

Ш.Шагдар Е.Батчуулун
Г.Юмчмаа Г.Уранчимэг Т.Навчаа

ГАЗАРЗҮЙ II

**11 жилийн сургалттай өрөнхий боловсролын
сургуулийн 8 дугаар ангид үзнэ**

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яамны
зөвшөөрлөөр хэвлэв



“МОНХИЙН УСЭГ” ХХК

Улаанбаатар
2006 он



Тодруулга



Бие дааж гүйцэтгэх ажил



Бид мэдэхийг хүснэ



Дүгнэлт



Шийдвэрлэх асуудал



“Бид юу сурсан бэ?”

Зохиогчид:

Ш.Шагдар (Доктор Sc.D, профессор, ардын багш)

Е.Батчуулун (Доктор Ph.D, дэд профессор)

Г.Юмчмаа (магистр)

Г.Уранчимэг (магистр)

Т.Навчaa (Доктор Ph.D)

Редактор:

Е.Батчуулун Ш.Шагдар

ГАЗАРЗҮЙ 8

11 жилийн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн 8 дугаар ангид үзнэ.

Зохиогчийн эрх © Монгол улсын ардын багш, шинжлэх ухааны доктор, профессор Ш.Шагдар, Доктор, дэд профессор Е.Батчуулун нарт хадгалагдана.

Бүтээлийг бүтнээр буюу хэсэгчлэн хувилах, нийтлэх, электрон системд оруулах болон бусад хэлбэрээр ашиглахыг хориглоно.

Дизайнер: Б.Очирсүрэн

Менежер: Г.Байгалмаа

Зураач: Д.Отгонбат

Эксперт хийсэн: Ч.Батням Н.Наранцэцэг Д.Сарантuya

Цаасны хэмжээ: 170x250

Хэвлэлийн хуудас: 15

“МӨНХИЙН ҮСЭГ” ХХК-д эхийг бэлтгэж, хэвлэв.

Улаанбаатар, 2006 он

ISBN 99929-6-380-8

ГАРЧИГ

ОРШИЛ

I.

ГАЗАРЗҮЙН ЕРӨНХИЙ ТОЙМ



| | |
|-----------------------------------------------|----|
| 1. Монгол орны байгалийн байдлын онцлог | 6 |
| 2. Газарзүйн байрлал | 7 |
| 3. Манай улсын цаг тоолол | 11 |

II.

ГАЗАРЗҮЙН СУДАЛГААНЫ ТҮҮХ



| | |
|-------------------------------------------|----|
| 4. Монголчуудын газарзүйн мэдлэг | 16 |
| 5. Эртний үеийн судалгаа | 18 |
| 6. 1921 оноос хойшхи үеийн судалгаа | 22 |
| 7. Ястан угсаатан | 24 |

III.

МОНГОЛ ОРНЫ ГАЗАРЗҮЙН ЗУРАГ



| | |
|------------------------------------------------|----|
| 8. Зурагзүйн ерөнхийлөл, зураглалын арга | 28 |
| 9. Монгол орны газарзүйн зургийн тусгаг | 29 |
| 10. Байрзүйн зураг | 32 |

IV.

МОНГОЛ ОРНЫ БАЙГАЛИЙН ЕРӨНХИЙ ТОЙМ



| | |
|----------------------------|----|
| 11. Газрын гадарга | 39 |
| 12. Геологийн хөгжил | 46 |
| 13. Ашигт малтмал | 51 |

V.

ҮҮР АМЬСГАЛЫН НӨӨЦ



| | |
|-------------------------------------------------------|----|
| 14. Үүр амьсгалд нөлөөлөх хүчин зүйлс | 58 |
| 15. Агаарын массын орчин урсгал | 61 |
| Цаг агаарын зураг | 66 |
| 16. Агаарын температурын хуваарилалт | 71 |
| 17. Агаарын даралтын хуваарилалт, салхины горим | 75 |
| 18. Хур тунадасны хуваарилалт | 78 |
| 19. Үүр амьсгалын нөөц | 82 |

VI.

МОНГОЛ ОРНЫ УСНЫ НӨӨЦ



| | |
|---------------------------------------------------------|-----|
| 20. Гол мөрөн | 90 |
| 21. Голын тэжээл, горим, гол мөрдийн ач холбогдол | 94 |
| 22. Нуур намаг | 95 |
| 23. Мөсөн гол, олон жилийн цэвдэг | 98 |
| 24. Газар доорхи ус, рашаан | 100 |

VII.

ХӨРС, УРГАМАЛ, АМЬТНЫ АЙМАГ



| | |
|---------------------------------|-----|
| 25. Хөрсөн бүрхэвч | 104 |
| 26. Ургамал, амьтны аймаг | 107 |

VIII.

БАЙГАЛИЙН БҮС, БҮСЛҮҮР



| | |
|--------------------------------|-----|
| 27. Байгалийн бүс | 112 |
| 28. Хээрийн бүс | 117 |
| 29. Говийн ба цөлийн бүс | 122 |
| 30. Өндрийн бүслүүр | 128 |

IX.

БАЙГАЛИЙН АШИГЛАЛТ ХАМГААЛАЛТ



| | |
|-------------------------------------------------------|-----|
| 31. Байгаль хамгаалал | 136 |
| 32. Тусгай хамгаалалтай газар нутгууд | 141 |
| 33. Монгол оронд аялал жуулчлал хөгжүүлэх боломж | 156 |
| 34. Экологийн тулгамдсан асуудлууд | 158 |
| Хавсралт | 162 |

Элэг зурхнээс уяатай
Энхрий Монгол нутаг минь
Эцэг эхээс заяатай
Эрдэнийн алтан өлгий минь

Ж.Бадраа

ГАЗАРЗҮЙН ЕРӨНХИЙ ТОЙМ

1

Гол агуулга

- Монгол орны байгалийн байдлын онцлог
- Газарзүйн байрлал
- Манай улсын цаг тоолол

Юу мэддэг болох вэ?

- Газарзүйн байрлалын тухай ойлголт
- Монгол орны газарзүйн байрлал, гадаргын ерөнхий төлөв, тэдгээрийн онцлогуудын тухай
- Дэлхийн цагийн бүсийн ялгаа, түүнийг манай орны нөхцөлд хэрхэн хэрэглэдэг тухай мэддэг болно

Юу чаддаг болох вэ?

- Монгол орны газарзүйн сэдэвчилсэн зургуудтай ажиллаж байгалийн үзэгдлийн учир шалтгааныг тайлбарлаж чаддаг болох
- Газарзүйн зураг ашиглан монгол орны захын цэгүүд, хилийн шугамын урт зэргийг тодорхойлж чаддаг болох
- Монгол орны газарзүйн байрлалын давуу, сул талыг байгалийн болон нийгмийн талаас нь тодорхойлж суралж
- Амьдарч буй нутаг орныхоо газарзүйн байрлалд байгалийн нөхцөл аж ахуйн зорилгын үүднээс үнэлэлт, дүгнэлт өгч сурна.

Мэдлэгээ хэрхэн хэрэглэх вэ?

- Газарзүйн байрлалын давуу тал, байгалийн нөхцөл, нөөц баялагийг ашиглан улс, аймаг, нутаг орноо хөгжүүлэх боломжийг судлах
- Дэлхийн цагийн бүсийн ялгааг мэдэж, амьдралдаа хэрэглэж сурна.

1. МОНГОЛ ОРНЫ БАЙГАЛИЙН БАЙДЛЫН ОНЦЛОГ

Өнө эртний түүхт Монгол орон Азийтийн төвд Дэлхийн хоёр том гүрэн БНХАУ, ОХУ-тай хиллэн оршино. Манай орон Азийтийн хойд хэсгийн Сибирийн их хөвч тайга, Төв Азийн их цөл хоёрын хооронд, энэ хоёрын бие биедээ шилжих яг тэр тортон зааг дээр, Далайн төвшнээс дээш их өндөрт, өндөр уулсаар хүрээлгэдэн далайгаас аль хол оршдог учраас байгалийн нөхцөл байдлын хувьд өвөрмөц онцлогтой болжээ.



Нутгийн хойд ба баруун хэсэгт ойтайга найгаж, мөнх цаст уулс сүндэрлэж, гол мөрөн шуугин урсаж, тунглагад уст нуур цэлэлзэн байхад зүүн хэсэгт зээр мянга, мянгаараа сүрэглэн цахилсан, дөрөө зурам өвс халиурсан хээр тал цэлийн, өмнөд хэсэгт ухааран шаргалтсан манхат элс, нөгөө хэсэгт давхарлан долгиолсон цав толгод үргэлжилж байх жишээтэй.

Дэлхийн бөмбөрцөг дээрхи алив нутаг орон сав (чулуулаг, ус, агаар), шим (ургамал, амьтан) гэсэн таван үндсэн хамбүрдлээс бүрддэг. Түүнээс гадна чулуулаг эвдэрч бутран ус, агаар, нар салхины нөлөөгөөр жижгэрч амьтан ургамлын үлдэгдэлтэй холилдон амьтай, амьгүй биетийн холимог болсон **хөрс** гэдэг онцгой бүтэцтэй хамбүрдэл бий болдог. Энэ хамбүрдлийн харилцан нөлөөлөлд оршин буй байгалийн байдлыг **газарзүйн орчин** гэж нэрлэдэг.

Газарзүйн орчин бүрдүүлэгч хамбүрдлийн харилцан үйлчлэлийн үр дүнд бий болох газрын гадаргын байдлаас, мөн уур амьсгал, ус, хөрс, ургамал, амьтны аймаг зэрэг нөхцөл байдлаас нь болоод газар газарт өөр өөр төрх байдал бий болно.

Өнөө үед хүний аж ахуйн үйл ажиллагааны нөлөөгөөр байгаль-газарзүйн орчин ихээхэн хувирч өөрчлөгдэж байна. Байгалийн унаган төрх байдлыг их өөрчлөхгүйгээр байгалийг ашиглах, хамгаалахын тулд байгаль орчин-газарзүйн орчныг сайн судлах хэрэгтэй юм. Хүн төрөлхтөн өөрөө байгалийн бүтээгдэхүүн, байгалийг шүтэж амьдардаг болохоор түүнийг ашиглахгүй байх аргагүй. Гагцхүү зөв зохистой ашиглахын тулд өөрийн аймаг, сумын газарзүйн нөхцөл байдлыг сайтар мэдэх хэрэгтэй бөгөөд

бидний үзэж байгаа энэ хичээлийн агуулга үүнд чиглэж байгаа. Нутгийн байдлаас үүдэн гарах онцлогийг судалдаг болон хүмүүсийн амьдрал, аж ахуйн өвөрмөц онцлогийг судалдаг газарзүйн салбар шинжлэх ухаанууд ч шинээр үүсч хөгжих байгаа болно.

Манай оронд газар эзэмших, хувьчлах ажил эхлэж байгаа, мал аж ахуй, газар тариалан, зам, барилга, уул уурхайн ажил гээд манай аж ахуйн бараг бүх салбар газарзүйн мэдлэг шаардах болж байна.

Бид энэ хичээлээр монгол орны уул, тал хээр,.gov, цөл нутгийн болон өөр өөрсдийн аймаг, хот, сум, нутгийн байгалийн нөхцлийг судалж зөв зохистой ашиглах арга замыг мэдэж, байгаль орчноо хамгаалах монгол ёс заншилд суралцаж, хууль дүрэмтэй танилцах болно.

“Эх орон сумаас эхэлнэ
Эх орны газарзүй
сумын газарзүйгээс эхэлнэ”

Монголын газарзүйн энэ хичээлийг үзэхдээ бид өмнөх ангиудад үзсэн байгаль шинжлэл, газарзүйн мэдлэг болон орон нутгийн тодорхой жишээ, баримтуудад тулгуурлах болно.



1. Газарзүйн орчинд сайн, муугаар нөлөөлж буй хүний ямар үйл ажиллагаа танай нутагт түгээмэл байдаг вэ?
2. Байгалия зохистой ашиглахын тул нутагтаа юу хиймээр байна гэж бодож байгаагаа ярилцаарай
3. Та бүхэн эх орныхоо юугаар илүү их баахархдаг вэ?

2. ГАЗАРЗҮЙН БАЙРЛАЛ

Газарзүйн байрлал. Монгол орон дэлхийн хойд хагасын Ази тивд өргөрөгийн дагуу сунаж байрласан 1564116 ам км нутагтай бөгөөд энэ нь дэлхийн хуурай газрын 1 гаруй хувийг эзэлнэ. Нутгийн хэмжээгээр дэлхийн 200 гаруй улсын дотор 17-р байрт орно.


Манай нутгийн хамгийн хойд захын цэг нь Хөвсгөл аймгийн нутгийн хойд захад х.ө 52° 09'-д орших Ихсоёны нуруун дахь **Монгол шарын даваа**, өмнө захын цэг нь Өмнөговь аймгийн нутгийн өмнө захад х.ө.41° 35'-д орших Орвог **Гашууны Бортолгой** юм. Хамгийн хойд захын цэгээс өмнө захын цэг хүртэл өргөргийн хувьд 10° 34' – ын зөрөөтэй юм. Үүнийг уртын зайн хэмжээгээр авч үзвэл 2392 км болно. Энэ уртрагт ОХУ, Хятад, Вьетнам, Бирм, Тайланд, Камбожи, Сингапур, Индонез зэрэг 10 гаруй орон оршдог.

Нутгийн хамгийн баруун цэг нь Баян-Өлгий аймгийн нутгийн баруун захад з.у. 87° 44' –д орших **Монгол Алтайн Мааньт** уул, хамгийн зүүн цэг нь Дорнод аймгийн зүүн захад з.у. 119° 56'-д орших **Соёлз уулын Модтой Хамар даваа** юм. Хамгийн баруун захын цэгээс зүүн захын цэг хүртэл уртрагийн хувьд 32° 12' - ын зөрөөтэй. Үүнийг уртын зайн хэмжээгээр авч үзвэл 2392 км болно. Энэ уртрагт ОХУ, Хятад, Вьетнам, Бирм, Тайланд, Камбожи, Сингапур, Индонез зэрэг 10 гаруй орон оршдог.

Х.Ө 45°-ын зэргэдөнгөрдөгньманай улсын нутаг дэлхийн хойд хагасын дунд хэрд оршдогийг харуулна.

Х.Ө. 45°-ын зэргэд нь дэлхийн хойд туйл, экватор хоёрын яг дундах шугам билээ.

Монгол орны нутгийн баруун хэсгээр (Өлгий хотын дундуур) з.у. 90°-ын голдож дайран гарна. Иймд манай нутаг дэлхийн зүүн хагасын төв дунд оршдог гэж хэлж болно.



1 дүгээр зураг. Манай орны газарзүйн солбицлал
байрлал


Манай орны өнөөгийн нутгийн газарзүйн төв цэг-хүйснь Өвөрхангай аймгийн Бүрд сумын нутагт х.е. $46^{\circ} 52'$, з.у. $103^{\circ} 50'$ -ын солбицлол орших Өвөрхөшөөтийн булаг* юм. Энэ цэг дээр нутгийнхан дурсгалын суварга босгосон байна.

Төв цэг нь урьд өмнө янз бүрийн хугацаанд Монголын нутгийн хүйс гэгдэж байсан Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумын Зүүнхайрхан уул,


Бүрд сум, Төв аймгийн Эрдэнэсант сумын нутгийн заагт орших Батхаан уул, Архангай аймгийн Хашаат сумын нутагт орших Номгон уул, Цагаанхайрхан уулуудын бараг төв, дунд оршиж байна.

Манай улсын газарзүйн байрлалын бас нэг онцлог бол далайгаасалс (1000-2000 км) хол, Евразийн эх газрын төв дунд оршдог, Дэлхийн далайд гарцгүй 38 орны нэг юм.

* (Ш.Шагдар. Өвөрхөшөөт-Монгол орны нутгийн хүйс. УБ. 2001. товхимол үз)



2 дугаар зураг. Монгол орны газарзүйн онцлог цэгүүд




3 дугаар зураг. а. Монгол орны төв цэгийг тодорхойлох нь



б. Хүйсийн хөшөө

Хил хязгаар. Манай улс ОХУ, БНХАУ-тай 8219 км газраар хиллэх бөгөөд манай турван улсын хилийн уулзвар цэг нь баруун талдаа Таванбогд уул, зүүн талдаа Тарвагандахын овоо юм. Энэ хоёрын хооронд урдуураа БНХАУ-тай 4673 км газраар, хойгуураа

ОХУ-тай 3546 км газраар хиллэнэ. ОХУ ба БНХАУ-тай хоёулантай нь хиллэдэг аймаг бол баруун талд Баян-Өлгий, зүүн талд Дорнод аймаг байдаг. Гадаад улстай хиллэж байгаа аймгуудын нутагт хилийн байнгын ба түр гарцууд бий.



4 дүгээр зураг. Монгол орон далайгаас алслагдсан байдал



1. Улсын нутгийн захын цэгүүд ба нутгийн хүйсийг зураг дээр олоорой.
2. Монгол, Орос, Хятад гурван улсын хилийн уулзвар Таванбогд, Тарвагандахын овооны газарзүйн солбицлыг зураг дээр хэмжиж гаргаарай.
3. Танай аймаг, сумын төв улсын нутгийн захын цэгүүдээс хэдий хэр зйтай оршиж байна? Зургаас хэмжиж масштабаар бодож олоорой.
4. Танай суурингаас дараахи газрууд хүртэл хэдэн км зйтай вэ? /Экватор, Хойд түйл, Анхны голдож, 180-р голдож/

3. МАНАЙ УЛСЫН ЦАГ ТООЛОЛ




Дэлхий тэнхлэгээ 24 цагт нэг удаа эргэхэд түүний гадарга дээрх цэг бүр нэг цагт 15° -ын шилжилт хийнэ ($360^{\circ}:24 = 15^{\circ}$). Энэ нь уртрагаар 15° -ын ялгаатай цэгүүд хугацааны хувьд 1 цагийн ялгаатай байна гэсэн үг юм. Харин уртрагийн нэг градус нь хугацааны 4 минутын зөрөөтэй (1 цаг ($60'$) : $15^{\circ}=4'$). Иймд хоёр цагийн хоорондох уртрагийн градусын зөрөөг $4'$ -өөр үржүүлбэл цагийн ялгаа минутаар гарна. Жишээ нь: Адилхан 48-р зэргэд дээр з.у. 92° -д оршдог Ховд хот, з.у. 107° -ын голдожид оршдог Улаанбаатар хот хоёр 15° -ын зөрөөтэй, нэг цагийн ялгаатай. Өөрөөр хэлбэл Улаанбаатарт нар мандаад 1 цаг болсны дараа Ховдод нар мандана.

Уртрагийн зайн нэг градус нь хугацааны 4 минутын ялгаатай байдаг болохоор Дэлхийн уртрагийн 360° нь тус бүрдээ 4 минутын ялгаатай (12 цаг 00 мин. 12 цаг 04 мин, 12 цаг 08 мин гэхчлэн) 360 өөр цагтай байхад хүрэх юм. Энэ нь амьдралд зохимжгүй билээ.

Иймд хоногт 360 янзын цагтай биш, 24 өөр цагтай байх цагийн бүсийг хэрэглэхээр олон улсын хэмжээнд хэлэлцэн тохирчээ. Дэлхийг ингэж бус болгосныг цагийн бүс гэдэг. Нэг цагийн бүс 15° -ын голдожийг хамарна.

Цагийн бүсийг Лондон хотыг дайрч буй анхдугаар голдожийг тэнхлэг болгосон 0 бүсээс (анхны голдоожоос баруун, зүүн тийшээ тус бүр 7.5° бүгд 15°) эхлэн зүүн тийш (нар буруу) тоолно. Цагийн бүсийн хилийг яг голдож дагуулан шулуунаар биш тэр голдожийн ойролцоо том гол мөрөн, улс, аймаг, мужийн хилийг дагуулан тогтоодог. Цагийн бүсийн хилийн хоёр талд өөр өөр цаг хэрэглэнэ.

Лондон хотоос 12 цагийн зөрөөтэй 180-р голдожийн орших 12 дахь бүсийн тэнхлэг орчмоор өнгөрөх шугамыг



5 дугаар зураг. Дэлхийн цагийн бүсийн ялгаа

өдөр солигдох шугам гэнэ. Энэ тухай өмнөх ангид үзснээ эргэн санаарай. Энэ шугам нь далай дээгүүр, хүн ам суурьшдаггүй нутгаар өнгөрнө. Шинэ өдрийг эндээс эхэлж тоолдог. Улаанбаатараас Японоор дамжин зүүн тийш Даваа гаригт Америк тив рүү онгоцоор аялахад өдөр солигдох шугамыг зүүн тийш огтлож гарсан учраас Америк тивд Ням гариг болж байх болно. Харин Америк тивээс энэ замаар мөн өдөр энэ шугамыг баруун тийш огтлон гарсан бол Мягмар гариг болгон цагаа

урагшлуулна.

Манай улс 1961 оноос дэлхийн бүсийн цагийг албан ёсоор авч хэрэглэсэн билээ.


Дэлхийн цагийн VI бүсэд Баян-Өлгий, Увс, Ховд, Завхан, Говь-Алтай аймгуудыг, VII бүсэд төвийн аймгуудыг, VIII бүсэнд Сүхбаатар, Дорнод аймгийг багтаахаар тогтжээ.

Манай Улаанбаатар хот Лондон хотоос 7 цаг 32 минутын зөрөөтэй учир VII бүсэд оршдог болно.

Өвөл, зуны туйлын өдөр үргэлжлэх хугацаа (өргөргөөр)



| | Өрөнхий | Хөмөнчийн орчоо өдөр (Бүсийн орчоо) VI.22 | Хөмөнчийн орчоо өдөр (Овогийн орчоо) XII.21 |
|----------------|-----------|----------------------------------------------|------------------------------------------------|
| Үзүүлэлт | 0° 20° | 12:00 13:13:00 мин | 12:00 10:47:00 мин |
| | 40° | 14:45:00 мин | 9:09:00 мин |
| Нээлтийн орчоо | 45° | 15:28:00 мин | 8:40:00 мин |
| Үзүүлэлт | 48° | 16:00:00 мин | 8:20:00 мин |
| Очигийн орчоо | 50° | 16:40:00 мин | 7:51:00 мин |
| | 60° | 18:30:00 мин | 5:30:00 мин |
| Орчмын орчоо | 66.5° | 24:00:00 | 0:00:00 |



6 дугаар зураг. Улаанбаатарт нартай байх хугацаа

1. Зуны туйлын өдөр
2. Хавар намрын тэнцлийн өдөр
3. Өвлийн туйлын өдөр

Нарны гэрэлтэй хугацааг илүү сайн ашиглах зорилгоор зарим улс цагаа бүсийн цагаас өөр өөр тогтоон тоолох явдал бий. Ингэж газарзүйн байрлалынхаа онцлогт тохируулан хэрэглэж байгаа цагийг **тогтоолт цаг** гэдэг.

Дэлхийн 100 орчим орны адилаар манайд тогтоолт цагийг хэрэглэж зүн

цагаа 1-ээр урагшуулж, өвөл 1-ээр ухрааж тоолдог билээ.

Манай орны нутаг дээр өргөргөөс шалтгаалан өдрийн үргэлжлэх хугацаа өөр өөр байдаг. Зундаа манай хойд хэсгийн нутагт өдөр нь өмнөд хэсгийн нутгийнхаас арай урт, харин өвөлдөө эсрэг байна.



- Соёлз уулын Модтой Хамар даваан дээр нар мандсанаас хойш хэдий хугацаа өнгөрсний дараа Таванбогдын Мааньт ууланд нар мандах вэ? (Хариуг Дадлагын номоос үз)
- Зундаа Улаанбаатарт өдөр нь Даланзадгадынхаас урт болдог, өвөлдөө богино болдгийн учрыг тайлбарлаж ярилцаарай. (Хариуг Дадлагын номоос үз)
- Танай суманд хамгийн урт, хамгийн богино өдөр шөнө хэдэн цаг, хэдэн минут үргэлжилдгийг ажиглаж тэмдэглэж аваарай.
- Маргааш танай сууринд нар хэдийд мандаж, хэдийд жаргаж, өдрийн урт хэдий хэр үргэлжлэхийг ажиглаж олоорой.
- Танай суурин Улаанбаатараас орон нутгийн цагаар хэдэн минутын зөрөөтэй вэ? Бусийн цагаар бол цагийн зөрөө бий юу?



- Манай орон дэлхийн зүүн хагаст, хойд өргөрөгт Ази тивийн төв хэсэгт оршдог.
- ОХУ, Хятад улстай хиллэнэ.
- Далайгаас алс хол оршдог, далайд гарцгүй орон.
- Дэлхийн цагийн VI, VII, VIII бүсэнд оршдог.



- Манай улсын нутаг дээр хамгийн урт үргэлжилдэг зэргэдийг олж хэмжээг нь бодож гаргаарай.
- Манай улсын нутаг дээр хамгийн урт үргэлжилдэг голдожийг олоорой.
- Танай аймаг, суманд нар мандаж байхад:
 - Соёлз уулын Модтой Хамарт нар мандаад хэдий хугацаа өнгөрч байх вэ?
 - Таванбогдын Мааньт ууланд нар мандах хүртэл хэдий хугацаа дутуу байх вэ?
- Мал аж ахуй, газар тариалан, зам барилга, уул уурхайн гэх мэт аж ахуйн салбаруудад газарзүйн мэдлэг ямар ач холбогдолтой вэ? Газарзүйн шинжлэх ухаан бидний амьдралд ямар хэрэг болох вэ? Энэ талаар жишээ гарган ярилцаарай.
- Байгалийн байдлын онцлог, төрх байдал гэж юу вэ? Бодлоо бичгээр илэрхийлээрэй.
- Манай орон нутаг дэвсгэрийн хэмжээгээр Дэлхийн улсуудын дотор 17-р байрт ордог. Манай ороос том нутагтай улс орнуудыг газрын зургаас үзэж баримжаалан хэмжээгээр нь дараалуулж бичээрэй.



ГАЗАРЗҮЙН СУДАЛГААНЫ ТҮҮХ

2

Гол агуулга

- Монголчуудын газарзүйн мэдлэг
- Эртний үеийн судалгаа
- 1921 оноос хойших үеийн судалгаа

Юу мэддэг болох вэ?

- Монгол орны газар нутгийн хэмжээ, түүхэн байдал, монголчуудын газарзүйн мэдлэгийн талаар
- Монголчууд газар усаа хэрхэн мэдэж нэрлэж байсан болон газарзүйн уламжлалт мэдлэг
- Монгол орныг судлаж ирсэн жишээн дээр тулгуурлан газарзүйн судалгааны онцлог, хамрах хүрээний талаар мэддэг болно

Юу чаддаг болох вэ?

- Монгол орны газарзүйн судалгааны үечлэлд тулгуурлан ижил төстэй харьцуулалт хийх арга барилд суралцах
- Газарзүйн судалгааны замнал аяллын маршрутыг уншиж чаддаг болно

Мэдлэгээ хэрхэн хэрэглэх вэ?

- Газарзүйн мэдлэгтээ тулгуурлан өөрсдийн аяллын зам маршрутаа зураг ашиглан урьдчилан гаргаж сурах
- Нутаг орныхоо газарзүйн онцлогийн талаар эссээ зохиож бичих, үүндээ газарзүйн шинжлэх ухааны хэлийг ашиглах чадвартай болно.

4.

МОНГОЛЧУУДЫН ГАЗАРЗҮЙН МЭДЛЭГ

Монголын ард түмэн нэн эртнээс мал аж ахуй эрхлэн бэлчээр, усны сайныг дагаж хол, ойр нүүсээр байхуйд бас жин тээж холыг зорьж явах, мал эрж, сураглаж хэсэж явах, ан гөрөө хийх, аян дайн хийж явах зэрэгтээ газар нутгаа гүнзгий сайн мэдсээр ирсэн удаан жилийн түүхтэй билээ.

Монголчууд газарзүйн хэр зэрэг мэдлэгтэй байсныг "Монголын нууц товчоо" бүрэн харуулна. Тэнд өнөөгийн манай нутаг дээр болон гадаад оронд байгаа 200 шахам газар усны нэр гардаг, эзэн Чингис хаан цэргүүддээ байлдан дагуулах газрыг зааж өгөхдөө: "Далайн хөвөөгөөр явж... Уланau мөрнийг огтлон Тоур голыг өгсөж, Хянганы давааг давж их Aураг оронд нийлэн иртугэй" (МНТ- 253) гэж газрын зураг харж байгаа юм шиг газрыг нэгд нэггүй нэрлэн зааж байсан нь Чингис хааны болон ерөөс тэр үеийн монголчуудын газарзүйн мэдлэг нэн сайн байсныг батлан харуулна.

Монголчууд XIII зуун гэхэд Байгал далай, Баргужиныг мэддэг байсан нь тэнд оросын жуулчдыг ирэхээс даруй 300 гаруй жилийн өмнө, Чингис хаан Инд мөрнийг гатлан 1226 онд Энэтхэгт очсон нь Васко-Да-Гаммыг Европоос далайгаар тэр нутагт очихоос 270 гаруй жилийн өмнө, Бат хааны цэрэг 1240 онд Төв Европод хүрсэн нь Европоос Плано Карпиног Монголд ирэхээс 6 жилийн өмнө, Марко-Полог Монголд ирэхээс 31 жилийн өмнө болсон хэрэг билээ (7 дугаар зургийг үзээрэй). Эртний Хүннүчүүд, Х зууны

үед киданчууд газрын зураг хэрэглэж байсан ба XVII-XIX зууны үед манайд хошуудын болон өртөө замын зургийг үйлдэн хэрэглэж байсан ажээ.

Юан улсын судрын 48-р дэвтэрт "... газрын ёсны тэмдэглэл буюу газрын хөрсний дүрэмт савыг хийсэн байдал гэвэл modoor дугариг бөмбөг үйлдэж 7%-ийг ус болгожээ. Түүний өмнө нь ногоон, үлдэх 3%-ийг газар шороо болгожээ. Түүний өнгө нь цагаан бөгөөд мөрөн гол, тэнгис далайн судсыг түүний дотор хэлхэлж тоолжээ" гэж 700 орчим жилийн өмнө бичиж байсан нь өнөөдөр бидний мэдэх дэлхийн гадаргын 70% нь ус, 30% нь хуурай газар гэж үздэг шинжлэх ухааны дүгнэлттэй тохирч байна.



Монголчуудын газар усандaa өгсөн нэрс газарзүйн мэдлэгийг нь бас илтгэн харуулна. Газар нутгаа **хэлбэр дурсээр нь Дөш, Холбоо, ургадаг ургамлаар нь Хиагт, Шарилжтай, амьдардаг амьтдаар нь Үнэгт, Тарвагатай, цаг уурын үзэгдлээр нь Сүүдэрт, Будант, ашигт малтмалаар нь Хөөт, Эрдэнэт, Чулуут, Оюут, олон цөөнөөр нь Гурвансайхан, Тавантолгой, Долоондаваа, том жижгээр нь Ихбогд, Багабогд, өнгө зусээр нь Харговь, Цагаан хошуу гэхчлэн онцлог байдлыг нь онож нэрлэсэн байдаг. Түүнээс гадна рашаан булаг зэрэг газар усны нэрсийг тухайн газар дээр нь хад чулуунд сийлэн тавих, нэр найрлага, ашиглах зориулалт зэргийг модонд сийлэн пайз болгон босгох зэрэг ажил хийдэг байжээ.**

* (С.Дамдинсүрэн, Ш.Шагдар. Монголын нууц товчооны газар ус. УБ., 2006. номыг олж үзээрэй.)



7 дугаар зураг. Монголын эрт цагийн түүхийн зураг (1926 онд Герман улсад хэвлүүлсэн цомгийн доторх зураг)

- Чингисийн дайлж авсан улс 1227 он
- Хубилай хааны дайлж авсан улс
- Хорезмын улс 1220 он
- Төмөр хааны эзэлсэн улс 1405 он
- Эдүгээ бүхий Монгол улс



8 дугаар зураг. Сэцэнхаан аймгийн Цэрэнвандуй Бавуудоржийн хошууны газрын зураг.

(Одоогийн Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын хавь нутаг)

Цүүгэл голын чулуун дээр сийлсэн хаяг

Түшээтхан аймгийн Зоригт вангийн буюу Гүнцэлцаевичд уулын хошууны нутаг Гүнцэлийн Цүүгэл булаг (одоогийн Төв аймгийн Эрдэнэсант сум).

5. ЭРТНИЙ ҮЕИЙН СУДАЛГАА


Хүннү улсын Атила хаан бүр V-зууны үед Баруун Европод Итали, Франц улсад хийсэн аян дайныг удирдаж явсан түүхтэй. Харин Монголын газар нутаг болон нүүдэлчин монголчуудын тухай мэдэх гэсэн гадаад улсуудын сонирхол XIII зууны эхэн үеэс ихэссэн юм.

Европоос анх XIII зууны дунд үед Монголд ирсэн Италийн жуулчин *Плано Карпино*, Францын лам *Вильгельм Рубрук* нар, монголын хүн ардын зан заншил, ахуй амьдрал, газар нутгийн байдлын талаар мэдээ баримт цуглуулан эмхэтгэн бичиж үлдээснийг өнөөдөр бид Монгол хэл дээрээ уншиж байна. Монголчуудын тухай мэдэх гэсэн хүслийн хажуугаар монголын

газар нутгийг ажиглаж тэмдэглэх явдал үргэлжилсээр байжээ.

Манай нутгийг ажиглан тэмдэглэсэн зүйл нь нутгийн газарзүйн онцлогийг бүрэн дүүрэн илрүүлж хараахан чадаагүй боловч монголын газар нутаг, байгалийн байдлын ерөнхий төрх байдлыг танин мэдэхэд хувь нэмэр, суурь дэвсгэр болсон юм.

Газарзүйн судалгааны зорилго, дайц XIX зууны II хагасаас эрс их болж иржээ. Энэ үед оросын жуулчид манай орны газар нутгийг шинжлэх ухааны үндэстэйгээр судлахын эх суuriйг тавьсан юм. Манай орон, Төв Азиар Оросын жуулчин *Н.М.Пржевальский* 1870-1883 онд 4 удаа аялжээ.



9 Монгол орны газар дурсийн зураг (1926 онд Герман улсад хөвтүүлсэн цомгийн доторх зураг)

Н.М.Пржевальский
“Монгол ба Тангадын орон” гэдэг номондоо манай орны газарзүйн талаар дэлгэрэнгүй бичжээ. Тэрбээр урьд өмнө шинжлэх ухаанд тэмдэглэгдээгүй байсан тахь, хавтгай болон зарим ургамал зэрэг олон зүйлийг олж мэдээлсэн юм. Түүнээс хойш тахийг Пржевальскийн адуу гэж нэрлэх болсон билээ.

1878-1879 онд Оросын жуулчин М.В. Певцов Монгол Алтай, Хангайн нурууны өвөр бэл говь нутгаар аялан судалж, уг нутгийн газрын зургийг зохиожээ.

1892 онд Оросын нэртэй геологич академич В.А.Обручев Хиагтаас Замын-Үүд орох замын дагуух нутгийн геологийн тогтоцыг судалж, Говийн геологийн тогтоц, гадаргын зохион байгуулалт, газарзүйн бусад онцлогийн талаар шинэ материал цуглуулжээ.

1870 1875 1880 1885 1890 1895

Іðіññúí æօօö÷èí Ñ.Í.їððàíèí
ïiäiëüí áàðóóí öýñýä ïiäië
Àëðàéí íóðóó Èõ íóððóóäüí
õîðäð, Äiâü íóðàä, Öýiâäíû
óððàð ðöýä õððä õððà òððä
ñóððàð ñððà ñððà ñððà ñððà

“Баруун хойд Монголын тодорхойлолт”, “Хятадын Тангад-Төвдийн хязгаар ба Төв Монгол” гэдэг зохиолууддаа бичжээ.

1899-1926 онуудад Оросын жуулчин П.К.Козлов Монгол орон Төв Азийг судалж Монгол Алтай, Говь-Алтай, Говь нутаг, Хэнтийн нуруу зэрэг газраар явж газрын гадарга, хөрс, ургамал амьтны аймгийг судлан бас археологийн шинжилгээ хийж

“Монгол орон ба Амдо”, “Монгол ба Кам” зэрэг ном бичжээ.

1905 оноос В.В. Сапожников Монгол Алтайн нуруунд судалгаа хийж Ховд, Эрчис голын сав газрын гадаргын зохион байгуулалт, эртний мөстлийн талаар дүгнэлт гаргажээ.

1903 онд Г.Е. Грумм-Грижимайло Монгол Алтайн нуруу, Хархираа уул, Увс нуур орчмоор байгалийн газарзүйн болон хүн судлал, угсаатны зүйн судалгаа явуулж

“Баруун Монгол ба Урианхайн хязгаар” гэсэн ном бичжээ.

1913-1914 онд М.А. Усов Хэнтийн нурууны геологийн зураг зохиосон.

1900 1905

1910

1915

1920

1902 онд В.А. Комаров Соёны нуруу, Хөвсгөлийн уулсын ургамлыг судлан Монгол орны ургамлын гарал үүслийг сонирхон ургамлын газарзүйн мужлалыг үйлдэж, эртний мөстөл, олон жилийн цэвдэг, Хөвсгөл нуурын гарал үүслийн талаар судалгаа хийжээ.

Финляндын иргэн И.Г.Гранэ 1906 Монгол Алтай, Хэнтийн уулсаар эртний мөстлөгийн ул мөрийг судалсан

Английн судлаач Дуглас Карруртерс 1910-1914 онуудад Төв Ази, баруун Монгол Хархираа, Түргэний уулс дахь орчин цагийн мөсөн голуудын тухай мэдээ баримтуудыг дурдсан.

“Үл мэдэгдэх Монгол орон” ном бичжээ.

Америкийн геологич Ч.Берки Ф.Моррис нар 1920-оод онд Монгол Алтайн нуруунд геологийн судалгаа явуулж манай оронд ажиглагдах буй тэгшрэлийн гадарга, тал газрыг өндрийн хязгаараар Хангайн, Говийн, Пан-Чауны тал газар гэж нэрлэжээ. Мөн дөрөвдөгчийн хурдсыг судалсан байна.

6. 1921 ОНООС ХОЙШХИ ҮЕИЙН СУДАЛГАА

1920-ийд оны үед Америк улсын геологич Р.Ч.Эндрюс тэргүүтэй шинжилгээний ажил манай говь нутагт ажиллаж, геологийн түүхийн судалгаа хийж үлэг гүрвэлийн яс зэрэг ихээхэн материалыг аваачсан ба Монгол орон дэлхийн хүний үүслийн анхны голомт хэмээн үзэж байв.

1921 онд манай Шинжлэх ухааны байгууллага-Судар бичгийн хүрээлэн байгуулагдаж улс орныхоо нутгийг өөрийн мэргэжилтнүүд судлах ажил эхлэж Оросын болон бусад улсын шинжлэх ухааны байгууллагатай хамтран олон талын судалгаа явуулж байсан, одоо ч олон улсын эрдэмтэдтэй хамтран судалсаар байна.

1921 оноос өмнө оросын болон бусад орны эрдэмтэд, жуулчдын хийсэн судалгааны дунд монгол орны газарзүйн тухай шинжлэх ухааны үндэстэй арвин их материал бий болсон бөгөөд эдгээр судалгааны дүгнэлт нь байгалийн төрх байдал, хам бурдэл болон бас хүн ам эдийн засгийн асуудлыг ч хамарч байжээ.

1920

1925

1930

1935

1923-онд Ховд голын сав газарт геологич И.П.Рачковский судалгаа явуулж улмаар 1925-1927, 1930-1933 онуудад И.П.Куплетский зэрэг геологичид монгол орны баруун хэсэг, Хэнтийн уулс, Говь нутагт геологи, ашигт малтмалын судалгаа хийжээ.

1923-1926 онуудад ургамал судлаач Н.В.Павлов Хангайн нуруу, Хөвсгөлийн улсын ургамлыг 1925-1926 онуудад хөрс судлач Б.Б.Полынов, ургамал судлаач И.М.Крашенников, Н.Н.Лебедев, амьтан судлаач А.Н.Формозов, А.Я.Тугаринов, 1929 онд Е.В.Козлова нар жигүүртэн, хөхтөн амьтдыг судалжээ.

1926 онд Герман улсад "Дэлхийн байдлыг үзүүлэн сургах атлас хэмээх зургийн дэвтэр" гэдэг цомог зураг хэвлүүлжээ. Энэ нь манай дунд сургуульд зориулсан анхны атлас төдийгүй өөрийн орны ба дэлхийн байдлыг үзүүлсэн манай анхны орчин үеийн атлас болох юм. Энэ атлас нь дэлхийн байдал, сарны явдлын зураг, Азийн зураг 2, Америкийн, Австралийн, Африкийн зураг гэж бүгд 16 өнгөт зураг бүхий 12 хуудастай үйгаржин монгол бичгээр бичсэн тайлбартай юм. (Энэ сурх бичигт гурван зураг нь орсон)

1930-аад онд Оросын мэргэжилтэн А.Д.Симуков-Монгол улсын газрын зураг зохиож "БНМАУ-ын газрын зургийн дэвтэр" гэдэг цомог хэвлүүлжээ. А.Д.Симуков 1930-1940 онуудад Монгол орны гадарга, бүх нутгийг хамран судалгаа явуулж газарзүйн хувьд Монгол орны нутгийг 12 мужид хуваасан. "Симуковын ногоон" хэмээн нэрлэгдэх болсон физик газарзүйн ханын зураг зохиосон. Газарзүйн атласууд зохион, "БНМАУ-ын газарзүйн нийтлэл" гэдэг өгүүлэл бичжээ.

1940-1945 онуудад Э.М.Мурзаев, И.Д.Беспалов, А.А.Юнатов, А.Г.Бянников нар олон жилийн турш Монгол орноор аялж хөрс, ургамал, амьтны аймгийг судалж олон ном бичжээ.

Э.М.Мурзаев 1940-1945 онуудад Хангайн нуруу, Монгол Алтай, Их нууруудын хотгор, Хөвсгөл, Дорнод Монголын тал, Халх гол, Хянганы нуруу Монгол орны физик газарзүйн онцлогуудад ерөнхийд нь шинжлэх ухааны тодорхойлолтыг өгөх эх материалыг цуглуулсан. Мөн физик газарзүйн 5 мужлалт хийж, байгалийн 4 бүсийг ялгасан."БНМАУ- физик газарзүйн тодорхойлолт" гэсэн ном бичжээ.

1940

1945

1950

1948-1949 онуудад ЗХУ-ын ШУА-ийн Палеонтологийн шинжилгээний анги манай ШУ-ны хүрээлэнгийн мэргэжилтнүүдтэй хамтран говь нутагт малтлага хийж дундад төрмөлийн эриний аварга үлэг гүрвэлийн яс олсон нь дэлхий дээрх амьдралын хөгжлийг судлахад чухал хэрэглэгдэхүүн болжээ.

Оросын геологич В.М.Синицин 1951 онд Монголын геологийн түүхэн хөгжлийг эрт, дунд, төрмөлийн эринээр тодорхойлсон "Төв Ази" гэсэн бүтээлдээ дурдажээ.

В.Соложненко, А.Тресков, Н.А.Флоренсов, В.А. Бобров нар 1957 онд Их бага Богд уул орчим судалгаа явуулж тэр орчмын тектоникийн хөдөлгөөний ул мөрийг тодорхойлсон

- 1946 онд байгуулагдсан Ус цаг уурын үндэсний албаны газар эх орны уур амьсгал, ус зүйг нарийвчлан судлахад ихээхэн үүрэг гүйцэтгэсээр ирсэн юм.
- 1949-1951 онд хамтарсан хөдөө аж ахуйн шинжилгээний анги тус орны бүх нутгаар судалгаа хийж, газарзүй, ус, хөрс, ургамлын талаар шинэ баримтуудыг олж цуглуулжээ.
- 1957-1958 онуудад усны шинжилгээний анги бүх аймагт ажиллаж гол мөрд, нуурыг судлаж, бэлчээр хадланг усжуулах боломжийг илрүүлжээ.
- 1961 онд ШУА, улмаар Газарзүйн, Цэвдэг судлалын, Биологийн (ургамал, амьтны), Геологийн, Хөдөө аж ахуйн хүрээлэнгүүд байгуулагдаж өөр өөрсдийн чиглэлээр Монгол орны байгаль газарзүйн байдлыг судалж иржээ.
- 1961-1964 онуудад атар газрын хөрс судлах ажлын явцад манай орны хөрсний онцлогуудыг танин мэдэхэд их ач холбогдолтой ихээхэн материал цуглуулжээ.

Монголын эрдэмтэд нутгаа судалсан нь. Манай эрдэмтэн мэргэжилтнүүд эх орноо судлахад

ихээхэн үүрэг гүйцэтгэсээр иржээ. Шинжлэх ухааны академийн академич Д.Цэвэгмид, Ш.Цэгмид, Б.Гунгаадаш, Т.Пунцаг, Ц.Хайдав, Д.Доржготов, Н.Өлзийхутаг, Б.Лувсанданзан, О.Төмөртогоо, Р.Барсболд, Д.Дашзэвэг, Ц.Даваажамц, О.Шагдарсүрэн, А.Дулмаа нар болон газарзүйч Н.Лонжид, О.Намнандорж нар Монгол орны газарзүй, геологийн тогтоц, хөрс, ургамал, амьтны аймаг, уур амьсгал, гадаргын ус, рашаан булгийг судалж олон ном бүтээл гаргасан билээ.

Төрийн шагналт эрдэмтэн геологич Б.Лувсанданзан ОХУ-ын эрдэмтэдтэй хамтарч “боржин чулуунд шинэ эрдэс бүрэлдэх зүй тогтолыг” нээсэн нь манай геологи газарзүйн төдийгүй улсын хэмжээний шинжлэх ухааны анхны нээлт болсон юм.

Газарзүйч эрдэмтдээс академич Ш.Цэгмид, доктор Н.Лонжид нар Монгол улсын Төрийн шагнал хүртсэн билээ.

Мөн манай биологич эрдэмтэд шинэ зүйлийн амьтан ургамал олныг олж илрүүлэн байгаль судлаач эрдэмтэд олон газрыг улсын тусгай хамгаалалтад авах үндэслэл гаргаж байна.

7. ЯСТАН УГСААТАН

Угсаатан нь нутаг дэвсгэр, эрхлэх аж ахуй, хэл, соёлын нийтлэг чанартай гарал угсаагаараа нэгэн овгоос улбаалсан гол шинжтэй байдаг.

Ястан гэдэг нь аймгууд үүссэний дараа үндэстэн бий болохоос өмнө түүхэн ёсоор бүрэлдэн тогтдог хүмүүсийн хэл, газар нутаг, эдийн засаг, соёлын нийтлэг шинжтэй хүмүүс юм.

Манай улсад Халх үндэстэн хүн амын (95% орчим хувь) олонхийг эзлэх 2 сая орчим хүн аж амьдарч байна. Казах үндэстэн хүн амын 4 гаруй хувь буюу 100 мянга гаруй хүн ам нь голдуу Баян-Өлгий аймагт оршин суудаг.

Монгол үндэстэнд хамарагдах 20-иод ястан бий. Дөрвөд* ястан 67 мян орчим хүн, Баяд ястан 50 мян орчим

* Бүх тоог 2000 оны хүн амын тооллогын мэдээгээр авав.



АКАДЕМИЧ Ш.ЦЭГМИД (1922-2004)

Газарзүйн шинжлэх ухааны доктор, профессор, академич Ш.Цэгмид 1922 хотод Улаанбаатар хотод төрсөн. Нийслэл хотод байсан анхны орос сургуулийн 8 дугаар ангийг дүүргэн Сангийн Яам, Архин завод зэрэг газар хэмлэрч орчуулагч хийж байгаад 1941 онд Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн газарзүйн тасагт Оросын нээрт газарзүйч Э.М. Мурзаевыг дагалдан Баруун Монголын нутгаар хээрийн судалгаа хийхэд оролцсон нь түүний газарзүйч болох анхны гарaa байсан юм.




Дэлхийн хоёрдугаар дайны үед (1942-1947 онд) Москвагийн Их сургуулийн газарзүйн ангийг төгсөн аспирантурт дэвшин суралцаж, 1951 онд газарзүйн ухааны дэд докторын зэргийг хамгаалсан нь гадаад оронд докторын зэрэг хамгаалсан Монголын анхны эрдэмтдийн нэг болсон юм. 1962 онд газарзүйн шинжлэх ухааны докторын зэргийг хамгаалжээ.

Монгол орны физик газарзүйг анхлан судалсан үндэсний мэргэжилтний нэг болох Ш.Цэгмид физик газарзүйн шинжлэх ухааны салбарт геоморфологи, эртний газарзүй, ландшафт судалалын чиглэлээр голлон ажиллаж, Монголын Шинжлэх ухааны академийн жинхэнэ гишүүн, ЗХУ-ын (хуучнаар) Газарзүйн нийгэмлэгийн гадаадын хүндэт гишүүн байснаас гадна боловсролын салбарт ч үнэтэй хувь нэмэр оруулсан билээ. Тухайлбал, 1956 онд нээн эрхлэгчээр нь ажиллаж байсан МУИС-ийн газарзүйн салбар нь эдүгээ 50 жилийн хугацаанд олон арван газарзүйчийг бэлтгэн гаргаад байна.

Монголд анхны сургууль байгуулагдсан үеэс эхлэн гадаадын сурах бичгүүдийг орчуулан хэрэглэж байсан тэр үед Ш.Цэгмид багш дунд сургуулийн 7 дугаар ангид үзэх “Монгол орны газарзүй” (1957 он) сурах бичгийг зохиосон нь үндэсний анхны сурах бичиг болсон юм. Энэ сурах бичиг нийт 7 удаа давтан хэвлэгдэж, 1984 онд БНМАУ-ын төрийн шагнал хүртсэн нь дунд сургуулийн сурах бичгүүдийн хувьд анхдагч нь болсон юм. Түүнчлэн “Хэнтийн уулархаг орны физик газарзүй ба эртний мөсдлийн тодорхойлолт”, “Монгол орны дорнод хэсгийн ландшафт, байгалийн муужууд”, “Монгол орны физик газарзүй” (1968) зэрэг томоохон бүтээлүүд түүрвиснаас гадна физик газарзүйн онолын чиглэлтэй бүтээлүүд нь орос монгол хэл дээр олноор хэвлэгдсэн билээ. Академич Ш.Цэгмид Хэнтийн уулсын физик газарзүйн онцлог, эртний мөсдлийг судалж, энэхүү уулст өндөрлөгийн оройн хэсэгт олон жилийн цэвдгийн нөлөөгөөр сэвсгэр чулуулаг гулсах үзэгдэл дөрөвдөгч галавын үед нэлээд түгээмэл байсан ба Хэнтийн нуруунд нэг удаагийн мөстлөг болсон гэж дүгнэлт гаргасан юм. Мөн эртний газарзүйн судалгаа хийж Орог нуур дөрөвдөгч галавт хойшоо ихээхэн тэлж хөндийгөө бараг дүүргэж байсныг тогтоожээ. Монголын газарзүйн шинжлэх ухаанд түүний оруулсан томоохон хувь нэмрийн нэг бол монгол орны физик газарзүйн анхны 3 шатлалт мужлалыг үйлдсэн явдал юм. Монгол орныг 1) Хангай Хэнтийн уулархаг их муж, 2) Алтайн уулархаг их муж, 3) Монголын дорнод талын их муж, 4) Говийн их муж гэсэн 4 их мужийн хүрээнд 11 муж, 27 тойрог ялгасан нь одоо ч хэрэглэгдэж байна.

нь Увс аймагт, Буриад ястан 40 гаруй мянган хүн ам Дорнод, Хэнтий, Төв, Хөвсгөл, Сэлэнгэ аймагт, Дарьганга ястан Сүхбаатар аймагт 32 гаруй мянга, Захчин ястан 30 шахам мянган хүн Ховд аймагт, Urianhay ястан 30 шахам мянган хүн Ховд аймагт, Дархад ястан 20 шахам мянган хүн Хөвсгөл аймагт,Өөлд ястан 20 шахам мянган хүн Ховд аймагт, Торгууд ястан 10 гаруй мянган хүн Ховд аймагт, Хотон ястан 10 мян орчим хүн Увс аймагт, Хотгойд ястан

10 мянга орчим хүн Хөвсгөл аймагт, Мянгад ястан 7 мянга орчим хүн Ховд аймагт, Тува ястан 5 мянга орчим хүн Баян-Өлгий, Ховд аймагт амьдардаг, мөн Барга, Үзэмчин ястан Дорнод, Сүхбаатар аймагт амьдардаг. Цаатан, Сартуул, Чантуу, Халимаг хүмүүс зарим аймагт амьдардаг. Түүнчлэн Орос, Хятад зэрэг үндэстэн Улаанбаатар, Сэлэнгэ аймагт бүгд 8 мянга орчим хүн буюу улсын хүн амын 0,3 хувь орчмыг эзлэн амьдарч байна.



10 дугаар зураг. Монгол орны ястан угсаатны байршил



1. Аймаг сумынхаа нутгаар ямар ямар жуулчид, эрдэмтэд явж, ямар чиглэлийн судалгаа хийж байсан талаар материал цуглуулж ярилцаарай.
2. Гадаадын болон дотоодын аялагч жуулчид танай нутагт ирдэгийн учир нь юу вэ? Энэ талаар эсээ бичээрэй.
3. Монголын үндэстэн ястнуудын үлгэр домог, дуу, шүлэг, магтаалын талаар цуглуулга хийцгээ.
4. Монгол орны үндэстэн ястны тоогоор диаграмм байгуулж, дүгнэлт өгч ярилцаарай.



Гол агуулга

- Газарзүйн зураг, түүний үндсэн шинж чанар, масштаб
- Зурагзүйн ерөнхийлөл
- Гадаргын хэлбэрийг зурагт дүрслэх нь
- Зурагзүйн тусгаг
- Монгол орны газрын зургийн тусгаг
- Байрзүйн зураг

3

Юу мэддэг болох вэ?

- Монгол орны газрын зургийн онцлог, хэрэглэх тусгагын талаар
- Байрзүйн зураг, түүний үндсэн шинж болон монгол орны байрзүйн зургийг дүрслэх тухай
- Зургийн масштаб, ерөнхийлөл зураглалын аргуудын талаар мэддэг болно.

Юу чаддаг болох вэ?

- Газрын зургийн таних тэмдэг, масштаб ашиглан зураг уншиж сурх
- Байрзүйн зураг дээр солбицол тодорхойлох, хэмжилт хийж сурх
- Бэлэн мэдээлэл тоон үзүүлэлт ашиглан хялбар газарзүйн зураг зохиож чаддаг болох
- Газрын зураг ашиглан хэрэгтэй мэдээллээ олж авах дүгнэлт хийх арга барил эзэмшинэ.

Мэдлэгээ хэрхэн хэрэглэх вэ?

- Нутаг орныхоо гадаргын төлвийг том масштабтай байрзүйн зургаар тоймлон дурсэлж үзүүлэх
- Тухайн газар орны байрзүйн зураг ашиглан гадаргын онцлогийг тодорхойлдог болох чадвар эзэмшинэ.

8.

ЗУРАГЗҮЙН ЕРӨНХИЙЛӨЛ, ЗУРАГЛАЛЫН АРГА

Газарзүйн зураг нь газарзүйн шинжлэх ухааны болон газарзүйн хичээлийн хувьд үзүүлэн таниулах зүйл төдий бус судалгааны зүйл, танин мэдэхүйн чухал хэрэгсэл нь болдог юм. Газарзүйн зураг зохиох, хэвлэх, ашиглах аргазүйн шинжлэх ухааныг **Зурагзүй /картографи/** гэж нэрлэдэг.

Зураг дээр газарзүйн биет юмсыг хэр зэрэг тодорхой буюу тойм төдий зурах нь ямар хэмжээтэй масштаб хэрэглэхээс шалтгаална. Ямар ч том масштабтай зураг байлаа гэсэн газар дээрх юмыг нэгд нэггүй бүрэн зурж үзүүлэх боломж байхгүй.

Жишээлбэл: 2,5 км урт булаг буюу ганга 1:2 500 000 масштабтай зураг дээр 1 мм урт зурагдах ёстой. Ер нь аливаа зураг дээр масштаб ёсоор нь хураангуйлахад 1 см-ээс богино зурагдах гол мөрөн зэрэг зүйлсийг зурахгүй орхидог.

Үүнээс ямар дүгнэлт гаргаж болох вэ? Масштаб нь жижигрэх тутам зураг дээр үзүүлэх зүйлийн тоо цөөрнө. Ингэж зураг дээр үзүүлэх зүйлсийг агуулгадаа болон масштабтаа тохируулан сонгогчыг зурагзүйн ерөнхийлөл гэнэ.

1: 1 500 000 масштабтай зургийн 1 мм зайд нь газар дээрээ 1,5 км газрыг төлөөлнө. Тэгэхээр ийм хэмжээний зайд буй газрын онцлог нь уг зураг дээр тусгагдахгүй (өртөхгүй) гэсэн үг. Харин зургийн масштабыг 1:150 000 болгон томсговол 1,5 км нь 1 см урт зурагдана.

Зургийн дурслэлийн таних тэмдэг нь олон. **Шугаман** тэмдгээр гол мөрөн, зам, хилийн уртыг үзүүлнэ.

Тайлбарын таних тэмдгээр өнгө, тоо хэмжээ, дүрсийг үзүүлнэ. Жишээ

нь: устай холбоотой (гүн, өргөн, хурд, орших өндөр зэрэг) тоо хэмжээг хөх цэнхэр өнгөөр, газрын гадаргатай холбоотой (хаялбар шугамын ба эрэг гангын өргөн, урт, гүн зэрэг) тоо хэмжээг бор шар өнгөөр тэмдэглэнэ.

Том масштабын “зураг дээр” навчт ой, шилмүүст ой гэхчлэн модны дүрс зурж ой модны төрлийг ялгах, ногоон өнгөөр зурах, голын урсгалын чиглэлийг цэнхэр сумаар үзүүлэх зэрэг нь тайлбарын таних тэмдэг юм.

Таних тэмдэг нь масштабтай тохирч байх, тохирохгүй байх ч бий. Жишээ нь: 1: 1 500 000 масштабтай зурагт төмөр замыг 1 мм өргөн тэмдэглэсэн байвал зургийн масштабаар хөөж бодвол газар дээрээ 1,5 км өргөн зам байх нь. Ийм өргөн зам байхгүй шүү дээ. Гол мөрөн, зам, төмөр замын уртыг зургийн масштабаар хөөж бодон олж болдог бол өргөнийг нь бодох боломжгүй. Масштабаар нь хэмжээг олж болохгүй ийм тэмдгийг **масштабын биш тэмдэг** гэдэг.

Газарзүйн сэдэвчилсэн зурагт дурслэлийн төрөл бүрийн арга хэрэглэнэ. Заримаас нь дурдья.

Өнгөт дэвсгэрийн арга. Хөрс ургамал зэргийг төрөл төрлөөр нь ялан өөр өөр дэвсгэр өнгөөр зурдаг.

Ижил шугамын арга. Аливаа үзэгдэл юмын тоо хэмжээний адил утгатай цэгүүдийг шугамаар/зураасаар/холбон үзүүлдэг.

Хөдөлгөөний шугамын арга. Голын урсгалын чиглэлийг цэнхэр сумаар үзүүлдэг шиг төмөр зам, авто зам, усан замуудын ачаа тээвэрлэх чиглэл, салхи, агаарын фронтын шил-

жилт, шувууны нүүдэл гэхчлэн аливаа хөдөлгөөний чиглэлийг үзүүлдэг.

Ингэхдээ сумны өнгө нь төрлийг, сумны өргөн нарийн нь түүний тоо

хэмжээг үзүүлнэ. Жишээ нь: Далайн хүйтэн урсгалыг цэнхэр сумаар, дулаан урсгалыг улаан сумаар дүрсэлдэг билээ.



1. Янз бүрийн зургийн таних тэмдгүүдийг ажиглаж, ямар зүйлийг хэрхэн тэмдэглэсэн, аль нь масштабын биш тэмдэг болохыг ялгаж ярилцаарай.
2. 1:150000 масштабтай зураг дээрх 1 ам см талбай нь газар дээрээ хэдий хэмжээний талбайтай газрыг төлөөлөх вэ?

9.

МОНГОЛ ОРНЫ ГАЗАРЗҮЙН ЗУРГИЙН ТУСГАГ

Орос, Хятад, АНУ, Канад, Монгол зэрэг өргөргийн дагуу сунаж тогтсон нутагтай орнуудын зургийг **конус тусгагаар зурах** нь тохиромжтой байдаг.

Монгол орны газарзүйн ихэнх зургийг **тэнцүү өнцөгт, огтолсон, жирийн конус** тусгагаар зурдаг.

Эдгээрийн онцлог юу вэ?

a/ **Тэнцүү өнцөгт**-газар нутгийн хэлбэр дүрс зөв, хэмжээ нь гажиж зурагдана

b/ **Огтолсон** –бөмбөрцгийг конусын хажуугаар огтуулж зурна.

Монгол орны ихэнх зургийг

х.ө. 45° , х.ө. 49° -ын зэргэдээр огтуулж зурдаг. (12 дугаар зургийг үз)

в/ **Жирийн конусын тэнхлэг** нь бөмбөрцгийн тэнхлэгтэй давхацсан шулуун байна.


Харин манай Үндэсний атласын зургийг х.ө. 42° ба 52° -ын зэргэдээр огтолсон тэнцүү хэмжээт тусгагаар зурсан байдаг.

Монгол орны зургийн огтолсон хоёр зэргэд (х.ө. 45° , х.ө. 49° буюу х.ө. 42° , х.ө. 52°)-ийн дагуу гажилт байхгүй. Иймд уг зэргэдүүд дээр хэмжсэн зай нь масштабаар нь бодоход газар дээрх үнэн хэмжээтэй адил гэсэн үг.




Бидний хэрэглэдэг зарим зургийн нэр, түүний тусгагууд;

Тал бөмбөрцгийн зураг - хөндлөн азимут, Дэлхийн улс төрийн ба байгалийн зураг - олон конуст, Дэлхийн цагийн бүсийн зураг - цилиндр, Арктик, Антарктидийн зураг - туйлын азимут тусгаг.




11 дүгээр зураг. Хөндлөн азимут тусгагаар зурсан тал бөмбөрцгийн зураг (1926 онд Германд хэвлүүлсэн цомогт буй)



12 дугаар зураг. Огтолсон конус тусгагаар зураглах нь

Манай улсын нутаг дээрх уртрагийн нэг градусын өнцөгт талах зэргэдийн нумын урт

| Зүрхийн шоёрдлын нэгжийн урт (бийнээд) | 1 шоёрд шоёрдийн нэгжийн урт (бийнээд) |
|-------------------------------------------------|----------------------------------------------|
| 40 | 85.4 |
| 41 | 84.1 |
| 42 | 82.9 |
| 43 | 81.5 |
| 44 | 80.2 |
| 45 | 78.8 |
| 46 | 77.5 |
| 47 | 76.1 |
| 48 | 74.6 |
| 49 | 73.2 |
| 50 | 71.7 |
| 51 | 70.2 |
| 52 | 68.7 |



13 дугаар зураг. Огтолсон конус тусгагаар Монгол орныг үзүүлэх нь (х.ө 45° ба 49°-ын дагуу гажилтгүй зурагджээ)



1. Монголын 1:1500 000 ын зураг дээр х.ө 51°-ын дагуу, з.у. 98°-102°-ын хоорондох зайд масштабтайгаа тохирч байгаа эсэхийг хэмжин бодож үзээд 28-р хуудсан дахь хүснэгтийг ашиглан шалгаарай.
2. Монголын зураг дээр х.ө. 45° ба 49°-ын зэргэдийн хоорондох голдожийн 4°-ын хөвч нь үнэн хэмжээтэй нь харьцуулбал богино зурагдана. 12 дугаар зургийн хөвч, нум хоёрыг ажиглаж шалгаарай.

10. БАЙРЗҮЙН ЗУРАГ

Газар нутгийн байдлыг тодорхой үзүүлэхийн тулд олон хуудас болгон, том масштабаар зурсан зургийг **байрзүйн** (топографийн) **зураг** гэнэ.

1:1000000-ын зураг нь байрзүйн зургийн суурь юм. Дэлхийн бөмбөрцгийн гадаргыг голдож дагуулан 6°-ын босоо бүсэд хувааж түүнийг 180-р голдооос эхлэн нар буруу чиглэлээр 1-60 хүртэлх дэс тоогоор дугаарлана. Үүнийг **багана** гэнэ. Харин хөндлөнгөөр нь зэргэд дагуулан 4°-ын зйтай 22 эгнээ болгон хувааж эгнээгээ экватораас эхлэн /A.B.C....M гэхчлэн/ латин үсгээр нэрлэнэ.


Ингэхэд зураг дээр уртрагийн хувьд 6°, өргөргийн хувьд 4°-ын хэмжээтэй /трапец хэлбэрийн хуудсууд үүснэ. Харин 88-р зэргэдээс хойших туйл орчмын 2°-ын радиустай тойргийг Z үсгээр тэмдэглэдэг. /14-р зургийг үз/ Тэдгээр хуудсыг дээрхи үсэг тоогоор нь L-48 гэхчлэн хаяглахыг **байрзүйн зургийн нэрлэл** гэнэ.

Монгол орны нутаг саятын масштабын байрзүйн зурагт 45-50 гэсэн 6 багана, K,L,M,N гэсэн 4 эгнээнд орших 14 хуудсанд зурагдаг юм.


Саятын зургийг 1:100 000 зураг болгон дэлгэрэнгүй зурья гэвэл L-48 гэхчлэн нэрлэлтэй хуудас бүрийг өргөргийн дагуу 20 минут, уртрагийн дагуу 30 минутын хэмжээ бүхий 144 хуудас болгон хувааж L-48-39 гэхчлэн хаяглан нэрлэнэ.

Өөрөөр хэлбэл зургийн масштабыг цааш нь улам томсгон зурья гэвэл тэр хуудсаа бас 4 хуваах гэхчлэн цааш нь хувааж бас болно. Үүнийг 15-р зургаас үзээрэй. Үүнээс илүү том масштабын зураг зохиохын тулд уг хуудсаа голдож, зэргэд шугамыг дагуулан дахин хуваана. Жишээлбэл, 1:500000 масштабтай зургийн нэг хуудас нь уртрагийн дагуу 3°, өргөргийн дагуу 2°-ын хэмжээний газрыг хамарна.

1:1000000 масштабын нэг хуудас зурагт 1:100000 масштабын зургийн 144 хуудас багтана. 1:25000 масштаб бүхий зураг уртрагийн дагуу 7'30'' өргөргийн дагуу, 5'-ын хэмжээтэй газрыг хамарна. Иймд байрзүйн зургийн бүх хуудсууд трапец хэлбэрийн хүрээтэй байна. Энэ хүрээний умард, өмнөд тал нь зэргэд шугамууд, баруун, зүүн тал нь голдож шугам юм.




14 дүгээр зураг. Дэлхийн гадаргыг 1:1000000 масштабтай байрзүйн зурагт дүрслэх нь




15 дугаар зураг. Монгол орны 1:1000000 масштабтай байрзүйн зургийн хуудасны хуваалт ба нэрлэл

L - 48 - 39



1 : 100000
i à ñ ø ò à á ò à é
áàééðçéí çóðääééí
íýä öööäñüä 144
öýñýäö ööåäàåäë íýä
öööäàñíú iàñøòäà
íü 1:100000 áïëí.


L - 48 - 39 - A



Масштаб 1:50000

А-Г ТЭМДЭГЛЭВ

L - 48 - 39 - A - a



Масштаб 1: 25000

а-Г ТЭМДЭГЛЭВ

16 дугаар зураг.

1:1000000 масштабтай байрзүйн зургийг том масштабтай болгон зурах байдал






- Дэлхийн байдлыг цаасан дээр хураангуйлан зургаар үзүүлдэг
- Ерөнхийлж, бас олон янзын таних тэмдэг хэрэглэдэг
- Тохирох тусгаг хэрэглэн алдаа багатай зурахыг боддог
- Тодорхой үзүүлэхийн тулд дэлхий нийтээр хэлэлцэн тохирсон байрзүйн олон хуудаст зураг болгон зурдаг.
- Байрзүйн зургийн эгнээ баганыг үзүүлсэн үсэг ба тоог нэрлэл гэнэ.
- Байрзүйн зургийн масштаб олон янз байдаг.



1. Монгол орны нутгийн төв цэгийн байрзүйн зургийн нэрлэлийг бичээрэй.
2. Ховд аймгийн Чандмань сумын нутагт хөөмийчдийн концерт үзэхээр явлаа гэж бодвол чи ямар ямар газрын зураг ашиглан тэр аймгийн талаар мэдээлэл авах вэ? Тоочиж бичээрэй.
3. L - 48 - 10 - B - зургийн 4 талд залгагдах хуудсыг олоорой. 35-р хуудасны зургийг ашигла.
4. Газрын хотгор гүдгэрийг хаяалбараар үзүүлдэг, хаяалбар шугам нь олон ойр ойр байвал газар нь их өндөр, эгц байна гэсэн үг. Монгол орны том масштабын зургийг ажиглан дараах асуултанд хариул.
 - Хархориноос Улаанбаатар хүртэл нэгэн өнгөөр зурагджээ. Үүнд газрын гадаргын талаар ямар дүгнэлт өгч байна вэ?
 - K-48 гэсэн хуудсанд ямар хот оршихыг зурагт олж заа. 15-р зурагт үз.
 - Монгол шарын даваанаас урагш гадаргын байдалд дүгнэлт өгч ярилц. Хаанаа өндөр, хаанаа хотгор хөндийнүүдтэй байна вэ?
 - Хэрвээ чи Хатгалаас Хархорин хүртэл явах болбол ямар ямар голыг хөндлөн гарах вэ? Ямар зам сонгохоо зурагт зааж тайлбарла.
5. Монгол орны захын цэгүүдийн солбицолыг олоорой.
6. Дараах зургаас L-48-69, L-48-133-Г-а, L-48-24-Б хуудсыг олж тэмдэглэж газрын зурагт заа.
7. Янз бүрийн газрын зургуудыг тусгаг, гажилт, зураглалын арга зэргээр нь ялгаж ярилц.
8. Сумынхаа газарзүйн солбицлыг тодорхойлоод байрзүйн зургийн 1:100000, 1:50000 масштабтай нэрлэлийг бичээрэй.
9. 15-р зургийг ашиглан L-48 нэрлэлтэй хуудсанд зурагдсан аймгуудыг нэрлэ! Энэ хуудсанд багтсан нутгийн талбайг ол.
10. Х.Ө 46°41'; З.Ү 113°17'-ын солбицолд орших Баруун-Урт хот, Х.Ө 49°59' 3.Ү 92°04'-ын солбицолд орших Улаангом хотуудын 1:100000 зургийн хуудасны нэрлэлийг зураад бодож ол!

L48-5 Бая





Газрын налуу усан руу, хаяалбар шугам дээрх тооны дээд тал нь газрын өндөрлөг хэсэг рүү хандана. Байрзүйн зургийн хүрээ нь газарзүйн зургийнхаас ялгаатай хэд хэдэн хэсгээс бүрдэнэ. 17-р зургийг ажиглая. Зургийн гадна талын хүрээ нь өргөн нарийн хос зураас байна. Түүний дотор цэгүүдийн хооронд 10 секундын зйтай. Бүр дотор талын хүрээн дээр 4 захын газарзүйн солбилцол ба километрийн тоог тэмдэглэжээ. Тухайлбал энэ зурагт Х.Ө-47°57'00"-ээс Х.Ө-47°59'30"-ийн хоорондох (2°30'), З.Ү-104°15'00"-ээс З.Ү-104°18'00"-ийн хоорондох газар (3°00') зурагджээ. Хөндлөн шугамд байгаа 5314, 15, 16 зэрэг тоонууд нь экватороос тухайн шугам хүртэлх зайд (км-ийн шугам 5315, 5316, 5317 км), босоо шугамд буй 64, 65, 18466 гэсэн тоо нь 18-р багананд тэнхлэг голдоос 466 км зйтайгаар оршихыг заана. Энэ шугам тэнхлэг голдоос зүүн тийш байвал 500-аас их (534, 535), баруун тийш бол 500-аас дутуу (464, 466) байна. Жишээ нь: 464 гэдэг нь (500-464=36) тэнхлэг голдоос баруун тийш 36 км зйтай орших км-ийн шугам гэсэн үг.



- 1. Сэхүүлийн голын аль гарын эрэг нь эгц, аль эрэг нь налуу хажуутай байгааг ажиглаж олоорой.
- 2. Сэхүүлийн ба Сөртийн голын усны хагалбарыг ажиглаж харандаагар бүдэг зураарай.
- 3. Заг голын өргөнийг 14-р км-ын шугамын дагуу хэмжиж рой.
- 4. Сэхүүлийн голын уртыг хэмжиж олоорой.
- 5. Энэ зураг дээр А цэгээс Б цэг хүртэл шулууны дагуу өндөр намын зүслэл хийгээрэй.
- 6. Тариа тарья гэвэл гадаргын хэлбэрийн хувьд хаана, хэдий хэмжээний талбайд тарьж болохоор байна? Олоорой.
- 7. Баян суурингаас 188.0 тоот өндөрлөгт 2°-ын хэвгийтэй зам тавих газрыг хэмжиж олоорой.
- 8. 65-66-р км-ын босоо шугамын хооронд 15-р км-ын хөндлөн шугамын дагуу газрын дундаж хэвгийг тодорхойлно уу.
- 9. Халzan уулын тэмдгийг ажиглаарай, битүү хаяалбар шугамын гадна гадагшaa заасан зураас байгаа нь юуг зааж байна?
- 208.8 тоот өндөрлөгийн газарзүйн ба тэгш өнцөгтийн солбицлыг олоорой.



МОНГОЛ ОРНЫ БАЙГАЛИЙН ЕРӨНХИЙ ТОЙМ

4

Гол агуулга

- Газрын гадаргын ерөнхий тойм
- Геологийн цаг тоолол
- Атираат муж
- Геологийн хөгжил
- Ашигт малтмал

Юу мэддэг болох вэ?

- Монгол орны гадаргын ерөнхий шинж, хаагуур ямар хэлбэр зонхилдог болохыг мэдэж тэдгээрийн аж ахуйн ашиглалтын талаар ойлголттой болох
- Ашигт малтмалын нэр төрөл, тархалтын зүй тогтол, ашиглалтын талаар мэдэх
- Монгол орны геологийн хөгжлийн талаар мэддэг болно.

Юу чаддаг болох вэ?

- Газрын зураг ашиглан гадаргын хэлбэрийн талаар ерөнхий дүгнэлт гаргаж сурас
- Алтай, Хангай, Хэнтий, Их хянган, Хөвсгөл орчмын уулс ба тал газруудын тархалт байршлыг зураг дээр зааж газарзүйн онцлогийг нь тайбарлаж чаддаг болох
- Монгол орны ашигт малтмал, байгалийн нөөцийг ирээдүйд хэрэглэх, улс орныхоо эдийн засгийг хөгжүүлэхэд хэрхэн ашиглаж болох тухай төсөөлөл гаргаж чаддаг болно.

Мэдлэгээ хэрхэн хэрэглэх вэ?

- Газрын гадарга нь уур амьсгал, ус, хөрс, ургамал амьтан зэрэг байгалийн юмсаас гадна зам тээвэр, үйлдвэр, газар тариалан, хадлан, бэлчээр гэхчлэн аж ахуйд эерэг сөрөг ямар нөлөөтэй болохыг нутгийнхан жишээн дээр ойлгож, амьдралдаа хэрэглэж сурна.

11. ГАЗРЫН ГАДАРГА

Монгол орны нутаг өрөнхийдөө өндөрлөг, нутгийн 80 гаруй хувь нь далайн төвшнөөс дээш (д.т.д) 1000 метрээс өндөр өргөгдсөн бөгөөд нутгийн дундаж өндөр нь 1580 м юм.

Энэ нь дэлхийн хуурай газрын дундаж өндрөөс 800 метрээр, Ази тивийн дундаж өндрөөс 600 гаруй метрээр өндөр байгаа гэсэн үг. Ийм учраас манай улс их өндөрлөг газар оршдог гэж дүгнэж болно.

Нутгийн баруун ба хойд хэсэг нь өндөрлөг уулархаг, зүүн хэсэг нь талархаг. Газрын гадаргын хэлбэр, өндөр нам нь уур амьсгал, ус, хөрс, ургамал, амьтны байрлалд ихээхэн нөлөө үзүүлдэг зүй тогтолтойгоос гадна зам тээвэр, үйлдвэр, газар тариалан, хадлан, бэлчээрийн ажилд бас нөлөөлдгөөрөө улс орны эдийн засагт эерэг ба сөрөг дагавар авчирдаг.

Уулс. Манай оронд Алтай, Хангай, Хэнтий, Их хянган, Хөвсгөл орчмын гэсэн уулсын таван үндсэн тогтолцоо бий. Эдгээрээс хамгийн том нь Алтайн уулсын тогтолцоо юм.

Алтайн уулс нь улсын нутгийн баруун захаас хил даган зүүн хойшоо **Сийлхэмийн нуруу** болж үргэлжилнэ. Монгол Алтайн нурууны баруун захад орших **Таванбогд** уулын оргил **Хүйтэн** уул нь 4374м өндөр бөгөөд манай улсын хамгийн өндөр цэг юм. Таванбогд уулаас зүүн хойшоо улсын хил даган 200 орчим км үргэлжлэх 3500 орчим метр өндөр **Сийлхэмийн нуруу** салбарлана.


Монгол Алтайн нуруунаас **Ховд** гол эх авна. Ачит нуурын хөндийгөөр тусгаарлагдан зүүн талд нь мөнх цаст **Хархираа**, Түргэн уул, түүний урд залгаанд Их тахилгат **Алтанхөхий** уул оршино.

Гичгэний нуруунаас зүүн тийш Баянцагааны нуруугаар эхлэх **Говь-Алтайн** уулс нь зүүн тийш болох тутам говийн байдалтай болж намсахаас гадна тасархайтан өөр хоорондоо холдоно.

Говь-Алтайн нуруу нь богиновтор боловч хэд хэдэн эгнээ болох нуруудтай, өргөн хоолой бүхий **Тэнгэр** уулын тогтолцооны уулс юм.



18 дугаар зураг. Алтайн нурууны Хархираа уул. Мөнх цастай



Масштаб 1 см-т 188 км



19 дүгээр зураг. Монгол орны газрын гадарга ба байгалийн онцлог

Монгол Алтай гол нуруугаа дагасан цувраа уулс болон түүнтэй зэрэгцэн орших салбар уулсаас бүрэлдэнэ. Энд кембрийн өмнөх эриний эх чулуу, хувирмал чулуулгууд, мөн ордовик, силурийн галвын элсэн чулуу, занар ихээхэн түгээмэл байдаг.

Говь Алтай богино, хэд хэдэн эгнээ

нурууттай, эгнээ уулсын хооронд өргөн хөндийнүүд оршдог. Эрс тэс хэлбэртэй, хад элбэгтэй, эгц хажуу бүхий хотгор гүдгэр зонхилох бөгөөд уулс нь уудам хотгоруудаар бие биенээсээ тусгаарлагдсанаас гадна цөлийн өгөршлийн хүчтэй нөлөөнд автагдсан учраас хажуу нь эгц, орой тэгшивтэр байна.



20.а дугаар зураг. Хангайн нуруу



20.б дугаар зураг. Хэнтий ханы Бурхан Халдун уулын Дарцаг мод

Хангайн нуруу нь Завхан аймгийн нутаг дахь Сонгинохайрхан уулнаас зүүн урагшаа Төв аймгийн нутаг дахь Дэлгэрхаан уул хүртэл 700 орчим км урт үргэлжилдэг. Гол нуруу нь 3000 гаруй метр өндөр бөгөөд оргил нь мөнх цаст, их тахилгат, тусгай хамгаалалттай, 4021 м өндөр Отгонтэнгэр уул юм. Хангайн уулсад Урантогоо, Хорго, Ханбаян зэрэг унтарсан галт уулс бий.

Хангайн нуруу өрөнхийдөө хавтгай бөмбөгөр оройтой, уулын хажуу нь эгц цавчим, эртний тэгширлийн гадарга бүхий нутаг юм. Гол нурууны дээд хэсэгт мөсөн голын хунх, тэвшин хөндий бий. Гол нуруу нь зүүн хойшоо намсан **Орхон Сэлэнгийн** хөндийн

өмнөх хэсэгт, ухаа гүвээт тэгш өндөрлөг болдог.


Хэнтийн нуруу нь нутгийн зүүн хойд хэсэгт 400 орчим км үргэлжилнэ. Хэнтийн нурууны баруун тийш салбарласан хэсгийг **Багахэнтий**, зүүн тийш салбарласан хэсгийг **Иххэнтий** гэнэ. Оргил нь **Багахэнтийд** орших 2800 метр өндөр **Асралтхайрхан** уул юм. Улаанбаатар хотын өмнүүр сүн-дэрлэх дархан цаазат **Богдхан** уул нь Хэнтийн нурууны салбар юм. Хэнтийн нурууны Асралтхайрхан уул орчим уулсын хажуу эгц орой нь тэгширлийн байдалтай, **Багахэнтийн** нурууны хойд хажуу нэлээд эгц бөгөөд өмнөд хажуу нь налуу юм. Эртний мөстлөгийн хунх, морены толгод цэвдгийн нөлөөний ул мөр бий.

нуруу, **Ихсоёны** нуруутай холбоотой юм. Хөвсгөл орчмын уулсын хамгийн өндөр цэг нь 3491 метр өндөр **Мөнхсарьдаг** оргил юм.

Хөвсгөлийн уулс баруун хойноосоо зүүн урагш болох тусам өндөр нь намсана. Ян сарьдгууд олонтой, Альпийн уулын хэв шинжтэй, хажуу нь гүн хавцаар хэрчигдсэн, асга хад ихтэй, Хөвсгөл нуурын баруун ба зүүн хэсгээр бэсрэг уулс олон.

Нутгийн зүүн захад орших **Их Хянганы** уулсын салбар нь 1500 орчим метр өндөр, намхан уул юм.

Манай орны нутагт буй **Хянганы** уулсын салбарууд нь ерөнхийдөө зүүнээс баруун тийшээ чиглэх ба нийтдээ намхан 800-1500 м өндөр, бөмбөгөр



21 дүгээр зураг. Хөвсгөлийн Их уул

Хангайн нурууны баруун хойд захаас хойшоо үргэлжлэх **Хөвсгөл орчмын уулс** баруун хойд захад орших ба уулзүйн хувьд хил орчмын **Тагнын**


хавтгай оройтой, налуу хажуутай, голын хөндийнүүд нь нэлээд өргөн намаг ихтэй.



| Уулсын тогтолцоо | Хамрагдах уул нурууд | Хамгийн өндөр оргил |
|------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------|
| Алтайн нуруу | Монгол Алтай Таванбогд, Ёлт, Өвчүү, Мөст, Өндөрхайрхан, Бурханбуудай, Дөш, Цэнгэлхайрхан, Цамбагарав, Хөхсэрг, Хархираа, Түргэн | Хүйтэн 4374 м |
| Хангайн нуруу | Говь Алтай Баянцагаан, Ихбогд, Багабогд, Арцбогд, Гурван сайхан, Алтан, Сэврээ, Зөөлөн, Бумба, Тост, Ноён Хангайн гол нуруу, салбар уулс: ХанХөхий, Тогтохын шил, Тарвагатай, Булнай, Суваргахайрхан, Уулзүйн хувьд холбоотой: Намнан, Бүрэн, Бүтээл, Хантай | Их богд 3957 м Отгонтэнгэр 4021 м |
| Хэнтийн нуруу | Иххэнтий Багахэнтий | Асралтхайрхан 2800 м |
| Хөвсгөлийн уулс | Хордил сарьдаг, Улаантайга, Баяны нуруу | Мөнхсарьдаг 3491 м |

"Бууж удлэм холоос
 Айл нь харагдах сонин
 Бугуйл хаям ойроос
 Нар нь мандах хачин"
 (Төрийн шагналт, яруу найрагч
 Б.Явуухулан "Тал" шулгийн хэсгээс)

22 дугаар зураг. Мэнэнгийн тал



23 дугаар зураг. Монгол орны хоттор гудгэрийн ялгаа

Тал. Монгол орны төв, зүүн, зүүн өмнөд хэсэг нь тэр аяараа үндсэндээ талархаг гадаргатай, өндөр нь 560-900 орчим метр. Манай орны баруун хэсгийн уулсын хооронд нуурууд бүхий хонхор болон том уулсын ар, өврөөр бас хотгор талархаг газрууд их бий.

Ухаа гүвээт тал. Тал нь 10-20 м өндөр, бөмбөгөр оройтой, маш налуу хажуутай, тэдгээрийн хооронд тэгш гадарга дээр элс, хужир марз элбэг.

Гуу жалга бараг байхгүй, хотос хонхор маш гүехэн тэгш талууд бий.

Монголын дорнод хэсэг нь кембрийн болон эртний төрмөлийн суурь чулуулгийг хучиж далдалсан дундад төрмөлийн болон гуравдагч галавын хурдастай.

Уул хоорондын хонхор ба голын хөндий. Төрх байдлын хувьд харь-

цангуй тэгшивтэр, хавцал маягийн, тэвшин хэлбэрийн хөндийнүүдтэй, уул хоорондын хотгорын бага зэргийн овон товонтой өрөнхийдөө хотгорын төв рүүгээ хэвгий байдаг. Хотгор хоолойнууд нь хэлбэр дүрс хэмжээгээрээ ялгаатай бөгөөд заримд нь нуур, хужир, шал, тойром тогтсон байдаг.

Говийн өмнөд нутаг дахь гадаргын онцлог хэлбэр бол цав, зоо гэж нэрлэгдэх эртний тунамал хурдсын илэрцүүд бөгөөд энд цэрдийн болон палеогений галвын аварга хөхтөн амьтдын чулуужсан яс элбэг тохиолдоно. Жишээ нь: Бүгийн цав, Хэрмэнцав, Ногоонцав, Эргэлийн зоо, Баянзаг гэх мэт.



1. Монголын физик газарзүйн зураг дээр өнгийн шатлал ашиглан танай нутгаас нам ба өндөрлөг газарт багтах нутаг хаана байгааг ол. Газрын налуу танай суурингаас хойш ба урагш хэрхэн өөрчлөгдж байгааг ажиглан бичээрэй.
2. Гадаргын хэлбэр ба өндөр нам нь байгалийн бусад зүйлсэд хэрхэн нэлөөлөх талаар дараах хүснэгтийг ашиглан товч бичиглэл хий.

| | |
|----------------|--|
| Үүрээлжийн тал | |
| Хөөрөө | |
| Үрээлжийн тал | |
| Бэлтгэлийн тал | |
| Аж үеийн тал | |
| Нийтийн тал | |

3. 22-р зургийг ажиглан томоохон хотгор, уул хоорондын хөндий болон.govийн нэрсийг бичиж аваарай.

12. ГЕОЛОГИЙН ХӨГЖИЛ

Геологи нь Дэлхийн чулуун мандлын тогтоц, эрдэс баялгийг судалдаг ухаан. Дэлхийн бөмбөрцгийн геологийн хөгжлийн үе шатуудыг тогтоохдоо чулуулгийн үе давхаргаас олддог ургамал амьтны чулуужсан яс, үлдэгдлийг судалдаг.

Геологийн хөгжлийн хамгийн том үелэл нь эрин юм. Геологийн эрин нь олон зуун сая жил үргэлжилсэн учир түүнийг дотор нь арай богино хугацаагаар буюу хэдэн арван сая жил үргэлжилсэн үе болох галавуудад хуваана.

Газрын давхарга нь **магмын, тунамал, хувирмал** гарал үүсэлтэй чулуулгаас бүрэлддэг тухай бид мэдэх билээ. Чулуулгийн анх үүссэнээс хойших өнгөрсөн цаг хугацааг чулуулгийн **үнэмлэхүй нас** гэнэ.

Магмын чулуулгууд гэж дэлхийн гүний халуун хайлмаг бодис (магма) дээш нэвчин царцах буюу газрын гадаргад бялхах замаар үүссэн чулуулгуудыг нэрлэнэ. Дэлхий

дээр хамгийн өргөн тархалттай боржин бол магмын чулуулаг юм.

Тунамал чулуулгууд газрын гадарга дээр гол төлөв ус, нар салхины үйлчлэлээр үүсэх бөгөөд элс, шавар, шохойлог найрлагатай байна.

Хувирмал чулуулгуудад газрын гүний өндөр даралт, дулааны нөхцөлд анхдагч төрхөө өөрчилж өөр найрлага, бүтэцтэй болсон бүх төрлийн чулуулгийг хамааруулна. Энэ бүлгийн гол төлөөлөгчид нь боржингоос үүсдэг гнейс, элсэн чулуу, шавраас үүсдэг занар, шохойн чулуунаас үүсдэг гантиг зэрэг болно.

Чулуун мандлын хавтангуудын хөдөлгөөний улмаас газрын давхарга атираажих, хагарч зөрөх зэргээр өөрчлөгднө. Энэ үйл явцыг **тектоник хөдөлгөөн** гэнэ.

Монгол орны нутагт геологийн бараг бүх эрин галавт үүссэн чулуулаг тархсан байдаг.



24 дүгээр зураг. Үлэг гүрвэлийн араг яс (Улсын Байгалийн түүхийн музей)

ГЕОЛОГИЙН ЦАГ ТООЛОЛ

| | | Эриний хугацаа (жилээр) | Болсон атираачил Үргэлжилсэн хугацаа (жил) | Болсон үйл явдал | Үүссэн ашигт малтмал |
|----------|-----------|--------------------------------------|-------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------|
| | | Кайнозой (шина термөн) 65 сая жил | Дөрөвдэгч 1.5 сая | Олон удаа мөстлөг болов Хүний үүсэв | Хүлэр, шижирмэг, алт, барилгын материал |
| | | Альпийн | Неоген 22.2 сая | Хүн дүрст сармагчин, адуу үүсэв. | Хүрэн нүурс шатагч хий, нефть, хувь төмөр |
| | | Палеоген | 41 сая | Төв Азийн уулс ба говийн үүсэв. Хөхтөн, халим, мөнх ногоон ургамал үүсэв | Фосфорит, нүурс, боксит |
| | Мезозойн | Цэрэд 140 сая | Галт уулын идэвхжил. Үлэг гүрвэл, далд үрт ургамал үүсэв | Нефть, шатагч хий, нүурс, холимог төмөрлөг. Налаих, Багануур, Шивээ овоо, Чандган | |
| | Юр | 195 сая | | Нисдэг гүрвэл үүсэв | Нүурс, нефть, фосфорит. |
| | Триас | 48 сая | | Тивүүдийн задрал. Шүүвуу хөхтөн үүсэв | Могойн гол, Улаан толгой нүүрсний орд |
| | Пермь | 47 сая | | Тивүүдийн боёгнөрөл, даян дэлхийн хуягийшилт蒙古 орны юнөгийн нутаг хурай газар болон хөгжжик эхэв. Сээр нуруутан амьтан үүсэв. | Давс, нүурс, шатагч хий, төмөрлөг ашигт малтмал. Тавантонгой |
| | Герциний | Карбон 56 сая | | Өтгөн ой, нүцгэн үрт ургамал дэлгэрэв. Мөстлөг | Хар тарвагатай, яварын нүүрсний орд |
| | Девон | 56 сая | | Европ, Америк тив үүсэв. | |
| | Силур | 30 сая | | Тэнгисийн татралт, галт уулын идэвхжил, загас ургамал үүсэв | Төмөр, хромит, ээс, холимог төмөрлөг |
| | Каледоны | Ордовик 55 сая | | Тэнгисийн түрэлт, тэнгисийн сээр нуруутан амьтан ошров | |
| | Кембри | 50 сая | | Тэнгисийн сээр нуруутан амьтан үүсэв | Нефть, фосфорит |
| Протозой | | 1995 сая | | Анхны мөстлөг, эртний тивүүдийн цом бүрэлдэв. Тэнгисийн олон эст замаг үүсэв. | Төмөр, ховор төмөрлөг, ээс, марганц, алт, цагаан алт, уран, алмаз, диц |
| Archæй | Байгалийн | 1100 сая | | Анхны далай тогтов. Нэг эст бактер, хөх ногоон замгууд үүсэв. | |

Дөрөвдөгч галавт хүн бий болж байгалийн хатуу ширүүн нөхцөлтэй тэмцэн чулуу, төмөр зэвсэг хийж амьдралдаа хэрэглэж байсны ул мөр манай оронд цөөнгүй тохиолдоно.

Неогены галавын эцэс дөрөвдөгч галавын үед болсон хөдөлгөөний үед өнөөгийн манай **Өмнөговь, Архангай, Өвөрхангай, Хөвсгөл, Булган, Сүхбаатар** аймгийн нутагт галт уул оргилж байжээ. Тэдгээрийн жишээ нь Сүхбаатар аймгийн **Дарьганга** нутагт байгаа **Шилийн Богд, Алтан Овоо** зэрэг 222 унтарсан галт уулс, Архангайн **Хоргын тогоо**, Булганы **Уран тогоо** зэрэг унтарсан галт уулс болно.

Архангайн Хорго гэхэд л 8 мянга орчим жилийн өмнө оргилж байсныг эрдэмтэд тогтоожээ. Дөрөвдөгч галавын хөдөлгөөн одоо ч үргэлжилсээр байгааг хүчтэй газар хөдлөлүүд илэрхийлдэг.


1905 оны Булнай-Ханхөхийн газар хөдлөл 400 орчим км урт ан цавыг үүсгэсэн бөгөөд энэ нь дэлхийд газар хөдлөлөөр үүссэн хамгийн урт бөгөөд шулуун хагаралын нэг юм. 1957 оны Ихбогдын газар хөдлөл 300 орчим км урт хагарлыг, 1968 оны Булганы Могоодын газар хөдлөл 40-өөд км урт хагарал язархайг үүсгэжээ.



25 дугаар зураг. 1905 оны Булнайн газар хөдлөлийн хагарал



26 дугаар зураг. 1967 оны Могоодын газар хөдлөлийн хагарал



27 дугаар зураг. Хоргын унтарсан галт уул
(баруун талаасаа,
дотор тал нь)



Геологийн зураг. Газрын давхарга дахь чулуулгийн бүтэц, тархалтын зүй тогтол, оршилтыг мэдэхийн тулд геологийн судалгаа явуулдаг. Ийм судалгааны дүнгээр геологийн зураг зохиодог.

Геологийн зураг дээр янз бүрийн нас, найрлага бүхий чулуулгийн тархалт болон хагарлуудыг таних тэмдгээр ялган үзүүлнэ.

Тектоникийн зураг. Дэлхийн бөмбөрцөг дээрх атираат мужийн бүтэц, үүссэн нөхцөл ба насыг өнгөт дэвсгэрийн арга, таних тэмдэг хэрэглэн үзүүлсэн зургийг Тектоникийн зураг гэнэ. Ийм зураг ашигт малтмалын эрэл хайгуулд их үүрэгтэй.



1. Геологийн цаг тооллын дэс дарааллыг 45-р хуудаснаас үзээд, даацах асуултад хариулаарай.
 - Эртний төрмөлийн эрин одоогоос хэдэн жилийн өмнөөс эхлээд, хэдэн жилийн өмнө дууссан бэ?
 - Пермийн галаваас хойш хэдэн сая жил өнгөрсөн байна? Түүнээс хойш болсон гол үйл явдлууд юу байв?
2. 1905, 1957, 1967 оны газар хөдлөлийн талаар ахмад хүмүүсээс сураглаж мэдэж аваарай.
3. Газрын гадаргын хэлбэрийг өөрчилдөг гадаад дотоод хүчин зүйл бий. Аль нь танай нутагт илүү илэрсэн байна вэ? Жишээ гарган ярилцаарай.
4. Танай нутагт ямар төрлийн чулуулаг элбэг тархсан бэ?
Сумын төв орчимд ямар төрлийн чулуулагтай вэ? Ярилцаарай.
5. Кембрийн галавт газар дээр уудам усан сан тогтсон. Сибурийн галавт тэнгисийн ус багасав. Энэ хугацаанд тэр тэнгисийн усанд 100 жилд 1 мм тоос тунадас үүсж хожим тэр нь чулуу болон хувирсан гэж санавал тэр тунамал чулуулаг хэдий хэр зузаан давхраас үүсгэсэн байх вэ? (Хариуг Дадлага ажлын номоос үз)
6. Танай нутагт давхраа, атираа нь ил харагддаг хад чулуулагтай хавцал, ангал, уул бий юу? Зургийг нь зурж, эсвэл зургийг нь авч кабинетдаа тавь. Хэдий үеийн атираа байж болох талаар шүүн ярилцаарай.
7. Триасын галав хэдэн жил үргэлжилсэн бэ?
 - а. 58 сая жил
 - б. 43 сая жил
 - в. 45 сая жил
 - г. 41 сая жил
8. Фосфорит, зэсийн хүдэр, алт, нефть, шатах хий, чулуун нүүрс зэрэг нь эринд бүрэлдэн тогтжээ.
 - а. Эх төрмөл
 - б. Анх төрмөл
 - в. Эртний төрмөл



http://www.extmin...._aimag.htm
<http://www.emc.erdnet.mn>
<http://www.google.com>
<http://www.mram.mn>
<http://www.mne.mn>

13. АШИГТ МАЛТМАЛ

Монгол улс ашигт малтмалаар баялаг орон.

Аж ахуйд ашиглаж болох байгалийн байдлаараа байгаа эрдэс бодисыг ашигт **малтмал** гэнэ. Ашигт малтмал хуримтлагдаж орд газар үүсгэнэ.

Ашигт малтмал бол тэрийн өмч юм. Алт, фосфорит, зэс, газрын тос, хайлуур жонш, уран, нүүрсний баялагт манай ирээдүйн их найдвар бий.

Ашигт малтмалыг дотор нь төмөрлөг, төмөрлөг бус, шатах ашигт малтмал гэж ерөнхийд нь гурав хуваадаг.


Ашигт малтмал нь геологийн урт
удаан хугацааны явцад дэлхийн гадаад
ба дотоод хүчин зүйлийн нөлөөгөөр
үүсдэг.

Шатах ашигт малтмал нь нур, намаг, тэнгисийн гүехэн усны ёроолд удаан хугацааны туршид дарагдсан органик бодисын хуримтлааас үүсдэг.


Шатах ашигт малтмалын ийм төрлөөс манай оронд нүүрс их тархжээ.

Чулуун нүүрсний 200 гаруй ордод 152 тэрбум тонн нөөцтэй. Чулуун ба хүрэн нүүрсний ордыг үүссэн насаар бүлэглэж үзвэл:

1. Цэрдийн галавт үүссэн нүүрсний орд Төв, Дундговь, Дорнговь, Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймгийн нутгийг хамарсан бүс үүсгэнэ. Гол орд нь: Налайх, Баганур, Шивээ Овоо, Чандган, Талбулаг, Адуунчулгуу юм.
 2. Юрийн галавын нүүрс Булган, Хөвсгөл, Сэлэнгэ аймгийн нутгийг хамарна. Гол ордод Сэлэнгийн Улаантолгой, Булганы Сайхан Овоо, Хөвсгөлийн Могойн голын орд орно.
 3. Пермийн галавын чулуун нүүрс ба коксжих нүүрс Өмнөговь,



28 дугаар зураг. Шатах ашигт малтмал



Говь-Алтай аймгийн нутагт байх ба Өмнөговийн Тавантолгойн орд нөөц ихтэй юм.


4. Карбоны галавын нүүрс Увс, Ховд, Говь-Алтайн нутгийг хамарсан бүсэд тархжээ. Гол орд нь Увсын ХарТарвагатай, Явар зэрэг болно.

Шатах ашигт малтмалын өөр нэг гол төрөл нь газрын тос буюу нефть юм. Дорноговийн Зүүнбаянд цэргийн хурдсанд, Дорнодын Тамсагт мөн цэргийн хурдас дотор оршино. Байгалийн хий ч ийм хурдсанд олдох магадлалтай. Шатах занар, хүлэр ч манайд элбэг байдгийн дотроос Өвөрхангай, Хөвсгөл аймагт элбэг. Архангайн Хашаат бол гол орд нь юм. Дундговь, Сүхбаатарт мөн цэргийн хурдсанд шатах занарын 30 гаруй орд бий. Эдгэрээс Өвөрхангайн Хөгшин гол, Архангайн Хашаат /Зүүнбулаг/ нэлээд нөөцтэй.

Нүүрсний гаралтай их нөөцтэй метан хий Өмнөговийн Гурвантэс сумын Нарийн Сухайтын нүүрсний орд орчимд олджээ.

Төмөрлөг ашигт малтмалын аж ахуйн ач холбогдол их, эдгэр ашигт малтмал нь харьцангуй залуу настай, талст чулуулгийн шургамал биетүүдийн нөлөөгөөр үүснэ. Өнгөт ба ховор төмөрлөгийн хүдрүүд болох цагаан тугалга, хар тугалга, зэс, молибден, алт, мөнгөний хүдрүүд үүнд хамарагдана. Ялангуяа зэсийн хүдэр бол манай орны гол экспортын бүтээгдэхүүн юм. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 23.6%, экспортын бүтээгдэхүүний 29.1%-ийг зэсийн үйлдвэрлэл эзэлж байна. Зэсийг цахилгаан дамжуулагч, гоёл чимэглэл, ахуйн хэрэглэлд ашигладаг.

Зэс-Молибден. Хангайн нурууны ар, Сэлэнгийн саваас баруун тийш Хяргас нуур хүрэх өргөн уудам бус нутагт байна. Гол орд нь Эрдэнэтийн



30 дугаар зураг. Төмөрлөг ашигт малтмалын тархалтын бүсүүд



31 дүгээр зураг. Алтны уурхайн дүр төрх

овоо, Цагаансуварга болно. Өмнөговийн Оюу толгойд их нөөцтэй зэс, алт олдоод ашиглах ажил эхлэх гэж байна.

Манай орон алтны нөөц ихтэй.


2005 оны байдлаар 12 тн алт олборлосон нь байна. Алтыг зөвхөн гоёл чимэглэл төдийгүй, цахилгаан техник болон бусад салбарт хэрэглэдэг үнэт металлын төрөлд ордог бөгөөд Монгол Алтай, Хангай, Хэнтий нуруунд түгээмэл тархсан байна. Ялангуяа Орхон, Сэлэнгэ, Бороо, Ерөөгийн сав газар, Хангайн өвөр, Говийн хойд хэсэг, Говь-Алтайн нурууны баруун хэсэгт, Хархираа, Түргэн уул, Алтайн Өвөр говь, Баруун хуурайд байх ба гол орд нь Заамар, Толгойт, Дөвөнт, Ерөө, Бороо, Оюутолгой болно. Мөн Баян-Өлгийн Асгатад бий.

Дундговь аймгийн нутгийн зүүн хэсгээс зүүн тийшээ Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймгийн нутгийг дамнасан ёргөн уудам бүс нутагт холимог

төмөрлөг орших ба гол орд нь Хараат уул, Бүрэнцогт, Төмөрт Овоо, Асгат, Цав, Улааны орд гол ордууд юм.

Алтайн гол нуруу /Таванбогд/, Хэнтийн нуруу, Улз голын сав, улсын нутгийн зүүн өмнө захад ховор төмөрлөг их. Дорнговийн Лугийн гол, Өмнөговийн Мушгиагийн савд том ордууд илэрчээ.

Төмөрлөг бус ашигт малтмал: Барилгын гол түүхий эд болох элс, хайрга, шохойн чулуу, бал чулуу, боржин, сайн чанарын шавраас авахуулаад, хайлуур жонш, очир алмаз ч хамарагддаг. Эдгээрийн дотроос манай оронд хайлуур жонш элбэг бөгөөд Хэнтий, Дорнговь, Сүхбаатар, Дорнод аймгийн нутгийг хамарсан уудам бүс нутагт 370-аад орд байна. Гол орд нь:Хэнтий Дорнговийн Бор-Өндөр, Хажуу Улаан, Бэрх, Дожир, Өргөн, Хар Айраг, Зүүн Цагаандэл юм.



32 дугаар зураг. Төмөрлөг бус ашигт малтмал

Фосфоритийн орд Хөвсгөл аймгийн нутагт уудам нутгийг эзэлнэ. 40 орчим ордод 4.5 тэрбум тонн нөөцтэй. Хөвсгөлийн Урандөш, Онгилог, Жанхай, Бүрэнхаан гол ордууд юм.

Төрөл бүрийн давс манай оронд элбэг бий. 50 орчим орд илрэлд 10 орчим тэрбум тонн нөөцтэй. Гол

орд нь: Өмнөговийн Гурвантэс, Дорнодын Сангийн далай, Увсын Шүдэн уул, Сүхбаатарын Өөшийн говь зэрэг газарт девоны ба дөрөвдөгчийн хурдас дотор агуулагдана.

Баянхонгорын Ихбогд, Говь-Алтайн Тонхил, Хөвсгөлийн Залаатад шөрмөсөн чулуу бий.



33 дугаар зураг. Давс гаргаж байгаа нь (Өмнөговь аймгийн Гурвантэс сум)

Өмнөговийн Мандал Овоо, Дарханы Шарын гол зэрэг газар шаазан ваарын шавар элбэг.

Гөлтгөнө. Увсны Сагил, Дорноговийн Сайхандулаан, Өлгийхийд, Дундговийн Дэлгэрхангай зэрэг газарт пермийн ба цэрдийн галавын хурдсандаа оршино.

Бал чулуу. Хөвсгөлийн Харгана гол, Төв аймгийн Зүлэгт

Хөвсгөл, Сүхбаатар, Хэнтий, Төв, Завхан, Говь-Алтай, Баян-Өлгий, Ховд, Өвөрхангай аймгийн нутагт өнгөлгөөний чулуу их бий.

Ашигт малтмалтай холбоотой экологийн асуудал. Ашигт малтмал олборлох нь хүний нийгмийн хэрэгцээ

оловч нөхөн сэргээлт хийхгүй бол байгаль орчныг бохирдуулах, эвдлэн сүйтгэх, унаган төрхийг алдагдуулах улмаар хэзээ ч нөхөж баршгүй хор хохирол учруулна. Газрын гадарга хөрсийг эвдлэн сүйтгэхээс гадна ус гол ширгэн хатах, агаар бохирдуулах зэргээр маш их нөлөөлдөг. Жишээ нь: 2005 оны байдлаар зөвхөн Өвөрхангай, Баянхонгор аймгийн нутагт гэхэд л нийт 120 га газар алт олборлосноос болж эвдрэлд оржээ. Иймд ашигт малтмал олборлосон нүхийг дахин булж тэгшлэх, мод зүлэг суулгах зэргээр нөхөн сэргээх ба худаг уснаас аль болох хол олборлолт хийх шаардлагатай байдаг.



- Манай орон газрын гадаргын хэлбэр геологийн он цагийн урт хугацаанд үүсэн хэлбэржжээ. Одоо ч бүрэн хэлбэржээгүй байгаа нь үе үе болдог газар хөдлөлөөр харагдана.
- Манай орон ашигт малтмалаар баян. Ялангуяа алт, газрын тос, зэс, нүүрс, фосфорит, уран, нүүрс, хайлуур жоншны баялагт ирээдүйн их найдвар бий.



1. Танай нутагт ямар ашигт малтмал хаана, хаана байна? Ярилцаарай
2. Нүүрний ордуудыг насаар нь жагсаа, эдгээр нь тус бүрдээ хэдэн жилийн өмнө байгалийн нөхцөл ямар байхад ямар, ямар эрин галавт үүссэн болохыг ярилцаарай
3. Танай аймаг сум нүүрсээ хаанаас авдаг, ямар зэргийн чанартай нүүрс болохыг мөн зургийг ажиглан дүгнэлт гаргаж ярилцаарай.
4. Эдгээр зургийг хараад ямар чулуулгаар хийснийг нэрлэж танай аймагт байгаа эсэх талаар ярилц.





ҮҮР АМЬСГАЛЫН НӨӨЦ

5

Гол агуулга

- Уур амьсгалыг бүрэлдүүлэгч хүчин зүйлс
- Хийн мандлын орчил урсгал
- Хийн мандлын фронт, циклон, эсрэг циклон
- Цаг уурыг урьдчилан мэдэх аргууд
- Уур амьсгалын горим, агаарын температур
- Салхи
- Хур тунадас

Юу мэддэг болох вэ?

- Монгол оронд эх газрын эрс тэс уур амьсгал бүрэлдсэн шалтгаан, нөлөөлсөн зүйлсийн тухай
- Агаарын температур, даралт, салхи зэрэг уур амьсгалын элементүүдийн хуваарилалт болон тэдгээрийн учир шалтгааны талаар мэддэг болно.

Юу чаддаг болох вэ?

- Цаг агаарын элементүүдийн хоорондын хамаарлыг тайлбарлах
- Тоон үзүүлэлт ашиглан график, диаграмм байгуулах
- Монгол орны болон өөрийн амьдарч буй газар орныхоо цаг агаар, уур амьсгалын төрхийг тодорхойлох
- Цаг агаарын ажиглалт хийж, ойрын 2-3 хоногт тэнгэр ямар байхыг урьдчилан мэддэг болно
- Уур амьсгалын зураг, цаг агаарын зураг уншиж ашиглаж сурна

Мэдлэгээ хэрхэн хэрэглэх вэ?

- Нутаг орны цаг агаар, уур амьсгалын байдлаас хамаарч аж ахуй хөтлөхдөө зөв сонголт хийх
- Цаг агаарын байдлыг ажиглаж, цаг агаарын мэдээг ойлгож, амьдрал ахуйдаа ашиглах
- Уур амьсгал, цаг агаарын үйл явцын учир шалтгааныг тайлбарлаж чаддаг болно.

14. УУР АМЬСГАЛД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛС

Үүр амьсгалын нөхцөл нь байгалийн хамбүрдэлд болон хүний аж ахуйн үйл ажиллагаанд ихээхэн нөлөө үзүүлнэ.

Тухайн газар нутагт олон жилийн турш тогтмол ноёрхож ирсэн цаг агаарын байдлын дундаж горимыг **уур амьсгал** гэх бөгөөд үндсэн үзүүлэлт нь дулааны ба тунадасны тоо хэмжээ, түүний улирлаар хуваарилагдсан байдал, ууршилт, чийглэгийн итгэлцүүр (коэффициент) юм.

Тухайн газар орны уур амьсгал бүрэлдэн тогтоход газарзүйн байрлал, нарны цацраг, агаарын массын хөдөлгөөн, гадаргын байдал, өндөршилт, далай тэнгисээс хол, ойр орших байдал, далайн урсгал, уул нуруудын чиглэлээс гадна хүний үйл ажиллагаа нөлөөлдөг. Манай орны уур амьсгал бүрэлдэн тогтоход эдгээр хүчин зүйлс хэрхэн нөлөөлснийг авч үзье.

Газарзүйн байрлалын нөлөө. Газарзүйн байрлалын нөлөөлөл суурь хүчин зүйл болохын учир нь нарнаас ирэх илч дулааныг өргөрөг бүр өөр өөр хэмжээтэй авдагт оршино.

Монгол орон дэлхийн бөмбөрцгийн хойд хагасын дундад өргөрөгт багтах боловч далайн түвшнөөс дээш нэлээд өндөрт өргөгдөн (1580 метр) эргэн тойрон уул нуруудаар хүрээлэгдэн далай тэнгисээс алс оршдог нь нэг өргөрөгт байдаг бусад орныг бодвол дулааны илч бага, далайн агаар нэвтрэн ирдэггүй буюу маш бага хэмжээтэй

ирдэг учир хур тунадас багатай байна. Түүнчлэн халуун, хүйтний зөрүү нэг жилийн дотор төдийгүй нэг хоногт их байдаг учир ийм уур амьсгалыг **эх газрын эрс тэс уур амьсгал** гэнэ.

Нарны цацраг. Нарнаас ирж байгаа гэрэл, илчийг **нарны цацраг** гэх ба цацрагийн зарим хэсэг нь агаар мандалд шингэж, зарим нь уул, тал, агаар мандлын тоос зэргээс болж сарнина. Багахан хэсэг нь л гадаргад ирдэг. Нарны сарнисан ба шулуун цацрагийн нийлбэрийг **нийлмэл цацраг** гэнэ.


Нар тэнгэрийн хаяанаас дээш хэр өндөрт мандахаас тэнд ирэх дулааны хэмжээ шалтгаална. Нар өндөрт мандаж байвал их дулаан авна, нарны мандах өндөр бага бол тухайн газрын хүлээж авах дулааны тоо хэмжээ мөн л бага байна гэсэн уг.

Тухайн газрын хүлээж авах нарны цацрагийн тоо хэмжээ нь өргөргөөс хамаарна. Учир нь нарны тусгалын өнцөг өргөрөг бүрт өөр өөр байдаг. Манай орны өмнөд хэсгээр нарны тусгалын өнцөг арай их байхад хойд хэсгийн нутгуудаар ийм биш тул харьцангуй сэргүүн байдаг юм. Манай орны хамгийн хойд ба урд захын нутгийн өргөргийн зөрөө $10^{\circ}34'$ бай-гаа нь тэр нутгуудад нарнаас ирэх илч төдий хэмжээний градусын ялгаатай байна, хойшлох тутам өөрөөр хэлбэл өргөрөг өндөрсөх тутам илч дулааны хэмжээ багасна гэсэн уг. /35-р зургийг ажиглаарай/



Нарны цацраг нь дэлхийн гадаргын 1 ам дөрвөлжин см талбайд ноогдож буй дулааны тоо хэмжээгээр илэрхийлэгддэг.

Үүнийг ккал / см² -аар тэмдэглэнэ.




34 дүгээр зураг. Улаанбаатарын зуны

(1) ба өвлийн (2) туйлын өдрийн
үдийн нарны тусгалын өнцөг



Үдийн нарны тусгалын өнцгийг өгсөн томъёогоор бодож,
хүснэгтийг гүйцээгээрэй. (Өөрийн суурингийн нарны тусгалын
өнцгийг хэмжиж шалгаарай)

| ^а Өðã°Өðã | Ӧàìäèéí óðò °ä°ð (Çóíú ðóéë) VI.22 $H = 90^{\circ} - (\varphi + 23.5^{\circ})$ | Ӧýíöèééí °ä°ð III à IX ñàðûí 21-23 $H = (90^{\circ} - \varphi)$ | Ӧàìäèéí áîäèí °ä°ð (^а âëééí ðóéë) XII.21 $H = 90^{\circ} - (\varphi - 23.5)$ |
|----------------------|--------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------|
| Ýêâàðîð 0° | 66.5° ($H = 90^{\circ} - 23.5^{\circ}$) | 90° | 66.5° ($H = 90^{\circ} - 23.5^{\circ}$) |
| lyëöèéí çà 23.5° | 90° | 66.5° | 43° |
| ð.º. 41° | | | |
| ð.º. 45° | | | |
| ð.º. 48° | | | |
| ð.º. 49° | | | |
| ð.º. 51° | | | |
| ð.º. 52° | | | |
| ð.º. 66.5° | 47° | 23.5° | |
| Öïéä ðóéë äyýð | 23.5° | 0° | |



35 дугаар зураг. Хавар намрын өдөр
шөнийн тэнцлийн үеийн үдийн
нарны тусгалын өнцгийн ялгаа
(х.º. 41°, 51° дээр)

Манай оронд нарны цацрагийн хэмжээ ерөнхий зүй тогтлын дагуу хойноос урагш нэмэгдэнэ.

Манайд бүрхэг өдөр цөөн, голдуу цэлмэг байдаг учраас нарнаас шууд ирэх шулуун цацраг голлоно.

Өмнө зүгийн нутаг Говь-Алтай, Баянхонгор, Дорноговь, Дундговь аймгийн өмнөд хэсэг, Өмнөговь аймгийн бүх нутагт нарны нийлбэр цацраг 1500 kVt/цаг m^2 орчим байхад хойд хэсгийн Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулс болон Алтайн уулсад 1200 kVt/цаг m^2 -аас бага юм.


Манай орон далайгаас алс хол оршдог тул далайн уур амьсгалын нөлөө тун бага, өвөлдөө их хөрч, зундаа их халах учир уур амьсгалын эх газрын эрс тэс шинж чанартай болно.

барагцаалбал 100 м тутамд агаарын температур (0.6° орчмоор) буурдаг тул уулын орой нь бэл хажуу талаасаа илүү хүйтэн болно. Энэ нь тэнд чийг тунадас унах боломжийг ихэсгэнэ.

Нарны илчийн хэмжээ уулын ар, өвөр, хажууд харилцан адилгүй. Өвөрт нь нарны гэрэл илүү эгц тусах учраас дулаан байна. Ар, хажууд нь ташуу тусна, сүүдэр ихтэй, ийм учраас хүйтэн сэргүүн байна. /36-р зургийг үзнэ үү/

Ялангуяа өвөл нар тэнгэрийн мандалд доогуур манддаг учраас нарны гэрэл уулын энгэрт сайн тусаад уулын ар хажууд бараг тусахгүй, сүүдэртэй байна.

Манай орон бүх талаараа уулсаар хүрээлэгдсэн учир гаднаас чийгтэй дулаан, хуурай, хүйтэн зэрэг олон



36 дугаар зураг. Уулын ар, өврийн хажуу дахь нарны тусгалын байдал

Гадаргын хотгор гүдгэр уур амьсгалын нөхцөл үүсэхэд ихээхэн нөлөөлдөг. Жишээлбэл: Өндөр уулсад агаар хүйтэн, үүл ихтэй, тунадас илүү унадаг бол тал газарт дулаан, тунадас бага унана. Уул өөдөр өгсөхөд

төрлийн агаар нэвтрэн ирэхэд саад болдог. Алтай, Хангай, Хэнтийн уулс нь баруун, баруун хойд зүгийн агаарын урсгалыг хаадаг учраас чийг нь тэдгээр уулсын ар хажууд бууж талархаг нутаг хуурай болдог.



Малчид өвөлжөөгөө уулын энгэр газарт сонгож, малынхаа саравчийг урагш нь харуулан барьдгийн учрыг тайлбарлаарай.

Нутгийнхаа үдийн нарны тусгалын өнцөг өвөл, зуны туйл, хавар намрын өдрийн шөнийн тэнцлийн өдрүүдэд хэдэн градус байдгийг хэмжих олоорой. Тэгээд агаарын дулаан хүйтэнтэй холбож тайлбарлаарай.

13-р хуудасны өдөр үргэлжлэх хугацаанаас үзвэл зуны туйлын өдөр өргөргийн хувьд хойшоо байгаа газарт өдөр нь их урт байдаг байна. Улаанбаатарт зундаа өдөр нь Сайншандынхаас урт байдаг. Тэгвэл Улаанбаатарт өдөр нь илүү дулаан баймаар юм, гэтэл Сайншандад Улаанбаатарынхаас дунджаар 5° -аар илүү дулаан байдаг. Түүний учрыг тайлбарлаарай. (Хариуц Дадлага ажлын номоос үз)

15. АГААРЫН МАССЫН ОРЧИЛ ҮРСГАЛ

Манай орны үр амьсгалын байдалд Арктикийн, сэргүүн бүсийн, дулаан орны агаарын масс нөлөөлнө.

Арктикийн агаар нь Хойд мөсөн далай дээр бүрэлдэн тогтдог бөгөөд тэр нь өвөл зунгүй хүйтэн хуурай, тунгалаг байдаг. Ийм агаар манай нутагт ирэхэд тэнгэр цэлмэж хүйтэн болно.


Сэргүүн бүсийн агаар нь дундад өргөргийн эх газар ба далай дээр үүснэ. Эх газар дээр үүссэн ийм агаар нэвтрэн ирэхэд өвөл бол хүйтэн хуурай, зун бол дулаан хуурай байдаг. Харин далай дээр үүссэн ийм агаар нэвтэрч ирвэл өвлийн улиралд хүйтний эрч буурч, цас орно. Зуны цагт халуун буурч, агаарын чийг нэмэгдэн бороо орно.

Дулаан орны агаарын масс нь эх газрын, далайн гэж байх бөгөөд эх газрын агаар нь халуун чийг багатай, хуурай байдаг бол далайн агаар нь чийглэг учраас бороо оруулна. Манай оронд өвлийн улиралд Сибирьт бүрэлдэн тогтсон сэргүүн бүсийн агаарын


mass хойноос орж тогтдог бөгөөд бас заримдаа Арктикийн агаар нэвтрэн ирдэг. Иймд өвөл хүйтэн, хур тунадас бага, агаар тунгалаг байдаг. Зуны улиралд манай орны орны үр амьсгалын горим Сибирийн, Монголын, Хөх мөрний гэгддэг агаарын гурван массын нөлөөгөөр бүрэлдэн тогтдог. Манай улсад Агаарын тухай хуулийг 1995 онд батлан гаргасан билээ.

Хүйтэн, дулаан агаарын масс нүүж хоорондоо нийлэн, нэг нь нөгөөдөө шилжих тэр заагт шилжилтийн бус үүснэ. Үүнийг агаарын фронт (эгнээ) гэж нэрлэнэ. Энэ шилжилтийн бус нь хэдэн зуун, бүр хэдэн мянган км өргөн газрыг хамарч болно. Чухам ийм зааг дээр халуун хүйтэн агаар бие биедээ уусан шингэх бөгөөд энэ явцад тэр нутгийн агаарын температур, чийглэг, даралт эрс өөрчлөгднө.

Манай оронд дулаан агаар өмнөд талаас ирдэг бол хүйтэн агаар хойд талаас



37 дугаар зураг. Дулаан фронтын босоо зүсэлт.



38 дугаар зураг. Хүйтэн фронтын босоо зүсэлт.

орж ирдэг. Хүйтэн агаар руу дулаан агаар түрж орж буй үед **дулаан фронт** үүснэ. Ингэхэд дулаан агаар нь хөнгөн

учраас хүйтэн агаар дээгүүр хошууран хөөрөхдөө аажмаар хөрнө. Ингэж хөрөх үед агаар чийгээр ханаж усны уур




1. Дулаан, хүйтэн фронтод сэмжин үүл хэр өндөрт, фронтын шугамаас хэдий хэр зйтай газарт ажиглагдаж байна гэдгийг 37, 38-р зургаас үзэж ярилц!
2. Сэмжин үүл цаг агаарын ямар үзэгдлийн дохио болох вэ?
3. 38-р зургийг ажигла. Сэмжин үүл фронтын эхний зааг А цэгт хүртэл хэдэн км зйтай газарт хэдэн км өндөрт оршиж байна? Б цэг дээр хур тунадас бух хүртэл барагцаалбал хэдий хугацаа хэрэгтэй болох вэ? гэдгийг ярилцаж хариулаарай. (600-800 км зайд байна)

нь дусал болон өтгөрч тунадас унана. Дулаан фронт ўусэхэд нь дулаарч, үргэлжилсэн шиврээ бороо орно.

Дулаан агаар руу хүйтэн агаар шилжих үед хүйтэн фронт үүснэ. Хүйтэн агаар хүнд учраас дулаан агаар руу

түрэхдээ дулаан агаарын доогуур шургана. Ингэхэд дулаан агаар амархан хөрч аянгатай ширүүн аадар бороо орно. Хүйтэн агаар (фронт) ойртох үед өндрийн сэмжин үүл үүснэ. Үүнийг ажиглаж мэдвэл гэнэтийн их



39 дүгээр зураг. Азийн өвлийн агаарын даралтын байрлал

хүйтэн үерээс сэргийлж, мал, гэр орноо хамгаалж болно. Ингэж хамгаалж чадахгүй бол их хохирол амсдаг. Өвлийн улиралд манай оронд хойд туйлын хүйтэн агаар нэвтрэн ирж удаан хугацаагаар тогтох учир агаарын даралт ихэсдэг. Энэ их **даралтын муж нь** Увс, Хяргас нуурын хотгорт төвлөрөн байрлана.

Үүнийг **Азийн их даралтын төв** гэдэг. Улаангом хотод агаарын даралт 1-р сард 1055 гPa хүрсэн нь дэлхийн агаарын даралтын дээд хэмжээ юм.

Циклон ба эсрэг циклон. Циклон, эсрэг эсрэг циклон нь хийн мандлын том хуйлраа урсгалууд юм. Дундад өргөрөгт агаарын нам ба өндөр даралтын мужууд цаг үргэлж үүсэж байдаг ба тийм мужууд нь хэдэн мяняган километрийн диаметр бүхий газрыг хамарна.

Циклоны төвд даралт бага учир агаар өргөгдөх хөдөлгөөнд орж байдаг. Иймд усны уур өтгөрч тунадас орох боломж бүрдэнэ. Үүний учрыг тайлбарлаарай. Зуны цагт циклон үүсвэл үргэлжилсэн хур бороо ордог бол өвлийн циклон нь цас орох, цасан шуурга болох нөхцөл бүрдүүлнэ.




Циклон

- Төвдөө бага даралттай агаарын муж
- Агаарын хөөрөх хөдөлгөөн зонхилно
- Дээр гарсан агаар хөрнө
- Үүл үүснэ
- Тунадас унана
- Цаг агаар тогтвортой

Эсрэг циклон

- Төвдөө их даралттай агаарын муж
- Агаарын уруудах хөдөлгөөн зонхилно
- Агаар хална
- Үүл үүсэхгүй, тэнгэр цэлмэг
- Тунадас орохгүй
- Цаг агаар тогтвортой



40 дүгээр зураг. 1. Циклонд агаар
өгсөх хөдөлгөөнд орно

2. Эсрэг циклонд агаар уруудах
хөдөлгөөнд орно



1. Ойрын үед танай нутгийн цаг уурын байдал ямар байна вэ? Ямар агаарын масс ноёрхж байв? Энэ талаар яриарай.
2. Энэ сэдвийг үзэж буй өдрүүдэд танай нутагт ямар цаг агаар ноёрхж байна? Үүлшил, салхи, хур тунадасны байдлыг үндэслэн дүгнэлт гаргаж ярилц.
3. Яндангийн утаа их хургаж байвал ойрын 2-3 хоногт тэнгэр ямар байх вэ? Малдаа явахдаа ямар хувцас өмсөх вэ?



Эсрэг циклоны төв агаар дээрээс доош суух хөдөлгөөн ноёрхдог болохоор чийг өтгөрч хур тунадас унах нөхцөл бүрэлддэггүй, цэлмэг болдог. Учрыг тайлбарла. (Хариуг Дадлага ажлын номоос үз)



inter NET

<http://en.mongoliatoday.mn>
<http://www.mongolclimate.mn>
<http://www.coogle.com>
<http://www.olloo.mn>




ЦАГ АГААРЫН ЗУРАГ

Цаг агаарын байдлыг урьдчилан мэдэх нь малчин, тариаланч төдийгүй бүхий л ажил мэргэжлийн хүнд чухал асуудлын нэг бөгөөд улс орны эдийн засаг, ялангуяа хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд зайлшгүй хэрэгтэй юм. Ийм учраас өдөр болгон цаг агаарын мэдээний зураг зохиож хэрэглэдэг билээ. Ингэхдээ өөрийн болон зэргэлдээх улсын цаг уурын олон станцын мэдээг ашиглан энэ зургийг зохионо. Цаг агаарын зургийг зохиохдоо агаарын даралт, салхи, температур, хур тунадасны талаарх мэдээг цаг уурын станцуудаас

09, 12, 15 гэхчлэн гурван цаг тутамд авч зурагладаг. Ийм зургийг ашиглан цаг агаарын байдлыг тайлбарлаж байгааг бид өдөр болгон зурагтаар үздэг шүү дээ.

Цаг уурын байдлыг хоногоор, хэд хоногоор, сараар, улирлаар урьдчилан гаргаж болно.

Тэнгэр ямар байх вэ? гэдгийг манай ард түмэн өөрсдийн эрхлэн буй ажил, ахуй амьдралдаа олж авсан туршлага жишээ баримтаар урьдчилан мэддэг олон аргатай. Энд эдгээрээс цөөн жишээ дурдья.



41 дүгээр зураг. Цаг агаарын зураг



Тэнгэр сайхан байх шинж

- шөнө цэлмэг хүйтэн хонож, зун шүүдэр, хавар, намар, өвөл хяруу их унасан байвал
- гэрийн бүслүүр, олс, дээсэн татлага суларсан байвал
- утаа эгц дээшээ хөөрч байвал
- зуухны гал цайвар шаргал өнгөтэй байвал
- зун сарьсан багваахай үдэш удаан нисч байвал
- манан газарт бууж шингэвэл
- алтан хараацай дээгүүр нисч байвал
- бороо орж байхад адуу шилгээвэл
- мэлхий хөдөөлвөл
- солонго улаавтар өнгөтэй байвал
- том дугариг солонго гарвал
- бороо орж байхад тэмээ өөрөө бэлчвэл

Тэнгэр муудах шинж

- шүүдэр хяруу унах байх
- тогоо ямаахайтах
- хүний чих шуугих
- гэрийн бүслүүр, дээс, олсны эрч чангарах
- яндангийн утаа их хургах
- малын сүү шим муудвал
- зууханд гал улаан бөгөөд тас, няс хийн дуу гарган оч үсргэн асаж байвал
- үнс ширэмтвэл
- ямаа тургивал
- хурга зүүдэлбэл
- нохой тогловол
- тоншуул их дамарлаж байвал
- жирх зогисвол
- мал саравчиндаа хэвтээд байвал
- жижиг хүүхэд гарaa ээж байвал хүйтэрнэ.
- Нар сар чихлэн хүрээтвэл
- Манан хөөрвөл
- үүл сөрвөл
- элсэн чихэр, давс чийгтвэл



Улирал сайхан болох шинж

- үхэр оготно хөеөгөө зун орой бага хураавал өвөл сайхан болно.
- Тарваганы нүхний бөглөө бүлтгэр байвал өвөл цас багатай болно.
- Шувуу намар буцахдаа доогур нисч байвал өвөл сайхан болно.
- Тэнгэрийн оёдол намрын дунд сард алга болоод удалгүй гарч ирвэл өвөл сайхан болно.
- Намар од их гялалзаж, тод харагдаж байвал өвөл сайхан болдог.
- Намар мичид зулзагалбал өвөл сайхан болно.
- Хойд сараа даадаг 27-ны зурлага
- Намар цагаан морь, хонь өдөр дараагийн 60 хоногоо даадаг.....



Улирал хатуу болох шинж

- Үхэр оготно хөеөгөө эрт, их хураавал, хөөн дээрээ чулуу тавьсан байвал, намар нь салхитай, өвөл нь чанга болно.
- Тарваганы ичээний бөглөө цаана байвал өвөл нь цас ихтэй, эрт болно.
- Намар модны навч хагдралт хурдан болвол өвөл нь эрт болно.
- Шувуу буцахдаа дээгүүр нисч байвал өвөл чанга болно.
- Намар зээр нүүвэл өвөл нь чанга болно.

(Ш.Шагдар. "Тэнгэр ямар байх вэ?" УБ.1967
Х.Хангайсайхан. "Цаг уурын цагаан толгой" УБ.1991.Номоос дэлгэрүүлэн үз.)



42 дугаар зураг. 2005 оны 6 сарын 8-9-ны өдүрүүдийн цаг агаарын зураг



43 дугаар зураг. Хиймэл дагуулаас авсан цаг агаарын зураг (2005.07.9-13)



1. Дээрх цаг агаарын зургаас Монгол орны нутаг дээгүүр зурагдсан изобарын шугамыг ажиглаад агаарын даралтын ямар муж үссэн болохыг тодорхойл. Энэ үед цаг агаарын ямар төлөв байдал ноёрхох вэ? Ярилцаарай. Багшийн тусламжтайгаар таних тэмдгийг уншаарай!
2. Япон улсыг зураг дээр ол. Энд даралт ямар байна вэ? Изобарын шугамыгажиглаадхариулаарай. Монгол баяпоны агаарын даралтыг харьцуулж цаг агаарын төлөв байдлын ялгааг тодорхойл.
3. Агаарын фронт хаана үссэнийг ажиглаарай.
4. Цаг агаарын зураг зохиоход анхаарах зүйлс юу байж болох вэ? Зургаас ажиглаад, нэрлэж бичээрэй.
5. VI сард агаарын фронтын хил хаана байна вэ? Энэ үед тухайн нутаг оронд илэрч болох цаг агаарын үзэгдлүүд ямар байж болох талаар төсөөлөл гаргаарай.
6. 2-5 хоног өөрийн нутгийн цаг агаарын байдлыг ажиглаад цаг агаарын зураг болгон зур.



Манай зарим аймаг суманд улирал ямар болохыг шинжих ажлыг зохион байгуулдаг нь сонин юм. Жишээ нь: Дундговь аймгийн зүүн зүгийн сумд билгийн тооллын намрын дунд сарын 15-нд Говь-Угтаал сумын Хараат уулан дээр гарч шөнө ажиглан тэр хавь, ойролцоо нутагт өвөл ямар болохыг шинжих гаргасан дүгнэлт нь бараг таардаг гэнэ. Ийм ажиглалтыг нутаг нутагтаа хийж болох юм. Аль нэг газар дулаахан, хүйтэн байгааг мэдэрч болдог ч харин түүний хэмжээг харж чаддаггүй, харин хаана, ямар хэмийн дулаан, хүйтэн байгааг харах боломжийг газарзүйн зураг олгоно.




1. Тэнгрийн байдлыг урьдчилан мэддэг нутгийн ардын ажиглалтын шинж тэмдгүүдийг олж цуглуул!
2. Энд яригдсан шинж тэмдгүүдийн аль нь тохирч, аль нь тохирохгүй байгааг ажиглан шалгаж дүгнэлт гаргаарай.
3. Холын замд гарахаас өмнөх тэнгрийн байдлыг ажиглаж ойрын 2-3 хоногт тэнгэр ямар байхыг урьдчилан мэдэж аяндаа бэлдээрэй.
4. Малчид маргааш, нөгөөдөр тэнгэр ямар байхыг ажиглан урьдчилан мэдэж малаа билчээх зүгээ сонсох, өмсөх хувцсаа базаагаарай.
5. Хот суурин газар өвөл их утаатай байдгийн учир юу вэ?
6. Тэнгэр бүрхэг үед цаг агаарын байдал ямар байдаг талаар дүгнэж ярилцаарай.
7. “Борооны түрүүнд шороо
Боохойн түрүүнд хэрээ” зүйр үгийг үзсэн хичээлтэйгээ холбон тайлбарлана уу?
8. Монгол орон эх газрын эрс тэс уур амьсгалтай болохыг ямар шинж тэмдгүүдээр илэрхийлж болохыг бичээрэй.
Эх газрын уур амьсгал
Эрс тэс уур амьсгал
9. Манай оронд хавар цаг агаарын байдал маш их тогтвортгүй, бусад улирлаас их өөрчлөмтгийг байдаг. Учир нь юунд орших вэ?

16. АГААРЫН ТЕМПЕРАТУРЫН ХУВААРИЛАЛТ

Агаарын температурын хуваарилалтад газарзүйн өргөрөг, нарны цацраг, хийн мандлын орчил урсгал, газрын хотгор гүдгэр ихээр нөлөөлнө.

талдаа Булган голын хөндийгөөс Алтайн өврөөр явж, Ихбогд, Багабогд уулын араар тойрч, Бөөнцагаан нуурын хойгуур, Баянхонгорын урдуур, Арвайхээрийн араар зүүн тийшээ х.ө



44 дүгээр зураг. Нарны нийлмэл цацраг


Агаарын температурын хуваарилалтыг изотермийн тусламжтайгаар газарзүйн зураг дээрээс харж болно. Изотerm бол температурын ижил утгатай цэгүүдийг холбон зурсан муруй шугам юм. Үүнийг зурахын тулд цаг уурын станц бүр дээр хэмжсэн агаарын температурын тоон үзүүлэлт хэрэгтэй байдаг. Тоон үзүүлэлтийг зураг дээр тэмдэглэсний дараа ижил утгыг нь олж холбон зурах ба изотермийг сараар, жилийн дунджаар гэхчлэн гаргаж болно.

Манай нутаг дээр жилийн дундаж температурын 0°C -ын изотерм баруун

45-р зэргэдтэй бараг зэрэгцээ байдаг. Уг изотерм баруун талдаа уул ороож, гогцоорон тахирлаж, зүүн хэсгийн тал газраар шулуун харагдаж байгаа нь газрын гадаргын хотгор гүдгэрийн байдлаас хамаарч байгаа хэрэг билээ.


Жилийн дундаж температурын 0°C -ын изотерм нь YII сарын 20°C -ын изотермтэй бараг тохирч байдаг аж.

Манай Говь-Алтай, Баянхонгор, Өмнөговь, Дорнговь аймгийн нутгийн өмнөд хэсгийн жилийн дундаж температур 6°C , YII сарынх 24°C , I сарынх 16°C байдаг.



45 дугаар зураг. I сарын дундаж температур

Одоо хойд хэсгийн изотермийг авч үзье. Жилийн дундаж температур нь -6°C байдаг. Хангай, Хэнтий, Хөвсгөл, Алтайн уулсын дээд хэсгээр дундаж температур нь VII сард 12°C, I сард -24°C байдаг ажээ.



46 дугаар зураг. VII сарын дундаж температур


Манай улсын хэмжээнд хамгийн хүйтэн болдог нутаг нь Завханы Тосонцэнгэл, Улаангомх хавь, Увс аймгийн Зүүнговь сумын хавь нутаг бөгөөд энд -55°C -аас бууж хүйтрэх удаа бий. Хамгийн дулаан болдог газар нь Сайншанд, Чойбалсан хотууд, Эхийн гол юм. Энд VII сард $+40^{\circ}\text{C}$ -аас давж халах тохиолдол бий.

Монгол орны агаарын температур сүүлийн 60 жилийн дотор 1.5°C -аар дулаарсан байна. Энэ нь дэлхийн дулаараптай холбоотой юм.

Аймгийн төв, хотуудын 1, 7 дугаар сарын дундаж температурыг 1-р хавсралтаас үзээрэй.


Жилийн дундаж температур 45-р зэргэдээс урагших нутагт "+" тэмдэгтэй буюу дулаан хойших нутагт "-" тэмдэгтэй буюу хүйтэн байх магадлалтай, тийм ч байдаг.

Газар тариалан эрхлэхэд хүйтрэлгүй үеийн үргэлжлэх хугацаа болон хоногийн дундаж дулаан $+10^{\circ}\text{C}$ -аас дээших температурын нийлбэрийг авч үздэг.



Агаарын температурын
жилийн явц

1. Сайншанд
2. Цэцэрлэг



47 дугаар зураг. Агаарын температурын хоногийн дундаж дулаан $+10^{\circ}\text{C}$ ба түүнээс дээш байх өдрийн тоо.

Хүйтрэлтгүй үеийн үргэлжлэх хугацаа нь манай орны нутгийн хойд хэсэг болон уулсын дээд биед 50-аас цөөн хоног байхад хамгийн өмнөд хэсгийн нутагт 130-150 хоног байна.

Хүйтрэлтгүй хугацаа гэдэг нь хоногийн температур нь хасах тэмдэгтэй болохгүй хоногийн тоо юм. Ийм хугацаа нь 130 хоногтой байдаг нутгийн хойд хил нь жилийн дундаж температурын 4°C -ын изотермтэй бараг тохирч байна. Ургамал нь агаарын температур 10°C -ээс их болсон үед л ургадаг.

Иймд 10°C -аас дээших температурын нийлбэр хэд байх нь их чухал үзүүлэлт юм. Хоногийн дундаж температур нь 10°C -аас давах хоног манай орны хойд, өмнөд хэсэгт 100 ба 140 хоног байх бөгөөд энэ хоногуудын температурын нийлбэр нь 1000-2500 болдог. Энэ нь манай хадлан, бэлчээрийн ургацанд нөлөөлдөг учраас сарын өдөр бүрийн температурыг нэмж сарын нийлбэр температурыг гаргадаг. 10°C -аас илүү дулаантай хоногийн тоо Сайншандад 146, Улаанбаатарт 100, Мөрөнд 109 хоног байдаг.



Хоёр нутгийн температурын ялгаа нь, өргөргийн градусын ялгаатай тэнцүү байх магадлалтай. Жилийн аль ч өдрийн үдийн нарны тусгалын өнцөг **Орвог гашууны Бортолгойных Монгол шарын давааныхаас** $10^{\circ} 34'$ -аар их байх болно. Энэ нь үндсэндээ тухайн хоёр газрын өдрийн дулааны хэмжээ ийм ялгаатай байна гэсэн үг. Нарнаас ирэх илч дулааны хэмжээ нь үдийн нарны тусгалын өнцөгтэй шууд харьцаатай байна. Үүнээс үүдэн экватораас холдох тутам мөн дулаан багасдаг билээ.

Манай орны хамгийн дулаан нь Баянхонгор аймгийн **Шинэжинст сумын** нутаг (х.ө $43^{\circ} 15'$, з.у. 99°)-ын солбицолд орших **Эхийн голд** 44.8°C болсон бол хамгийн хүйтэн нь Увс аймгийн Зүүнговь суманд (х.ө $49^{\circ} 51'$, з.у. $93^{\circ} 47'$) -56.6°C хүрч, жилийн үнэмлэхүй их ба бага температурын агууриг нь 101.4°C хүрчээ.

Жилийн дундаж температур Эхийн голд 8.3°C , Баянхонгор аймгийн Гурванбулаг суманд (х.ө $47^{\circ} 13'$, з.у. $98^{\circ} 35'$) -8.3°C буюу дундаж агууриг нь 16.6°C ажээ. Энэ нь эх газрын эрс тэс уур амьсгалын тод илрэл юм.

Дэлхийн хуурай газрын жилийн дундаж дулаан 14°C байдагтай харьцуулж үзвэл манай нутаг илүү хүйтэн болох нь мэдэгдэж байна.

17. АГААРЫН ДАРАЛТЫН ХУВААРИЛАЛТ, САЛХИНЫ ГОРИМ


Монгол орон дэлхийн агаарын бага даралтын бүсэд оршдог боловч агаарын орчил хөдөлгөөн, туйлын фронт урагш, хойш шилжих, циклон, эсрэг циклон үүсэх үзэгдэл, тэдгээрийн байрлал, улирлын ялгаа зэргээс хамааран улирлаар өөрчлөгддөг. Агаарын даралтын хуваарилалтанд агаарын температур, гадарга, агаарын массын

шилжилт нөлөөлдөг.

Агаарын температур буурахад даралт ихэснэ. Температур нэмэгдэхэд даралт багасна. Өндөр ихсэхэд агаарын даралт 100 м тутамд 10 мб –аар буурна. Манай орны агаарын даралтын хуваарилалтыг улирлаар авч үзвэл эрс ялгаатай.




| Улирал | Температур | Даралт | Агаарын орчил |
|--------|----------------------------------|---------------------------------|-----------------------|
| Зун | Их (15°C - 25°C) | бага 1000 – 1008 мб | Циклон ноёрхно. |
| Намар | Тогтвортгүй, багасах хандлагатай | Тогтвортгүй, ихсэх хандлагатай | Циклон шилжилтийн |
| Өвөл | бага (- 15°C - (- 25°C)) | Их 1022 – 1054 мб | Эсрэг циклон ноёрхно. |
| Хавар | Тогтвортгүй, ихсэх хандлагатай | Тогтвортгүй, буурах хандлагатай | Шилжилтийн |



48 дугаар зураг. I сарын агаарын даралтын хуваарилалт




1. Алтайн нуруу, Их нууруудын хотгорын агаарын даралтын ялгааг зургаас харж учрыг тайлбарла



P_1 -д агаарын даралт 976 мб, уулын харьцангуй өндөр 400 м бол P_2 -ыг ол.

3. Цаг агаарын мэдээгээр үдээс хойш агаарын даралт буурна гэвэл чи хувцас хунаараа хэрхэн бодолцох ёстой вэ? Малдаа явахад юу анхаарах ёстой вэ?



49 дүгээр зураг. VII сарын агаарын даралтын хуваарилалт


*Амгүй байж уудаг
Амьгүй байж уйлдаг
Хөлгүй байж гүйдэг
Барихад баригдахгүй
Барилдахад дийлдэхгүй тэр юу вэ?*

Манай оронд салхи голдуу баруун хойноосоо зүүн урагшаа чиглэлтэй. Хаврын цагт эсрэг циклон арилж циклоны ажиллагаа идэвхжих үед салхины чиглэл өөрчлөгджэж эрч хүч нь

нэмэгдэнэ. Ялангуяа.gov, тал нутагт угаль хэмээх хүчтэй салхи, шороон шуурга болдог. Энэ нь манай орны хувьд байгалийн хөнөөлт үзэгдлийн нэг юм.

Манай хамгийн их салхитай аймгийнтөвнүү Мандалговь бөгөөд салхины хурд энд **40 м/с** хүрнэ. Хамгийн бага салхилдаг аймгийн төв нь Архангай аймгийн төв **Цэцэрлэг хот** бөгөөд энд хамгийн их нь **24 м/с** хүрнэ.

Хөвсгөл, Увс зэрэг том нуурын эргээр эргийн салхи, уулархаг газарт уул хөндийн салхи, Алтайн уулсад уулс даван салхилдаг халуун нөөлөг салхи зэрэг үүсдэг ба тэдгээрийг орон нутгийн салхи гэнэ.



50 дугаар зураг. Жилийн салхины дундаж хурд (Аймгийн төвүүдийн жилийн салхины дундаж хурдыг “Хавсралт 1”-ээс үзээрэй)



1. 48, 49, 50-р зургийг ашиглан танай нутагт агаарын даралтын дундаж утга I ба VII сард хэд байдаг, хэрхэн өөрчлөгддөг талаар бичиглэл хий.
2. Танай нутагт зүн ба өвлийн улиралд салхины зүг чиг хаанаасаа байж болох вэ? Үүнийг агаарын даралтын хуваарилалтын зургийг ажиглан тайлбарлаж бичээрэй.
3. I ба VII сарын агаарын даралтын зурагт дүрслэлийн ямар аргыг хэрэглэсэн байна вэ? Зураглалын аргын тухай үзсэнээ ашиглан (25 дугаар хуудас) тайлбарлаарай.
4. Өнөөдөр танай нутагт салхи хэр зэрэг хүчтэй, хаанаасаа салхилж байна? Ойрын хугацаанд салхины хүч, хурд чиглэл яаж өөрчлөгдөх вэ? Энэ өөрчлөлтийн нөлөөгөөр ямар байдал бий болов гэдгийг 3-4 өдөр ажиглаад дүгнэлт гаргаарай.
5. Яагаад манай оронд баруун зүгийн салхи зонхилдог вэ?

18. ХҮР ТУНАДАСНЫ ХУВААРИЛАЛТ

Хүр тунадас нь агаарт агуулагдаж байгаа чийгийн хэмжээнээс шалтгаална. Агаар нь байнга ямар нэгэн хэмжээний чийгтэй байдаг. Тэр чийгийг үнэмлэхүй чийг гэх ба граммаар илэрхийлнэ.

Тодорхой температуртай агаарын шингээж болох усны уурын дээд хэмжээг чийгийн **багтаамж** гэнэ. Жишээ нь: 1 шоометр агаар 0°C -тэй байхдаа 4.6 гр чийгийг шингээдэг бол

1 шоометр агаарын чийгийн багтаамж

| $t^{\circ}\text{N}$ | хэээä (äð) | $t^{\circ}\text{N}$ | хэээä (äð) |
|---------------------|------------|---------------------|------------|
| +25 | 23.8 | 0 | 4.6 |
| +20 | 17.5 | -2 | 4.0 |
| +18 | 15.5 | -5 | 3.2 |
| +15 | 12.8 | -10 | 2.0 |
| +13 | 11.2 | -20 | 0.8 |
| +5 | 6.5 | -40 | 0.1 |

температур нь ихсэн $+5^{\circ}\text{C}$ болоход шингээж чадах чийгийн дээд хэмжээ 6.5 гр болж нэмэгднэ.

Чийгийн багтаамж нь дээд хэмжээндээ тулсан агаарыг **чийгээр ханасан агаар** гэнэ.

Үнэмлэхүй чийгийг чийгийн багтаамжид харьцуулсан харьцааг **харьцангуй чийг** гэнэ. Манай оронд агаарын харьцангуй чийг 50-70% байдаг.


Харьцангуй чийг нь бүрэн ханавал зохих чийгийн хэдэн хувь нь байгааг харуулдаг үзүүлэлт юм. Температур буурахад чийгийн багтаамж багасаж харьцангуй чийг нэмэгддэг. Харьцангуй чийг нэмэгдэхэд тунадас унах нөхцөл бүрдэнэ.

Тунадасны хуваарилалтанд агаарын даралт, гадарга, агаарын орчил хөдөлгөөн нөлөөлнө.

Өвөл манай оронд тунадас бага, цасан бүрхэвч нимгэн тогтдог. Үүний учрыг их даралтын үед үүсэх агаарын хөдөлгөөнтэй холбон тайлбарлаарай. Агаарын даралт бага үед агаарын хөөрөх хөдөлгөөн явагдаж чийгийн багтаамж буурч тунадас орох нөхцөл бүрддэг. Зун манай оронд агаарын даралт бага, циклон тогтох учир тунадас ихэснэ. Орох тунадасны 80 хувь нь зуны улиралд орно.

51-р зургийг ажиглавал монгол орны хойд хэсэг, ялангуяа өндөр уулсын дээд хэсгээр тунадас их ордог нь тодорхой байна.

Мөн зургийг ажиглаж танай аймаг тунадасны хэмжээгээр улсын дотор ямар зэрэгт орохыг дүгнэж ярилц. Өндөр уулс чийгийг хааж, агаар өндөр уулыг өгсөхдөө хөрч хур тунадас орох нөхцөл бүрддэг.



Жилд унах тунадасны хэмжээ,


1. Сайншанд хот
2. Цэцэрлэг хот

Манай улсын аль ч нутагт унах хур тунадасны ихэнх хэсэг нь дулааны улиралд унадаг. Энэ нь нийт тунадасны 70 гаруй хувийг эзлэх бөгөөд зүн циклоны ажиллагаа хүчтэй болдогтой холбоотой.

Тунадасны дундаж хэмжээ жил жилд харилцан адилгүй байдаг явдал Монгол орны хур тунадасны горимын нэг онцлог юм. Өвлийн улиралд газар хөрч, агаарын даралт ихсэн агаартууруу-

нэвтрэн орж ирэх нь тунадас унах бас нэг нөхцөл болдог.

Улаанбаатар хотын ойролцоох Богдхан уулын 1600 орчим метр өндөрт орших Хүрэлтогоотын одон орны оргилд 659 мм тунадас унасан нь манайд тэмдэглэдсэн жилийн тунадасны хамгийн их хэмжээ юм. Гэтэл экваторын бүслүүрт жилд дунджаар 2000 мм тунадас ордог тухай өмнөх ангид үзсэн. Үүнтэй харьцуулахад ма-



51 дүгээр зураг. Жилийн тунадасны хуваарилалт

дах хөдөлгөөн ноёрхох учраас агаарт байсан чийг өтгөрөх нөхцөл бүрэлддэггүйгээс тунадас (цас) бага ордог.

Манай оронд жилд дунджаар 200-220 мм тунадас унана. Хангай, Хэнтий, Алтай, Хөвсгөлийн уулсад 500 мм, түүнээс ч их тунадас унадаг бол Дорнодын талд 200-300 мм, Говьд 100-150 мм тунадас унана.

Уулсын дээд биеid түүнээс ч их тунадас унах нь бий. Гаднаас чийгтэй агаар

най орон их хуурай газрын тоонд орно.

Харин Баянхонгор аймгийн Эхийн голд 36 мм тунадас унасан нь манайд хэмжигдсэн хамгийн бага хэмжээ юм.

Улаанбаатарт цасан бүрхүүлтэй байх хугацаа дунджаар 150 хоног байдаг бол Улаанбаатартай бараг нэг зэргэд дээр орших улсуудад 20-30 хоног байдаг. Өвөл манай орны хойд хэсэг, өндөр уулсын дээд биеэр

цас нилээд орж удаан хугацаагаар (5 сар гаруй) тогтдог бол өмнөд хэсгийн нутгаар цас бага орж 50 орчим хоног цасан бүрхүүлтэй байдаг.



1. Ангийн тасалгааны агаар одоо 20°C байна, 20°C -ын агаар 17.5 гр чийгээр ханах ёстай гэдэг нь 78 -р хуудасны хүснэгтээс харагдаж байна. Тасалгааны агаарын харьцангуй чийг хэвийн хэмжээнд буюу 60% байна гэж санавал ангийн агаарын үнэмлэхүй чийг ямар хэмжээтэй байх вэ? Бодож олоорой. (Хариуг Дадлага ажлын номоос үз)
2. Танай нутагт анхны цас, бороо хэдий үед ордог, цасан бүрхүүл хэдийгээс хэдий хүртэл тогтвортой байдаг, хэдий хэр зузаан байдаг вэ? Ажиглаж, тэмдэглэж аваад дүгнэлт гаргаарай.
3. Нутагтаа унадаг тунадасны хэмжээг цаг уурын станцаасаа авч сар сараар нь графикт зурж үзүүлэн дүгнэлт гаргаарай.



1. Хүйтэн улиралд гаднаас гэрт оруулсан сүх цантдаг, дулаан улиралд мөн гаднаас гэрт оруулж ирсэн дүүрэн устай бидон хувин хөлөрдгийн учрыг тайлбарлаарай. (Хариуг Дадлага ажлын номоос үз)
2. Алтай, Хангай, Хэнтий уулсаар яагаад тунадас их, Дорнодын тал, говьд яагаад бага унадаг вэ? Учрыг тайлбарла.
3. Манай орны хамгийн их болон хамгийн бага тунадас унадаг нутаг, хамгийн их хүйтэрсэн болон халсан газар нутгууд, хамгийн их салхитай газар орныг тэмдэглэж аваад тэдгээрт нөлөөлсөн хүчин зүйлүүдийг тодорхойлоорой.
4. Өнөөдөр цаг агаарын мэдээгээр агаарын температур $+20$ хэм, харьцангуй чийгшил 80% гэвэл үнэмлэхүй чийгийн хэмжээг тооцоолж гаргаарай.



Дээрвөн улирлын ялгаа

Дэлхийн гадарга дээр улирлын ялгаа газар бүр харилцан адилгүй. Зарим газар байнга зунаараа байхад зарим газар “мөнх” өвлөөрөө, зарим газар “борооны” ба хуурай улирал гэж ялгадаг бол зарим газар өвөл зуны дулаан хүйтний ялгаа төдийлөн их биш. Гэтэл сэргүүн бүсэд багтах орнуудад 4 улирал ялгарна.

Манайд 4 улирал эрс тэс ялгарахаас гадна өвөл, зуны температурын зөрөө бүр ч их, дунджаар 50°C -аас 60°C хүрдэг билээ.

Аргын тооллоор бол III, IV, V саруудыг **хавар**, VI, VII, VIII саруудыг **зун**, IX, X, XI саруудыг **намар**, XII.I.II саруудыг **өвөл** гэж тоолдог.

Билгийн тооллоор бол жилийг 4 урт, 24 бага улирал болгон хуваадаг. Энэ сэдвийг үзэж байх үед аргын ба билгийн ямар улирал явж байгааг бичээрэй.

Билгийн тооллын 24 улирал

| | Билгийн улирал | Харгалзах өдөр (аргын тооллоор) |
|-------|------------------------|---------------------------------|
| Хавар | Хаврын уур орох улирал | II.04-II.17 |
| | Хур усны улирал | II.18-III.04 |
| | Ичигсэд хөдлөх | III.05-III.19 |
| | Хаврын хугас | III.20-IV.04 |
| | Ханш нээх | IV.05-IV.19 |
| | Тариалангийн хур | IV.20-V.04 |
| Зун | Зуны уур орох | V.05-V.20 |
| | Өчүүхэн дүүрэн | V.21-VI.04 |
| | Буудай боловсрох | VI.05-VI.20 |
| | Нар буцах | VI.21-VII.06 |
| | Өчүүхэн халуун | VII.07-VII.22 |
| | Их халуун | VII.23-VIII.06 |
| Намар | Намрын уур орох | VIII.07-VIII.22 |
| | Сэргү орох | VIII.23-IX.06 |
| | Цагаан хяруу унах | IX.07-IX.22 |
| | Намрын хугас | IX.23-X.07 |
| | Хүйтэн шүүдэр унах | X.08-X.22 |
| | Хяруу унах | X.23-XI.06 |
| Өвөл | Өвлийн уур орох | XI.07-XI.21 |
| | Өчүүхэн цас | XI.22-XII.06 |
| | Их цас | XII.07-XII.21 |
| | Өвлийн туйл | XII.22-I.04 |
| | Өчүүхэн хүйтэн | I.05-I.19 |
| | Их хүйтэн | I.20-II.03 |


19. УУР АМЬСГАЛЫН НӨӨЦ

Үүр амьсгал нь газрын гадарга, ус зүй, хөрс, ургамал, амьтны аймагт нөлөөлөхөөс гадна хүмүүсийн эрхлэх аж ахуй, хүн амын суурьшил, ахуй амьдралд нөлөөлдөг.

Монголчууд эрт дээр үеэс жилийн дөрвөн улирлаа дагаж нүүдлийн мал аж ахуй эрхэлж ирсэн нь уур амьсгалын нөхцөлтэй холбоотой юм.

0,15 м/с, зун 0,2 - 0,4, м/с харьцангуй чийг 40-60 хувийн хооронд байвал тохиromжтой уур амьсгал гэж үздэг.

Үүр амьсгалын таатай нөхцөл бүрдсэн газар хүн амын нягтилт их байдаг нь зүй ёсны хэрэг юм. Жишээ нь: уур амьсгалын нөхцөл сайтай Орхон Сэлэнгийн сав газарт манай орны хүн амын 60 хувь нь нутаглаж байна.




Үүр амьсгалын нөхцөлөөс хүний эрүүл мэнд, ажиллах чадвар наслалт хамаардаг. Үүр амьсгалын нөхцөл хүн ба нийгмийн хөгжилд тааламжтай, бас тааламжгүй нөлөө үзүүлдэг. Жилийн дундаж температур $3^{\circ}\text{--}15^{\circ}\text{C}$, жилийн тунадасны хэмжээ 500-1500 мм-ийн хооронд байх нь хамгийн тохиromжтой уур амьсгал юм.

Харин сэрүүн өргөргийн хувьд температур өвөл -8°C –аас 10°C , зун $+23^{\circ}\text{C}$ –аас $+25^{\circ}\text{C}$, салхины хурд өвөл

Хэт халуун, хэт их хүйтэн, их чийглэг, ган зуд зэрэг нь уур амьсгалын хүнд нөхцөлд орно. Манай орны зарим нутагт өвөлдөө хэт хүйтэн, зундаа их халахаас гадна хур тунадасгүй хуурай байдаг нь үүнд хамаарлтай юм.

Хөдөө аж ахуйд уур амьсгалын нөлөө их байдаг. Жишээ нь: Харьцангуй дулаан.gov нутгаар тэмээ ямааны аж ахуй голлож байхад хангайн нутгаар үхрийн аж ахуй эрхлэхэд тохиromжтой.



Өвөлжөө хаваржаагаа барих, зуслангийн сууцаа барихдаа нөмөр дулаан, цас бага унадаг, үер усны аюулгүй газар барих нь үүр амьсгалын нөхцөлийг харгалзаж байна гэсэн үг юм.

Хаагуур ямар ургамал тариалах нь үүр амьсгалын нөхцөлөөс хамаарна. Манай орон урт өвөлтэй богино дулаан зунтай учир богино хугацаанд боловсордог ургамал тариалах нь тохиромжтой байдаг.

Зарим ургамлын ургах нөхцөл

| Ургамал | Шаардах дулааны нийлбэр ($^{\circ}\text{C}$) | Ургах нөхцөл |
|-------------|------------------------------------------------|--------------------------------------------------------|
| Арвай | 1300-1470 | Ургалтын хугацаа богино |
| Хошуу будаа | 1300-1600 | Тогтвортой ургац өгдөг |
| Буудай | 1600-1800 | Хүрэн, хар хүрэн хөрсөнд ургана, дулаан их шаардана. |
| Эрдэнэшиш | 700-1030 | Үс их шаарддаг, наран талын хажуугийн хөрсөнд |
| Төмс | 1100-1700 | Хол тээвэрлэхдэд тохиромжгүй тул хэрэглэгчтэй ойр байх |
| Наранцэцэг | 1750-2200 | Нарлаг хуурайттар орчинд гэрэл их шаардана |
| Өргөст хэмх | 1800-2000 | |
| Улаан лооль | 1800-2200 | |
| Хөх тариа | | Хөрс голдоггүй, чийг дулаан их шаардана |

10°C-аас дээш температурын нийлбэрийг агро уур амьсгалын нөөц гэнэ. 10°C-аас дээш байх өдрийн тоо манай өмнөд хэсэгт 150 хоногоос их, хойшлох тутам буурдаг. Гэвч өмнө талын нутгууд дулааны хангамж сайтай боловч тунадас чийг багатай байдаг нь газар тариалан эрхлэхэд саад болдог.

Уур амьсгалын нөхцөлийг тодорхойлоход температурын үзүүлэлтээс гадна чийгийн хангамж ямар байхыг тодорхойлох шаардлагатай. Чийгийн хангамжийг тодорхойлдог гол үзүүлэлт нь чийглэгийн итгэлцүүр (коэффициент) юм. Чийглэгийн итгэлцүүрийг дараах томъёогоор олно.



$$K = \frac{P}{E}$$

K - чийглэгийн итгэлцүүр


P- тунадасны хэмжээ

E- уурших чадвар

Чийглэгийн итгэлцүүр нь 0,3 –аас доош бол чийгээр дутмаг
0,3 – 0,6 бол хангалттай биш хуурайвтар
0,6 - аас дээш бол хангалттай гэж үздэг.

Жишээ нь. Цэцэрлэг хотод 338 мм тунадас унадаг. Уурших чадвар нь 632 мм байгаа тул чийглэгийн итгэлцүүр 0.53 болно. Харин Даланзадгад хотод 130 мм тунадас унадаг. Ууршилт 1304

мм байдаг болохоор чийглэгийн итгэлцүүр нь 0.01 буюу маш хуурай байгааг илэрхийлнэ. Зохих дулааны нөхцөлд ууршиж болох чийглэгийн хэмжээг уурших чадвар гэнэ.



52 дугаар зураг. Жилд уурших чадвар



ЧИЙГЛЭГИЙН ИТГЭЛЦҮҮР

| Аймгийн төвүүд | E (мм) | P (мм) | K | Аймгийн төвүүд | E (мм) | P (мм) | K |
|----------------|--------|--------|------|----------------|--------|--------|------|
| Өлгий | 720 | 107.1 | 0.15 | Даланзадгад | 1304 | 132.5 | 0.1 |
| Улаангом | 728 | 135.3 | 0.18 | Сүхбаатар | 630 | 304.7 | 0.48 |
| Ховд | 910 | 119.0 | 0.13 | Зуунмод | 648 | 270.8 | 0.42 |
| Улиастай | 681 | 217.0 | 0.32 | Мандалговь | 915 | 163.8 | 0.18 |
| Алтай | 671 | 176.9 | 0.26 | Өндөрхаан | 762 | 254.2 | 0.33 |
| Мөрөн | 711 | 234.5 | 0.33 | Сайншанд | 1257 | 116.1 | 0.09 |
| Цэцэрлэг | 632 | 344.0 | 0.54 | Чойбалсан | 811 | 246.0 | 0.3 |
| Баянхонгор | 561 | 216.3 | 0.38 | Баруун-Урт | 910 | 191.7 | 0.21 |
| Булган | 791 | 324.3 | 0.4 | Улаанбаатар | 648 | 233.0 | 0.36 |
| Арвайхээр | 791 | 254.2 | 0.3 | | | | |

Хур тунадас нь хадлан бэлчээрийн нөөцөд нөлөөлдөг. Тунадас бага унаж халуун болсноос ган болох, өвөл цас их унаж хүйтэрснээс зуд болох зэрэг байгалийн гамшигт үзэгдэл тохиолдох нь аж ахуй, эдийн засаг, хүмүүсийн

амьдралд их хор уршиг учруулдаг.

Дулаан агаар чийг агуулах чадвар ихтэй боловч зүн хур тунадас их унадаг явдал зөвхөн үүнээс хамаарах биш, харин гаднын чийглэг агаар нэвтрэн орж ирдэгтэй бас холбоотой юм.

ҮҮР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ

ХХ зууны үүр амьсгалын дулаарагалтын нэг үндсэн шалтгаан нь хүний үйл ажиллагааны улмаас агаар дахь хүлэмжийн хийн агууламж ихсэж байгаа явдал юм.

Хүлэмжийн хий нь нарнаас ирэх богино долгионт цацрагийг дэлхийн гадарга руу шууд нэвтрүүлдэг хирнээ дэлхийн гадаргаас эргэн туярах урт долгионт цацрагийг шингээж хуримтлуулан тогтоож барьdag. Ингэснээр газрын гадарга орчмын агаарын температур нэмэгддэг. Хүлэмжийн хий гэдэгт нүүрсхүчлийн хий (CO_2), намгийн хий (CH_4), азотын дутуу эсэл (N_2O), орчих мандлын озон, фреоны төрлийн хийнүүд орно.

Озон нь газрын гадаргаас 20 гаруй мянган метрийн өндөрт орших ба нарны хэт ягаан тuyaаг шингээн авдгаараа түүний хорт үйлчлэлээс биднийг хамгаалж байдаг.

ХХ зууны сүүлчээр Антарктид дээр үссэн озоны цоорхой жилээс жилд улам томорч байгаа бөгөөд хойд туйлын дээр озоны давхаргын хэсэг нь нимгэрч улмаар Япон, Монгол, Сибирь рүү тэлж болзошгүй тухай эрдэмтэд мэдээлжээ. Антарктид дээр озоны цоорхой үссэндийн дараа улс орнууд хуралдаж, озон задалдаг бодисын хэрэглээг хязгаарлах тухай “Венийн конвенц” “Монреалын хэлэлцээр” байгуулсан билээ.



53 дугаар зураг. Нуурын ус хатахад ёроолын лаг нь шал болон үлдэнэ

Үг хэлэлцээрт Монгол Улс 1996 онд нэгдэн орж, 1999 оноос Озоны давхаргыг хамгаалах Үндэсний хөтөлбөрийг батлан хэрэгжүүлэх талаар үе шаттай арга хэмжээ авч байна.

Үүр амьсгалын хувиралт, өөрчлөлт болон хүний хүчинзүйлсийн шуудбадам нөлөөгөөр сүүлийн дөчөөдхөн жилийн дотор Монгол орны экосистемд мэдэг-дэхүйц өөрчлөлт орж, энэ нь цөлжилт, байгалийн гамшгийн давтамж, хөнөөл идэвхжих, усны нөөц, биологийн төрөл зүйл хомсдох зэргээр илэрч байна.

Монгол орны хэмжээнд цаг уурын ажиглалт хийсэн сүүлийн 62 жилийн

хэмжилтийн мэдээг дундажлан сараар авч үзвэл 4 болон 8 дугаар саруудад тодорхой дулааралт, сэргүүсэлт илрээгүй боловч, жилийн дундаж агаарын температур 1.56°C , өвлийн улиралд 3.6°C , хавар, намрын улиралд $1.4^{\circ}-1.5^{\circ}\text{C}$, зуны улиралд 0.3°C -аар тус тус дулаарсан байна.

Дулааралт нь жилийн хүйтэн улиралд эрчимтэй, дулааны улиралдаа сулхан, тухайлбал, 1 дүгээр сарын дундаж температур 2.3°C -аар, 7 дугаар сарын дундаж температур 0.7°C -аар тус тус дулаарч байгааг нотолжээ.



Хөвсгөл нуурын эрэгт элс хуримтлагдаж эхэллээ (2005 он)



- Манай орон далайгаас алс хол, өндөр уулсаар хүрээлэгдэн их өндөрлөгт оршдог учраас эх газрын эрс тэс үүр амьсгалтай болсон
- Арктикийн, сэргүүн бүсийн, дулаан орны агаар нөлөөлдөг
- Циклон, эсрэг циклон орж ирдэг
- Дэлхийн хойд хагасын өвлийн агаарын их даралтын төв үүсдэг
- Цаг уурын байдлыг урьдчилан мэддэг олон шинж тэмдгийг монголчууд мэддэг
- Манай нутгийн дундуур х.ө.45°-ын зэргэд өнгөрдөг бөгөөд энд жилийн дундаж температур 0°C, энэ зэргэдээс урагш "+" (нэмэх), хийш "-" (хасах) тэмдэгтэй байх магадлалтай.
- Нутгийн өмнөд хэсэгт арай дулаан, хойд хэсэгт сэргүүн болдог
- Өмнөөсөө хойшоо температур буурна
- Хур тунадас манай нутгийн хойд хэсэгт их, өмнөд хэсэгт бага унадаг
- Салхи манай орны хойд хэсэгт арай бага, өмнөд хэсэгт их гардаг.



1. Танай нутагт ургамлын ургалт, гандалт, цэцэглэлт, гол урсах, үерлэх, хөлдөх, шувуу буцах, тарвага ичих гэх зэрэг ургамал амьтны буюу байгалийн үзэгдлийн өөрчлөлтөөр үзэгдэлзүйн улирлыг ялгах боломж байна уу? Орон нутгийн тийм шинжээр улирлыг ялгах гэж оролдоорой.



1. Танай нутагт билгийн тооллын ямар улирал аж ахуйн ямар үйл ажиллагаа явагддагийг ярилцаж бүртгэж тодруулж ав. Худаг гаргах, мал төллөх, ноослох, мал хөнгөлөх, гүү барих, морь уях, унага тамгалах, арьс сур элдэх, хөрзөн гишгэх, хороо барих, самар, жимс түүх, идэш гаргах гэх мэт
2. Дараах хүснэгтийг ашиглан 10°C -аас дээших температурын нийлбэрийн изотермийг Монгол орны нэргүй зураг дээр зураарай.



Агаарын температурын 10⁰-С-аас дээшихийн нийлбэр

| Станцын нэр | T 10 ⁰ С-аас дээш | Станцын нэр | T 10 ⁰ С-аас дээш | Станцын нэр | T 10 ⁰ С-аас дээш |
|-------------|------------------------------|-------------|------------------------------|-------------|------------------------------|
| Алтай | 1177 | Баянхонгор | 1617 | Чойбалсан | 2202 |
| Мөрөн | 1619 | Сүхбаатар | 2018 | Ховд | 1496 |
| Улиастай | 1411 | Мандалговь | 1929 | Даланзадгад | 2628 |
| Булган | 1616 | Баруун-Урт | 2128 | Сайншанд | 2723 |
| Цэцэрлэг | 1341 | Өндөрхаан | 2009 | Улаанбаатар | 1566 |
| Арвайхээр | 1588 | Улаангом | 2105 Σ | | Σ |

3. 10⁰С-аас дээшлэх дулааны нийлбэр их байгаа нутгуудыг зургаасаа ажиглан уур амьсгалын ямар нөөц нь илүү байгааг тодорхойлж шалтгааныг тайлбарла.
4. Чийглэгийн итгэлцүүрийг цаг уурын станц болгон дээр тэмдэглэж зурсан зурагтайгаа харьцуулна уу.
5. Наранцэцг ба арвай тариална гэвэл ямар нутгийг сонгон авах нь тохиромжтой байж болох вэ? Дүгнэлт гаргаарай.
6. Цаг агаарын элементүүдийн хоорондын хамаарал нь цаг агаарын мэдээнд хэрхэн тусдаг талаар дүгнэлт хийнэ үү. Харьцангуй чийг нь багасвал агаарын температурт нөлөөлөх үү? Агаарын даралт ихэсвэл хур тунадасанд нөлөөлөх үү? Температур, чийг, тунадасны хамаарал нь зохимжтой үед салхи ямар байхыг жишээгээр тайлбарлаж ярилцаарай.



inter NET

<http://en.mongoliatoday.mn>
<http://www.mongolclimate.mn>
<http://www.coogle.com>
<http://www.olloo.mn>
<http://www.mne.mn>

МОНГОЛ ОРНЫ УСНЫ НӨӨЦ

6

Гол агуулга

- Гадаргын ус, гол мөрд
- Голын тэжээл, горим, гол мөрдийн ач холбогдол
- Нуур, намаг,
- Мөсөн гол, олон жилийн цэвдэг
- Газрын доорхи ус, рашаан

Юу мэддэг болох вэ?

- Монгол орны гадаргын усны нөөц, түүний тархалт болон гол мөрдийн тэжээлийн горим, ашиглалтын тухай
- Манай орны нууруудын хонхорын гарал үүслийн ялгаа, тэжээл, дулааны горимын онцлог
- Мөсөн гол, олон жилийн цэвдгийн тархац, усны нөөцийн хэмжээ
- Рашаан амьдрал, аж ахуйд ямар ач холбогдолтой талаар мэдэж авна

Юу чаддаг болох вэ?

- Монгол орны гадаргын усны тархацыг газарзүйн бусад хүчин зүйлстэй нь холбон тайлбарладаг болох
- Нутаг орныхоо гол мөрөн, нуурын горимыг тодорхойлж чаддаг болно.

Мэдлэгээ хэрхэн хэрэглэх вэ?

- Нутгийнхаа булаг шанд, гол горхийг цэвэр байлгах, зөв ашиглах дадалд суралцах
- Ус, намгийн ойролцоо амьдарч байгаа үедээ уснаас тохиолдож болзошгүй эрсдэлээс сэргийлж чаддаг болох
- Рашаан усыг зөв хэрэглэж сурх зэрэг чадвартай болно.


20. ГОЛ МӨРӨН

Гол мөрөн, нуур намаг, газар доорх ус, мөстлөг, мөсөн гол, олон жилийн цэвдэг, хиймэл усан сан, цөөрөм зэрэг нь бүгд усны нөөцийг бүрдүүлдэг.

Усны нөөцөд хамгийн гол нөлөөлөх хүчин зүйл нь уур амьсгал боловч газрын гадарга, хөрс ургамал болон хүний үйл ажиллагаа нөлөөлнө. Иймд усны нөөц, түүний хэрэглээ зэрэг нь байгаль нийгмийн бүрэлдэхүүн хэсгүүдийн харилцан холбооноос хамаарна.

Манай орны гол мөрд Дэлхийн усны Зай савд хамарагдана. Алтай, Хэнтий, Хангайн уулс нь Номхон далайн, Хойд мөсөн далайн, Төв Азийн гадаш урсгалгүй ай савыг зааглаж байдгаараа дэлхийн усны хагалбар болдог.

Дэлхийн гурван том далайн ай савд багтдаг нь том эх газрын гүнд оршдог манай улсын хувьд нэгэн онцлог тал юм. Усны Зай савын зааг болдог




Ус, хүн, байгалийн харилцан холбоо

Манайд байнгын урсгалтай гол горхи 3800 орчим байдаг ба нийт урт нь 67.000 км хүрнэ. Гэвч гол мөрдийн тархац нь нутаг дэвсгэрт харилцан адилгүй, жигд биш юм. Алтай, Хангай, Хэнтий, Хөвсгөлийн уулсаар гол горхи элбэг байдаг бол Дорнодын тал, Говь нутагт ховор.

газар нь Хэнтийн нурууны баруун урьд төгсгөлд Богдхан уулнаас зүүн урагш орших Цогтчандмань уул болно.

Манай нийт урсацын хагас хувийг эзлэх ус ихтэй томоохон гол мөрдийн ихэнх нь Сэлэнгэ мөрөн, Байгаль нуур,



54 дүгээр зураг. Монгол орны гол мөрдийн ай сав

Енисей мөрнөөр дамжин Хойд мөсөн далайд усаа нийлүүлдэг. Гэтэл зүүн зүгт урсах талын том голууд болох Онон, Хэрлэн, түүний цутгалууд Амар мөрөн болон Далай нуураар дамжин Номхон далайд хурдэг. Номхон далайн ай

савын гол мөрд нь урсацын ч, талбайн ч бага хувийг эзэлдэг юм. Гадаад далайд усаа өгдөггүй “Эх оронч” голууд болох Тэс, Байдраг, Ховд зэрэг нь Төв Азийн гадагшаа урсгалгүй ай савд хамарагдана. Эдгээр ай сав тус бүрд багтах



Монгол орны гол мөрдийн ай сав

| Ай сав | Хамрагдах зарим гол мөрд | Эзлэх хувь урсацын | Эзлэх хувь талбайн |
|------------------------|---------------------------------------------------------------------------|-----------------------|-----------------------|
| Хойд мөсөн далайн | Сэлэнгэ, Орхон, Эг, Дэлгэр, Идэр, Чулуут, Хануй, Шишгэд, Алтайн Хуримт | 50 | 20 |
| Номхон далайн | Онон, Хэрлэн, Улз, Халхын гол | 15 | 12 |
| Төв азийн урсгалгүй | Завхан, Ховд, Тэс, Байдраг, Булган, Хүнгүй, Онги, Таац, Үенч, Бодонч | 31 | 68 |

гол мөрд, тэдгээрийн урсац ба нийт талбайн эзлэх хувийг 92-р хуудасны хүснэгтээс үзээрэй. Ямархуу дүгнэлт гаргаж болохоор байна вэ?


Гадаргын усны тархац нь уур амьсгалаасаа хамаараад жигд биш байдаг. Монгол орны өмнөд ба зүүн

хэсэгт гадаргын ус ховор. Баруун хэсэг болох Их нуурын хотгорт Тэс, Нарийн, Завхан, Хүнгий, Боршоо, Торхлог, Хөндрөн, Хархираа зэрэг голын адаг орж ирэх бөгөөд Хангай нурууны өврийн Баганууруудын хотгорт Байдраг, Таац, Түй, Онгийн голын


адаг, Алтайн өвөр говьд *Булган*, *Үенч*, *Бодонч*, *Барлаг* голуудын адаг орж ирнэ. Дорнодын талаар Монголын том мөрөн *Хэрлэн* гол урсах ба *Хэрлэн* голд *Мөрөн*, *Цэнхэрийн* гол зэрэг том цутгалууд бий. Хойд хэсгээр нь Улз гол

урсана. Зүүн өмнөд хэсэгт нь *Чоно* гол, *Харгилтай*, *Хонгорын*, *Бичигтийн* зэрэг голууд урсана.

Монгол орны хойд хэсэг чийглэг уур амьсгалтай учраас гадаргын ус-гол мөрөн нуур элбэгтэй болжээ.



55 дугаар зураг. Онон гол



56 дугаар зураг. Орхон хүрхрээ

Хангайн ба Хэнтийн уулсад гол горхи элбэг.


Онон гол Монголын эртний домогт гурван голын нэг. *Их хэнтийн* нурууны араас эх авч 289 км урсан гарч *ОХУ-ЫН Шилка* голд цутгадаг их устай гол. Ай сав нь 40200 ам км. *Эг*, *Барх*, *Хурх*, *Шуус*, *Агац*, *Хирхон* голууд цутгадаг.

Орхон голын баруун гарын цутгал Улаанголд үүссэн 20 гаруй метрийн өндөрөөс буух хүрхрээ нь манай орны хамгийн том хүрхрээ юм. Орхон гол энэ хавь нутагтаа 20 гаруй м гүн, 100 гаруй метр өргөн хүрмэн чулуун ханан эгц хавцал дундуур урсдаг. Хангайн арын *Ханбаян* болон бусад галт уулуудыг дэлбэрэхэд магма нь Орхон голын хөндий даган зүүн хойшоо зуугаад км урссан байна. Энэ магма царцахад түүн дээгүүр Орхон гол хөрөөдөн элээж урссаар энэ хавцлыг бий болгожээ.

Манай орны хамгийн том гол болох Сэлэнгэ мөрөн ойт хээрийн бусийн нутгийн тэн хагасаас илүү буюу 282000 ам км. талбайгаас усжиж, Хойд мөсөн далайд усаа өгнө.

Дэлгэр мөрөн, Идэр гол, Бүгсэй голын бэлчирийг олон голын бэлчир гэх бөгөөд чухам эндээс Сэлэнгэ мөрөн гэдэг нэр эхэлж улсын хил хүртэл 593 км урт урсана. Усны нөөц

ихтэй. Жилийн урсацын хэмжээ нь 15.3 шоо км буюу манай орны бүх гол мөрний урсацын бараг 50%-ийг эзэлнэ. Сэлэнгийн том цутгалууд нь Эг, Хүнүй, Хануй, Орхон голууд бөгөөд хамгийн том цутгал нь Хараа, Ерөө, Туул, Тамир голуудыг нийлүүлж авдаг Орхон гол болно. Сэлэнгэ мөрөнд нэн ховор хилим загас амьдардаг.



57 дугаар зураг. Сэлэнгэ мөрөн, Орхон голын бэлчир



1. 91-р хуудсан дахь хүснэгтээс дүгнэлт гаргаж бичээрэй. Хойд мөсөн далайн ай савын голууд талбайн ихэнхийг эзлэх боловч урсацын хагас хувийг эзэлдэг нь юутай холбоотой вэ?
2. Монгол орны физик газарзүйн зураг болон тунадасны хуваарилалтын зураг ашиглан Хэрлэн, Орхон голууд хэдий хэр тунадас унадаг газраас эх авсан байгааг тодорхойлно уу.
3. Голын эх адаг хоёрын өндрийн зөрөөг голын унал гэдэг бөгөөд түүнийг метрээр илэрхийлдэг. Хэрлэн, Орхон голын уналыг тодорхойлоорой.
4. Танай нутгаар ямар ямар гол горхи, булаг урсдаг вэ? Усны хэмжээ, үерлэдэг хугацаа ба их үерлэж байсан баримтын талаар ярилцаарай!



- Гол мөрдийн ихэнх нь өндөр уулнаас эх авдаг боловч Говь-Алтайн нуруунаас эх авсан том гол байхгүй байгаагийн учрыг тайлбарлаарай. (Хариуг Дадлага ажлын номноос үз)

21. ГОЛЫН ТЭЖЭЭЛ, ГОРИМ, ГОЛ МӨРДИЙН АЧ ХОЛБОГДОЛ ■

Манай гол мөрд борооны болон мөсөн голын ус, газар доорх усаар тэжээгдэнэ. Гол мөрдийн усны түвшин улирлаас их хамаардаг. Ихэнх голын хувьд үер гурван төрөл байдаг. Үүнд:

- Зуны цагт бороо их орсон үед гол горхины ус ихсэн заримдаа үерлэдэг. Ер нь бүх урсацын 60-80% нь зуны борооны үед ноогдоно.
- Хавар цас мөс хайлж цөн түрэх үед гэнэтийн үер үүснэ. Үүнийг шар усны үер гэнэ.
- Мөнх цастай өндөр уулнаас эх авсан голууд зуны их халуун өдөр бороогүй байсан ч үерлэнэ. Энэ нь уулсын оройн цас мөс хайлснаас болж байгаа хэрэг.

Газрын доорх ус нь манай гол мөрдийн тэжээлийн 25-40%-ийг бүрдүүлдэг. Говийн горхи бараг дан ганц газар доорх усаар тэжээгдэнэ.

Манай орон хүйтэн урт өвөлтэй учраас голууд 5-6 сарын туршид 80-120 см зузаан мөсөөр хучигдаж байдаг. Жижиг гол горхи гүехэн болохоор ёроолоо хүртэл хөлдөх явдал бий. Ихэнх голууд IV сарын дундуураас захлан урсаж ханзарч цэлмэн, намар XI сарын эхээр зайр гүйж удалгүй хадаална.

Гол мөрний урсац зуны улиралд ямагт их байдаг боловч ялгаатай. Хөвсгөлийн баруун хэсэг, Хангайн баруун хойд хажуугийн голуудад жилийн урсацын ихэнх нь 5-6 дугаар сард бүрэлдэнэ. Хэнтii, Хангайн голуудад V сараас урсацын хэмжээ нэмэгдэж хамгийн их нь VII, VIII сард ажиглагдана.

Хамгийн их зарцуулга хур борооны үерийн үед голдуу ажиглагдана. Хэнтii, Хөвсгөл орчмын голууд ихэвчлэн борооны усаар үерлэх боловч зарим жил цасны усны гаралтай шар усны үер тохиолдоно. Хөвсгөлийн баруун хэсгийн болон Хангайн нурууны баруун хойд хажуугийн голууд зуны хур бороо, хаврын цасны усаар үерлэх тохиолдол бараг тэнцүүхэн юм.

Шар усны үер манай хангай нутагт их тохиолддог. Үүнээс сэргийлж голын татмаас зайдуу нутаглах, голын эргээс хол буух хэрэгтэй юм.

Монгол Алтайн голуудын зарцуулга өндөр уулын цас мөс хайлах үед болно. Гол мөрний хамгийн бага урсац өвлийн цагт ажиглагдана. Манай орны өмнөд хэсгийн голууд зундаа ихэвчлэн тасалддаг.

Манай орон газар нутгийн хувьд өндөрлөг, усны гурван том хагалбарт оршдог учраас хур тунадас тогтдоггүй, гол мөрдийн ус ихэнхдээ улсын хилээс гадагшаа урсдагаас болж усны нөөцөөр бага, хязгаарлагдмал, дэлхийн орнуудын дунджаас доогуур юм.

Гол мөрдийн усыг ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар өргөн хэрэглэдэг бөгөөд зарим голууд дээр усан цахилгаан станц байгуулж, улирлын чанартай ашиглаж байна. Сэлэнгэ зэрэг томоохон голууд дээр усны аялалыг өргөнөөр зохион байгуулдаг болжээ.



- Нутгийн гол горхины хавар ханзрах, цөн түрэх, цэлмэх, намар зайр гүйх, хадаалах хугацааг ажиглаж тогтоо! Хаврын цөн түрэх үед үйлддэг уламжлалт зан үйлийн тухай ярилц. Цөн төрөх үеийг ажиглан голын зуны урсацын талаар урьдчилан хэлдэг шинж тэмдгүүдийг цуглувж зун шалгаж үзээрэй!



- Газарзүйн зураг ажиглан урсгалын чиглэлээ огцом өөрчилсөн З голыг олж, шалгааныг тайлбарлаарай. (Хариуг Дадлага ажлын номноос үз)
- Тунадасны хуваарилалтын зургийг ажиглан хамгийн их устай байж болох голуудыг нэрлэн дүгнэж ярилцаарай.

22. НУУР, НАМАГ

Нуур бол байгалийн нэг өвөрмөц бүрэлдэхүүн хэсэг билээ. Манай орон 4000 орчим нууртай. Тэдгээрийн нийт талбай улсын бүх нутаг дэвсгэрийн 1 орчим хувийг эзэнлнэ. Бүх нуурын 85 хувь нь 1 км² хүртэл талбайтай жижиг нуурууд бөгөөд дөнгөж 0,2% нь 1000 км²-аас их талбайтай. Гэвч эдгээр хэдхэн том нуурын талбайн нийлбэр нь нийт нуурын талбайн 58,6%-тай тэнцэнэ.

Нуурын тархалт тун жигд биш, ихэнх томоохон нуур нь Монгол орны бааруун ба хойд хэсгийн уулс хоорондын хотгор хонхорт, тухайлбал Их Нууруудын хотгорт голчлон тархжээ.

Говийн бүсэд нуур элбэг. Том нуурууд болох Увс, Хяргас, Хар-Ус, Хар, Дөргөн, Бөөнцагаан, Орог, Улаан, Таацын цагаан нуурууд энэ бүсэд оршино.

Нуурыг *усны горимоор* нь урсгал ба тогтмол, *химиин найрлагаар* нь цэнгэг, давстай, шорвог хэмээн ангилна.

Ямар нэг гол горхи урсан гардаг нуурыг *урсгал нуур* гэнэ. Хөвсгөл, Толбо, Тэрхийн Цагаан, Хоргон, Хагийн Хар нуур нь урсгал нуур юм. Урсгал нуур цэнгэг устай байдаг.



58 дүгээр зураг. Хөвсгөл нуур

Ямар ч гол горхи урсан гараагүй нуурыг тогтмол нуур гэнэ. Увс, Улаан, Бөөнцагаан, Тэлмэн, Хөх гэхчлэн тогтмол нуур шорвог устай юм.

Нуурын усанд хлорт натри зэрэг олон төрлийн давс уусна. Дорнодын Сангийн далай нуурт эрдэсжилт нь 300 г/л хүрдэг. Иймд Сангийн далай, Говь-Алтайн Буур, Завханы Цавдан, Өмнөговийн Гурвантэс нуураас хоолны давс олборлодог. Улаан, Оrog, Өөшийн Цагаан зэрэг говьд орших нуурууд бороо хуртай жил ус ихтэй, гандуу жил нь ус багасан, бүр ширгэх явдал ч бий.

Манай ихэнх нуурын усны түвшин VII, VIII сард эрс дээшилж хоёроос дөрөвдүгээр сарын турш тогтвортой өндөр байгаад X сараас эхлэн огцом буурдаг. Үргал нуурын усны түвшний жилийн хэлбэлзэл 30-80 см байна.

Нуурын усны дулааны горимын өөрчлөлт жилийн турш харьцангуй нэг

хэвийн байна. Ууланд ч тэр, тал газарт ч тэр, нуурын усны температур өвөл, хавар ихээхэн өөрчлөгдж III сараас эхлэн V, VI сар хүртэл алгуур нэмэгдсээр VII, VIII сард хамгийн их хална.

Монгол орны нуурууд усан хангамжид ашиглах бололцоотой 500 шоо км гаруй ус агуулж байдаг нь бүх голын урсацаас бараг 15 дахин их юм. Бас загас, давсны нөөцөөр баялгаас гадна эмчилгээний чанартай эрдэс, шавар агуулдаг (Цайдам, Тосон, Гурваннуур зэрэг) нуур ч цөөнгүй бий.

Дорнодын талархаг хээрийн бүс дэх олон нууруудаас хамгийн том нь 615 ам км.талбай бүхий Буйр нуур юм. Энэ орчимд нэн ховор шувуу гургуул, гангар хун амьдардгаас гадна Буйрт цагаан амар загас, хошуу галуу зэрэг ховор амьтад бий. Бусийн хойд захад Хөх нуур, Хайцийн цагаан, Жирмийн цагаан, Сумийн нуур зэрэг олон нуур бий.

| Нуурын хонхрын гарал | Хамрагдах нуурууд |
|-----------------------------|-----------------------------------|
| Тектоник хонхор | Увс, Хяргас, Хөвсгөл |
| Галт уулын гаралтай | Тэргийн цагаан, Шарга |
| Салхин хуримтлалын гаралтай | Салхит, Шаварт |
| Мөсөн голын гаралтай | Толбо, Даян, Хөх нуур, Хагийн хар |

Монгол орны хойд болон баруун хэсгээр нуур элбэг. Манай орны хамгийн гүн нь Хөвсгөл нуур юм. Улаагчин хар, Тэлмэн, Ойгон, Өгий, Тэргийн Цагаан нуурууд болон Хөвсгөлийн Дархадын хотгорт Цагаан нуур зэрэг олон нуур бий. Хэнтийн нуруунд Хагийн Хар, Хөх, Хар Зүрхний Хөх, Хангал зэрэг нуур элбэг бий.


Хавсралт 4-ийг ашиглан 100 ам км-ээс их талбайтай 14 нуурыг нэрлэж

газарзүйн зураг дээр олж заагаарай!

Манай орны нуурын хонхор янз бүрийн замаар үүссэн байна.

Мөн цөмрөлөөс болон салхины ажиллагаагаар үүссэн хонхорт нуур үүсэх явдал бий.

Хур тунадас ихтэй нутаг болох Хангай, Хэнтий, Алтай, Хөвсгөлийн уулсад болон гол мөрний хөндийгөөр намаг их тархсан.



59 дугаар зураг. Монгол орны нуурууд



1. Газрын зурагт тэмдэглэсэн нууруудыг олж нэрлэ. Нээсийг нь дэвтэртээ бичиж ав. Урсгал, тогтмолоор нь бас хэмжээгээр нь, ялаарай. Өөрийн нутгийн нуурын тухай ярилцаарай.
2. Эрээн нуур, Жирмийн цагаан, Ганга, Буст, Увс, Хөвсгөл гэхчлэн нэр заасан дуутай нууруудыг нэрлэ!
3. Газрын зургийн масштаб ашиглан Увс, Буйр нууруудын талбайг олж, хавсралт 4 -д байгаа талбайтай нь тулгаж үз.
4. Монгол орны 1:1 500 000 масштабтай зурагт тэмдэглэгдсэн гадагшаа урсгалгүй мөртлөө цэнгэг устай Завханы Хар нуур байна. Цэнгэг устай байдгийн учрыг тайлбарлах гэж оролдоорой! (Хариуг Дадлага ажлын номоос үз)
5. Танай нутагт ямар ямар нуур байна? Эдгээрийн үүсэл гарал ямар шалтгаантай байна вэ? Ярилц. Том нуур үзсэн сурагчид үзсэн нуурынхаа тухай ярьж өг. Намар хэдийд хөлдөж, хавар хэдийд цэлмэдэгийг ажиглаж тогтоогоорой.
6. Манай оронд 100.000 жилийн өмнө болсон сүүлчийн мөстлөгийн дараах дулаарлын үед манай орны нуур, гол мөрний усны түвшин яаж өөрчлөгдж байсныг төсөөлөн, ярилцаарай.

23. МӨСӨН ГОЛ, ОЛОН ЖИЛИЙН ЦЭВДЭГ

Дөрөвдөгч галавын үед манай Алтай, Хангай, Хэнтий, Хөвсгөлийн уулсад мөстлөг хэд хэдэн удаа болж байсан бөгөөд одоо зөвхөн Алтай, Хархираа, Түргэн, Хангай, Соёны уулсад мөнх цас, мөсөн гол үлджээ..

Манай орны уул нуурудын ноён ор гилд 3200 метрээс дээш өндөрт орчин үеийн **262** мөсөн гол бий. Тэдгээрийн нийт талбай 659 ам км хүрэх ба мөсний зузаан нь хамгийн зузаан газраа 185 м орчим байна. Мөсөн голын адаг нь хайлж голын эх болон урсана. Ийм голын нэг нь Ховд голын зүүн гарын цутгал *Цагаан гол* болно.

Олон жилийн цэвдэг. Манай орны хойд хэсгээр өвлүүлийн улирал урт бөгөөд хүйтэн болдог, бас цас багатай

байдгийн улмаас газрын хөрс чулуулаг, гүн хөлдөж зун ч гэсэхгүй хөлдүү байдаг. Үүнийг **ул хөрс чулуулгийн олон жилийн цэвдэг** гэж нэрлэдэг. Олон жилийн цэвдэг эртний мөстлөгийн үед анх үүссэн юм.

Манай орны ул хөрсний олон жилийн цэвдгийн урьд зах нь Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Шаргалжуут (х.ө. 46° 20'ын) хавьд Модон салаа ууланд хүрэх бөгөөд энэ нь Дэлхийн хойд хагасын ул хөрсний үргэлжилсэн цэвдгийн хамгийн урд зах юм.


Харин ул хөрсний толбо байдалтай тархсан цэвдэг өндөр уулсын ар бэлээр их бий. Ул хөрсний цэвдгийн нийт талбай улсын нутгийн 60 орчим хувийг эзэлнэ.



60 дугаар зураг. Монгол
Алтайн Таванбогд уулын
Потанины мөсөн голын адаг

Олон жилийн цэвдгийн зузаан нь Хангай, Хэнтий уулсад 50-80 м, Дорнод талд 5-15 м байдаг. Өндөр уулсад 1000 м зузаан байх явдал ч бий.

Хөрсний өнгөн хэсэг өвлийн цагт 4-5 м гүн хөлдөх бөгөөд дурьдсан нутагт олон жилийн цэвдэг түүнээс цааш үргэлжилнэ. Цэвдэгт хөрсөн дээр барьсан байшингийн доорх цэвдэг нь гэсэж өвөл ус ундран гарч ирэх зэргээр аж ахуйд их хохирол учруулдаг. Харин цэвдэгтэй хөрс нь хүнс хоолны зүйлс хадгалах агуулах байгуулахад ашиглах боломжтой.



1. Танай нутагт олон жилийн цэвдэг бий ю? Байвал хаагуур ямар газар тархсан байна вэ? Ярилцаж хариулаарай.
2. Олон жилийн цэвдэг яагаад бүр гүн хүртэл (Жишээлбэл: хамгийн ихдээ 1000 м-ээс гүн) үргэлжилдэггүй вэ? (Хариуг Дадлага ажлын номоос үз)
3. Уулын мөсөн голын урт яагаад нэмэгддэггүй юм вэ? Цас дээрээс нь нэмэгдээд байхад уруугаа гулсаад л баймаар юм. Бодож байгаад хариулаарай. (Хариуг Дадлага ажлын номоос үз)

24. ГАЗАР ДООРХ УС, РАШААН

Газар доорх ус нь ус үл нэвтрэх давхрага дээр оршдог бөгөөд хур борооны усаар тэжээгдэнэ. Говь ба хээрийн бүсэнд газар доорх усны томоохон сан оршино.

Манай оронд 300 гаруй рашаан бий. Үүнээс эмчилгээний шинж чанар, үйлчилгээ сайтай 90 гаруй рашааны орд байдаг бөгөөд 40 орчим нь халуун, 50 гаруй нь хүйтэн рашаан юм. Мөн рашаанлаг шинж чанартай булаг 100 гаруй, эмчилгээний шавар бүхий эрдэст нуур 40 орчим бий. Одоогоор судлагдсан рашааны ордын 40 гаруй хувь нь Монгол орны нутгийн баруун болон зүүн бүсийн, 33.3% нь Хангайн бүсийн, 23.3% нь говийн бүсийн нутагт оршдог.

Рашаан газрын гүнээс ундрان гарахдаа химиин янз бүрийн найрлагатай чuluулгийг дамжаасар тэдгээрт байгаа эрдэс бодис давсиг уусгаж авдаг. Зарим рашаан газрын гадарга дээр ил нуур булаг маягаар оршиж байхад зарим нь их гүнээс гарч ирдэг учир бүлээн, бүр халуун ч байдаг.



Рашааны мужууд


- Азотот халуун рашааны муж-Алтай, Хангайн уулс, Хэнтийн нурууны араар орших Хужирт, Шаргалжуут, Ерөө
- Нүүрсхүчлийн хүйтэн рашааны муж-Дорнод тал, Хэнтийн нурууны өврөөр орших Жанчивлан, Улаанбаатар, Талбулаг зэрэг болно.
- Метан, Азотот давсархаг рашааны муж-Их нуурын хотгор Говь нутгаар орших Бэгэр нуур зэрэг болно.

Хужиртын рашаан сувилал, Өвөрхангай аймгийн Хужирт сумын төвд 1660 м өндөр оршино. Нутгийнхан дээр үеэс хэрэглэдэг байсан халуун (54.5°C), заслын зөвлөн лаг шавартай. Дарь хүхрийн үнэртэй өнгөгүй, тунгалаг устай, сульфад, Хлорид, натри, кальцитын найрлагатай. Арьс, мэдрэл, үе мөч, эмэгтэйчүүдийн архаг өвчнийг анагаадаг улсын анхны сувилал юм.

Монгол орны рашааныг байрлал, найрлагаар нь хэдэн мужид хувааж үздэг.

Рашаан сувилал хөгжүүлэх үндэсний хөтөлбөр ёсоор (хавсралт 5-д нэр заасан) Хужирт зэрэг 17 рашааныг улсын хэмжээнд, Увсын Хартэрмэс, Сухбаатарын Талбулаг, Дорнодын Цагаанхөндий, Булганы Хунтуур, Хөвсгөлийн Эрхил нуур зэрэг 26 рашааныг аймгийн хэмжээнд, Төв аймгийн Естий, Өмнөговийн Нэмэгт зэрэг 11 рашааныг сумын хэмжээнд ашиглахаар заасан байна.

Хэнтийн уулс болон Дорнод талын хойд хагаст нүүрсхүчлийн хийтэй иsgэлэн хүйтэн рашаан зонхилдог бол Хангайн уулст азотметаны бүлгийн хийтэй, шүлтлэг халуун рашаан тархсан байдаг. Говийн ихэнх хэсэгт их эрдэсжсэн шүлтлэг хүйтэн рашаан голлоно. Хяргас нуур, Төв аймгийн Ихтөхөм, Бөөрөлжүүт зэрэг эрдэсжилт ихтэй, лаг шавартай рашаан нуурууд олон бий.



61 дүгээр зураг. Рашааны тархацын зураг



Цэвэр усны хомсдол. Дэлхийн дулаарлын уршгаар манай гариг даяар хуурайших боллоо. Манай гариг дээрх усны нөөцийн дөнгөж 2 хувь нь ундааны цэвэр ус байгаа юм. Дэлхийн хэмжээгэр өнөө үед 1.7 тэрбум хүн усаар гачигдаж байгаа. Хүн өглөө шүдээ угаахаар хоолойгоор усаа хүчтэй гоожуулах хооронд З л ус үр ашиггүй гоождог аж. Иймд хүн болгон усаа хамгаалахад хувь нэмрээ оруулах ёстой болж байна.

Газар доорх ус зөвхөн тал газар, хөндий, хонхорт төдийгүй уулын хажуу, оройд хүртэл дайралддаг ба уулын бэл хормойгоор ил гарч, булаг үүсгэнэ. Цав толгод, тал газарт булаг ундрах нь цөөн боловч тохиолдоно. Говьд бол тийм булаг ундарсан газарт тоорой, хайлс, жигд гэх мэт мод, бут ургаж баянбуурд бий болно. Жишээ

нь, Алтайн өмнөх.gov дахь Захуй, Эхийн гол гэх мэт баянбуурдийг дурдаж болно.

Булаг ундраагүй газарт газрын доорх усыг худаг малтаж ашиглана. Гадаргад ойрхон ул хөрсний усыг энгийн гар худаг байдлаар ашиглаж болно.



Манай орны хамгийн урт гол гол- Орхон (1124 км)

Хамгийн их устай гол – Сэлэнгэ мөрөн (хамгийн их урсац нь 4000 м³/с)

Хамгийн гүн нуур- Хөвсгөл (262м)

Хамгийн том нуур- Увс (3350 ам км)

Хамгийн өндөр хүрхрээ – Улаанцутгалан (20м)

Хамгийн урт мөсөн гол – Потанины мөсөн гол (53.5 ам км)



Манай гол мөрөн *Хойд мөсөн далай, Номхон далайн, Төв Азийн* гадагш урсгалгүй гэж 3 ай савд хуваагддаг.

Гол мөрдийн тэжээлийн гол нь борооны ус бөгөөд газар доорх усаар бас тэжээгддэг.

Нуур элбэгтэй. *Төв Азийн* хамгийн гүн нуур *Хөвсгөл* манайд байна.

Том уулуудад мөнх цас, мөсөн гол бий.

Азийн хойд хэсгийн ул хөрсний үргэлжилсэн цэвдгийн урд зах манай улсад (*Шаргалжуут хавьд*) бий.

Газар доорх ус рашаан элбэгтэй.



1. Танай нутагт газар доорх усыг хэрхэн гаргаж авч ашигладаг вэ? Худгийн гүн яагаад өөр өөр байдгийн учрыг ярилцаж тайлбарлаарай.
2. Тайраад байхад уртсаад байдаг
Шулаад байхад өргөсөөд байдаг. Тэр юу вэ?
3. Танай нутагт ямар өвчнийг анагаадаг ямар найрлагатай рашаан байдаг вэ? Очиж, ууж үзсэн рашааныхаа тухай нөхөддөө ярьж өгөөрэй.
4. Нутгийнхаа рашаан булаг, шанд худгийн бүртгэл гарга. Усны нөөц ундрагын тухай ярилц.
5. Манай орны тал хээр говь нутагт өвлүүн цагт хараар зутрахад худгаас малаа услах хэрэг гардаг. Зарим худаг яагаад өвөл хөлддөггүй вэ?
(Хариуг дадлага ажлын номоос үз)

ХӨРС, УРГАМАЛ, АМЬТНЫ АЙМАГ

7

Гол агуулга

- Хөрсөн бүрхэвч
- Ургамалжил
- Амьтны аймаг

Юу мэддэг болох вэ?

- Хөрс, түүний бүтэц, шинж чанар болон Монгол орны хөрсний хэв шинж, тархалтын зүй тогтол
- Монгол орны ургамал амьтны аймгийн тархалт, ашиглалт, хамгаалах тухай мэддэг болно.

Юу чаддаг болох вэ?

- Хөрсний тархалтын тойм зураг зохиох
- Хөрсний бүтэц, үргжил шимиийг ялган тодорхойлох
- Монгол орны ургамал, амьтны аймгийн газарзүйн зураг үнших, ашиглах
- Ховор, нэн ховор болон эмийн ургамлаас таньдаг болох
- Ургамал, амьтны тархалтын тойм зураг зохиож сурна.

Мэдлэгээ хэрхэн хэрэглэх вэ?

- Хөрсний шинж чанарт тохируулж юу тариалах, ямар аж ахуй эрхлэх боломжийг тодорхойлох
- Өөрийн орон нутгийн хөрс, ургамал, амьтны аймгийн тархалтад үнэлэлт дүгнэлт өгөх
- Ургамлыг ялган таньж, амьдрал ахуйдаа ашиглах, хөрс, ургамал, амьтны аймгийг ашиглах аргад суралцана.

25. ХӨРСӨН БҮРХЭВЧ

Хөрс судлаач алдарт эрдэмтэн Докучаев "Хөрс бол ландшафтын толь" гэж хэлсэн байдаг. Учир нь хөрс бол тухайн газар нутгийн хамгийн гол онцлогийг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл хөрс амьд ба амьгүй биесийн харилцан үйлчлэлийн үр дүнд маш урт удаан хугацаанд үүсэн бүрэлдэнэ. Сэргүүн бүсэнд 0.5-2 см зузаан хөрс байгалийн жамаараа үүсэхэд 800-1000 жил шаарддаг байна.

Хаагуур ямар ургамал ургах нь хөрс нөөс хамаардаг бол хөрс нь эргээд ургамлан бүрхэвчээсээ хамаарна.

Хөрсний физик шинж чанар, химийн найрлага, органик бодисын хуримтлал нь газар бүр адилгүй.

Хөрсний шинж чанар ба түүний тархалтанд нөлөөлөх нэг гол хүчин зүйл нь уур амьсгал юм. Учир нь эр-


дэс чулуулгийн өгөршил нь агаарын температур, чийг зэрэг уур амьсгалын нөхцлөөс шалтгаалдаг. Өгөршлийн явцад уулын чулуулаг эвдэрч том хэмжээтэй хад асгаас эхлээд хайрга, улмаар тоосны ширхэгтэй болтлоо эвдрэн бутардаг. Хөрсөн дэх эрдэс чулуулгийн харьцаагаар ерөнхийд нь хөрсийг **элсэргэг, шаварлаг, тоосорхог** хэмээн гурав ангилана.

Уур амьсгал хуурай байвал эх чулуулагт давс ихээр хуримтлагдаж хужирлаг хөрс үүснэ. Ийм хөрс манай говь цөл нутгаар элбэг тархдаг.


Ой мод, өвс ургамал сайтай, хур тунадас ихтэй газрын хөрсөнд ялзмаг их хуримтлагдана. Хөрсний үржил шим сайн байх тутам ялзмагийн хэмжээ их байна. Хөрсний өнгө ч төдий чинээ хар бараан байна. Ургамлын хатсан навч, мөчир болон амьтны сэг үлдэгдэл хөрсөнд шингэж, задарч, ялзмагийг үүсгэдэг.

Хөрсний зүсэлтийг үзүүлсэн зургаас хөрсний үе давхаргыг ажиглаарай. Хөрсний хэв шинж тус бүрийн өнгө өөр өөр байхаас гадна үе давхарга нь ч ялгаатай. Хамгийн дээд хэсэг дэх ургамлын үндэс бүхий бараан үе бол ялзмагт давхарга юм. Үүнээс доош хөрсний өнгө цайвар болсоор эх чулуулагт шилжинэ.

Ялзмаг азот, фосфор, кали зэрэг ургамалд тэжээл болох химийн элемен-түүдийг агуулдаг. Гэвч хөрсний үржил шимд эдгээр шим тэжээлийн бодисоос гадна өөр хүчин зүйлс ч нөлөөлнө. Манайд ялзмагаар баялаг хамгийн үржил шимтэй хөрс бол хар шороон хөрс юм. Ийм хөрс ой мод элбэгтэй хангай нутаг болон голын хөндийгээр тархдаг.



62 дугаар зураг. Хөрсний үе давхаргууд



63 дугаар зураг. Хөрсний тархцын зураг.

Хөрсний өөр нэг чухал шинж бол түүний механик бүрэлдэхүүн юм. Энэ нь элсэрхэг, шаварлаг, эсэх, мөн ямар бүтэцтэйг тодорхойлно. Хөрсих сэвсгэр байвал борооны ус болон агаараас хүчилтөрөгч амархан нэвчинэ. Ширхэг-лэг бүтэцтэй хөрсийг газар тариаланд ашиглахад тохиромжтой.

Хөрсний найрлага, бүтэц, гадаад төрх, өнгө зэрэг нь үүссэн нөхцөл, байгалийн орчин, үүсгэсэн чулуулаг болон хотгор гүдгэрийн байдал зэргээс хамаарна. Манай орны байгалийн нөхцөл газар бүр өөр өөр учир хөрсний шинж чанар ч бас түүнийг даган өөрчлөгднө. Үүнийг хөрсний хэв шинж гэдэг.

Манай оронд зонхилох 8 хэв шинжийн хөрс тархжээ. Энэ нь: Уулын нугын, Уулын ойн ширэгт, Уулын хар широон, Хүрэн, Говийн бор, Цэлийн гөлтөнөт бор саарал, Нууц намгийн, давсархаг хөрс юм.

Нэг хэв шинжид олон дэд хэв шинжийн хөрс багтана. Жишээ нь: хээрийн бүсийн үндсэн хэв шинж болох хүрэн хөрс гэхэд л хар хүрэн, цайвар хүрэн, жинхэнэ хүрэн гэсэн 3 дэд хэв шинжид хуваагдана. Хүрэн хөрстэй газар үэтэнэлдэв өвс ургамал ургах нь их бөгөөд ялзмагийн хэмжээ 1-3%, зузаан нь 30 см хүрнэ.

Манай орны тариалангийн эргэлтийн талбайн ихэнх нь хүрэн хөрстэй нутгаар бий. Хүрэн хөрсний найрлагад кальци, хүхэр их учир тариа нь уураг ихтэй, ургамлаар дамжин хонини ноосны гарц сайн байхад ч нөлөөлнө.

Хөрсийг яагаад хамгаалах шаардлагатай вэ? Хүн төрөлхтөний хоол тэжээлийн 88 хувийг хөрсөнд ургуулан

гаргаж авдаг бүтээгдэхүүн эзэнтэй. Гурил, будаа, талх, тариа гээд л бүгдийг нь хөрсөнд ургуулдаг. Манай улсын нутгийн 1.4 шахам хувийг эзэлж буй уулын таг, царам байц, хад асга, элсэн манхан, улаан шал, өвс ургамалгүй, гүнзгий гуу жалга, сайр, хүрмэн чулуутай газар буюу аж ахуйн зорилгод ашиглахад тохиромжгүй газраас бусад газрыг аж ахуйд ашиглаж байна.

Хөрс байгалийн болон хүний үйл ажиллагааны нөлөөгөөр эвдрэлд орно. Энэ нь машин техник олширсноос хэт олон зам гарах, нэг газарт удаан суурьшсанаас хөрс талхлагдан үржил шимгүй болон хатуурч, хөрсний элэгдэлд орох явдал их болж байгаа нь хүний зохисгүй үйл ажиллагаатай холбоотой. Салхи ба усны нөлөөгөөр эвдрэхээс хамгаалах гол арга нь мод зүлэг ихээр ургуулах явдал юм. Ширэгтэй хөрсөнд ус шингэн уусдаг бол ургамалгүй хөрс усанд амархан элэгдэж эвдэрнэ. Хөдөө хээр газар дуртай газраараа зам гарган машинаар давхих нь хөрсийг эвдэх хамгийн наад захын жишээ юм. Түүнчлэн гар аргаар ашигт малтмал олборлох, хаа дуртай газраа буудаллах, өвс ургамлыг сэндийлэх нь бүгд л хөрсний эвдрэлд хүргэнэ. Ер нь хөрс ургамал ургаж, үржих хамгийн чухал үндэс суурь болдог учраас Хөдөө аж ахуйд их ач холбогдолтой. Иймд хөрсийг хамгаалах асуудал юуны өмнө тавигддаг бөгөөд үүнийг шийдвэрлэхэд агротехникийн төрөл бүрийн арга замыг хэрэглэнэ. Үүний тулд хөрсний чийг тэжээлийн бодисыг хамгаалах, хог ургамлтай тэмцэх, эрдэс бордоогоор бордох, салхины болон усны элэгдлээс хамгаалах зэрэг олон төрлийн арга хэмжээ авдаг байна.



1. Ой модтой газар ялзмагт давхарга зузаан байдаг бол тачир сийрэг ургамалтай цөл газрын хөрсөнд ялзмаг бараг угүй. Үүний учир юу вэ? Хатсан өвс ургамал модны навчсыг хог хэмээн шатаахын оронд газарт булж даршлан хөрсний үржил шимиийг нэмэгдүүлэхэд ашиглаж болно. Үүний учир нь юу вэ?
2. Хөрсний тархалтын зургийг ажиглаж амьдардаг орчиндоо ямар хэв шинжийн хөрс илүү их талбай эзэлж байгааг тодорохойлон бичээрэй.
3. Манай улсын нийт газар нутгийн 80 гаруй хувь нь ХАА-н эдэлбэр газар бөгөөд үүний 125 сая га нь билчээрийн, 2 сая орчим га нь хадлангийн, 800 мянган га нь тариалангийн талбай эзэлнэ. Үүнийг тойргон диаграммаар дурсэл.
4. Дараах хүснэгтийг бөглөж дүгнэлт хийж ярилцаарай.

Хөрсний хэв шинж

Уулын нугын

Уулын ойн ширэгт

Уулын хар шороон

Хүрэн

Говийн бор

Цөлийн гөлтгөнөт бор саарал

Нуга намгийн

Давсархаг

Тархсан газрууд Тариалан эрхлэх байдал

26. УРГАМАЛ, АМЬТНЫ АЙМАГ

Ургамал ба амьтны аймгийг “амьд байгаль” хэмээн нэрлэдэг нь байгалийн ямар гол хэсэг болохыг нь тодотгож буй хэрэг юм. Ямарваа нутгийн байгалийн төрх байдлыг ургамал амьтан нь л хамгийн гол илтгэн харуулдаг. Хэдийгээр байгалийн бүрэлдэхүүнд тэдгээрээс гадна агаарын температур, чийг тунадас гэхчлэн олон зүйл багтдаг ч “нүдэнд харагдаж, гарг баригддаг” нь ургамал, амьтан юм. Ялангуяа байгалийн бүрэлдэхүүн хэсгүүдийн харилцан холбооны тусгал нь ургамлан бүрхэвч болдог учраас “тайга, мөнх ногоон ой, хэр

тал” гэхчлэн ургамлын нэрээр ялган нэрлэдэг шүү дээ.

Хаана ямар ургамал амьтан байх нь тухайн байгалийн нөхцлөөс гадна геологийн түүхэн хөгжилтэй холбоотой юм. Тухайлбал, халуун оронд заан, арслан, бар гэхчлэн аварга биетэн байдаг бол сэргүүн оронд тийм биш байдаг тухай бид өмнөх ангид үзсэн.

Манай орны ургамал, амьтны төрөл зүйл нэн олон. Нийт 3000 орчим зүйл ургамал, 140 зүйл хөхтөн, 400 гаруй зүйл шувуу, 80-аад зүйлийн загас, 30 орчим зүйлийн хоёр нутагтан амьдардаг боловч байгалийн

байдлаас хамаараад дотроо ялгаатай. Тухайлбал, нутгийн хойд хэсгээр ой модтой, өтгөн сахлаг өвс ургамалтай түүнээ дагаад хандгай, баавгай зэрэг ойн амьтад байдаг бол нутгийн зүүн ба өмнөд хэсгээр цөл-хээрийн ургамал, амьтад зонхилен.

Түүгээр ч барахгүй бэлчээрийн малин тоо толгой, сургийн бүтэц өөр өөр байдаг. Уулархаг газраар сарлаг их байхад хээр талд адuu голлосон, говь цөл газраар тэмээ ихтэй байх жишээтэй. Эдгээр ялгарлын гол хүчин зүйл болох байгалийн нөхцөл нь яваандаа хүмүүсийн аж төрөл эрхлэх байдалд нөлөөлжээ. Тийм чучраас хангай нутагт сарлагийн өрөм ааруул элбэг байхад хээрийн бүсийнхэн сайхан айрагтай, говийнхон ингэний хоормогоо дээд зэргийн ундаанд тооцдог билээ.

Ургамал амьтныг ашиглах, хамгаалах. Манай бэлчээрийн талбайн хэмжээ 1.3 сая орчим ам км бөгөөд ихэнх нь нутгийн төв хэсгээр бий. Манай орон ойн нөөцөөр ядуу орны тоонд ордог. Нийт талбайн 8.7 хувь (буюу 18300 ам км)-ийг эзэлдэг ой модны ихэнх нь нутгийн хойд хэсгээр, голдуу уулынхаа ар хажууд ургадаг. Учир нь уулын ар сүүдэр хажууд унасан чийг удаан хуримтлагдаж ой мод ургах нөхцлийг бүрдүүлсэн байхад уулын энгэр хажууд нарны тусгал их, ууршилтын улмаас амархан хатаж хуурайшина. Ой мод ус чийг их шаарддаг. Харин халуун чийглэг оронд ой мод уулын ар, өвөр аль ч хажууд, талд ургасан байдаг.

Ойн онцлог нэг төрөл бол говьд ургах заг юм. Заг зарим газраа тэмээ


далд ортол өндөр, өтгөн төгөл болон ургадаг. Заг маш халуун илч гаргадаг. Иймд загийг түлшинд их хэрэглэснээс болж устах аюул нүүрлэж байна.

Ой бол ган, цөлжилт, хуурайшилт, усны нөөцийн хомсдолоос сэргийлж, амьсгалах цэвэр агаар (хүчилтөрөгч)-ыг “үйлдвэрлэн” бий болгодог. Гэвч ой мод түймэрт өртөхөөс гадна хүмүүс барилга, хашаа, хүнс, түлшинд хэрэглэн байгалийн аясаар нөхөн ургах нөөцөөс нь хэтрүүлж байгаа нь ойн нөөц устах аюулд хүргэж байгаа юм.

Сүүлийн үед ойр ойрхон ган болж, ургамал их хатсанаас бэлчээрийн ургамлын төрөл зүйл цөөрч, шарилж зэрэг хогийн ургамлын ургах талбай ихсэж байгаа нь манай мал аж ахуйн бэлчээр тэжээлийн байдалд муу нөлөөлж байгаагаас сэргийлэх арга хэмжээ авах хэрэгтэй болж байна.

Манайд нутгийн унаган болон нэн ховор ургамлаас гадна хамгаалах ёстой 133 зүйл ургамал бүртгэгджээ. Дэлхийд нэн ховор болсон ургамал ч бий.

Амьтдыг амьтны аймгийн хуулиар нэн ховор, ховор, элбэг гэж 3 зэрэгт ангилсан байдаг. Нэн ховор амьтанд тахь, хавтгай, мазаалай, шивэрхандгай, хар мөрний хандгай, цаа буга, хүдэр, минж, халиу, ирвэс, цөөвөр чоно, монгол бөхөн, соргог бөхөн, жороо тоодог, гургуул, гангар хун, борцгор хотон, цэн тогоруу, хар тогоруу, цагаан тогоруу, хилим үхэрдэй, зантахай загас, бага тогосон одот эрвээхэй, хар мөрний хилим загас, реликт цахтай гээд 26 зүйл амьтан орно. Ховор 36 амьтдын нэрсийг 7-р хавсралтаас үзээрэй.



64 дугаар зураг. Манай орны зарим нэн ховор ба ховор амьтад



Монгол хундгана (*Adonis Mongolica*). Манай уна-ган, нэн ховор ургамал. Хангай Хэнтий, Монгол дагуурт ховор тохиолдоно. Уулын ойт- хээрийн жижиг үетэн, элдэв өвс зонхилсон газарт ургана. Эмийн ургамал, иш шулуун, өндийсөн, нүцгэн, сийрэг үсэнцэртэй, багц байдалтай, цэцэг нь олон том цагаан дэлбээтэй.

Зөвхөн тодорхой нутагт идээшин байрласан, өөр хаана ч үл тохиолдог амьтан, ургамлыг **унаган амьтан, ургамал** гэнэ. Манай оронд унаган ургамал 140 гаруй зүйл бий.



66 дугаар зураг. Монгол бөхөн

Монгол бөхөн (*Saiga tatarica mongolica*). Туруутны баг, тугалмайтын овог. Монголын унаган амьтан,



65 дүгээр зураг. Монгол хундгана

нэн ховор зүйл, дэлхийн хэмжээнд ховордсон. Биеийн урт 116 см, сэrvээний өндөр 75 см, жин 32 кг хүрнэ. Цайвар шаргал зүстэй, хос широн эвэртэй.

Хүзүүгээ сунган толгойгоо гудайлгаж цагт 60-70 км хурдан хатирдаг. Ховдын Манханы тал, Говь-Алтайн Шаргын говьд тархсан бөхөнг хамгаалах гэж эдгээр нутгийг улсын тусгай хамгаалалтад аваад байгаа билээ. Говийн хялгана, таана, хөмүүл, багал зуур шарилжаар хооллоно.



1. Өөр өөрсдийн мэдэх нутгийн ургамлын нэрсийн жагсаалт хийж, хэн нь хэдэн ургамал мэдэхийг шалгаарай. Кабинетдаа нутгийн түгээмэл тархацтай ургамлын хатаадас хийж аваарай. 6-р хавсралтыг ашиглаж болно.
2. Танай нутагт ой мод, заг, хайлас, бургас ургадаг уу? Хаана хэр их талбайд ургадгийг ярилц!
3. Танай нутагт ургадаг ямар ургамал хавар хамгийн эрт цухуйдаг, намар хамгийн орой ганддаг, хагдардаг вэ? Ажиглаж бүртгэж аваарай.
4. Амьтдыг нэн ховор, ховор гэж ялгасны учир юу вэ?
5. Танай нутагт нэн ховор, ховор амьтан бий юу? Эдгээр амьтдаас үзсэн хүн тэр амьтдынхаа тухай нөхөддөө ярьж өгөөрэй.

БАЙГАЛИЙН БҮС, БҮСЛҮҮР

8

Гол агуулга

- Байгалийн бүс, бүслүүрийн тухай
- Ойт хээрийн бүс
- Хээрийн бүс
- Говийн бүс
- Цөлийн бүс
- Өндөр уулын бүслүүр

Юу мэддэг болох вэ?

- Монгол орны байгалийн бүс
- Байгалийн бүсүүдийн байрлал, онцлог, тархалтанд нөлөөлсөн хүчин зүйлсийг мэдж авна.

Юу чаддаг болох вэ?

- Байгалийн бүсийн зураг дээр ажиллаж уур амьсгал, ус, ургамал амьтны тархалтын хоорондох харилцан хамаарлыг тогтоож чаддаг болох
- Байгалийн бүс, бүслүүрийн тойм зураг зохиох
- Байгалийн бүс, бүслүүрийн онцлог, ялгааг харьцуулан дүгнэлт гаргаж чаддаг болно.

Мэдлэгээ хэрхэн хэрэглэх вэ?


- Байгалийн бүсийн онцлогоос хамаарч аж ахуй эрхлэлтийн ялгаа үүсэж байгааг жишээгээр тайлбарлах
- Өөрийн орон нутаг ямар байгалийн бүсэнд орж байгааг тодорхойлох
- Байгалийн бүсийн онцлогт тохирсон ямар аж ахуй эрхэлж болохыг тодорхойлох
- Өөрийн орон нутгийн уулсаар босоо бүслүүр үүссэн эсэхийг ажиглаж дүгнэлт гаргах
- Орон нутагтаа илэрч байгаа байгалийн бүс, бүслүүрийн учир шалтгааныг тайлбарлаж сурна.

27. БАЙГАЛИЙН БҮС

Манай орны хамгийн хойд ба өмнөд захын цэг нь өргөрөгийн хувьд 10 гаруй градусын зөрөөтэй учир байгалийн төрх байдлын тодорхой ялгарлыг бий болгожээ. Манай орны хойноос урагш Ойт-Хээрийн, Хээрийн, Говийн ба Цэлийн гэсэн үндсэн 4 бүсийг ялган үзнэ. Өндрийн бүслүүр Алтай, Хангай, Хэнтийн өндөр уулсын оройгоор үснэ.

Узсэн. Ийнхүү ойн бүсээс хээрт шилжих завсрын бүс болох ойт-хээрт манай орны нутгийн хойд хэсэг хамарагдана. “Ойтой хээр” гэсэн утгаас нь үзэхэд ой нь бага, хээр нь их гэсэн санааг гаргаж болохоор байна.

Энэ бүсийн өмнө хил нь үндсэндээ жилийн дундаж температурын -2°C , VII сарын дундаж температурын $+16^{\circ}\text{C}$,



67 дугаар зураг. Монгол орны байгалийн бүс, бүслүүр

Ойт-хээрийн бүс. Евразийн нутаг дээр их талбай эзлэх ойн бүс нь аажмаар хээрийн бүсэд шилждэг. Өөрөөр хэлбэл хур тунадас их, чийглэг нөхцөлд ургах Сибирийн их тайга урагшлах тутам холимог болон өргөн навчтит ойд шилжиж улмаар өвслөг хээр болдог тухай өмнөх ангид бид

I сарын дундаж температурын -24°C -ийн изотермтэй бараг тохирно. (45, 46-р зургийг үз) Эндээс үзэхэд ойт-хээрийн бүс нь манай орны арай сэруүн, тунадас ихтэй нутаг юм. Жилд дунджаар 250-300 мм, уулсын оройн хэсгээр түүнээс их тунадас унана. (51-р зургийг үз) Бусад нутгийг бодвол цас

ихтэй, эрт орох бөгөөд цасан бүрхүүл 100 хоногоос ч удаан тогтдог. Зуны улиралд хур бороо ихтэй болохоор ган

нөөс гадна хар хүрэн, хүрэн хөрс зонхилно. Хөндийн ёроолоор эдгээр хөрснөөс гадна нуга намгийн хөрс, мөн давсархаг хөрс



68-р зураг. Ойт-хээрийн бүсийн байгалийн төрх

зуд болох явдал говь, хээрийн бүсийг бодвол цөөн.

Чийглэг уур амьсгалтай учир гадаргын усаар бусад нутгийг бодвол хүрэлцээтэй (51-р зургийг үз). Ойт-хээрийн бүсийн хөрс нь хөгжил сайтай, үргжил шимээр илүү ч өргөргийн байдал, хотгор гүдгэрээс шалтгаалан хөрсний хэв шинжүүд газар бүр харилцан адилгүй байдаг (63-р зургийг үз).

Уулсын ар хажууд ойн ширэгт хүрэн хөрс, ойгүй газарт хар шороон хөрс, тархсан байдаг бол арай урдуур өргөрөгт ойн ширэгт хөрс уулын ар хажуугийн зөвхөн дээд хэсгийг эзэлж, доод хэсэгт нь уулын хар шороон хөрс илүү тархана. Уулын энгэр хажууд ялзмаг багатай хар шороон хөрс-

ч тохиолдоно. Энэ бүсийн хөрсний ихэнх нь үргжил шимиин хувьд газар тариаланд тохиромжтой боловч уулын эгц хажуугийн хөрсийг ашиглах бололцоо мутай, зөвхөн уулын хөндий, налуу, хажуу, бэлийг ашигладаг. Ойт-хээрийн бүсэд ургамалшлыг дагаж, ойн болон хээр талын адгуусан амьтад амьдарна.

Сэлэнгэ мөрнөөс гадна Дэлгэр мөрөн, Идэр гол, Бугсэй, Эг, Хүнүй, Орхон Хараа, Ерөө, Туул, Тамир зэрэг ус ихтэй голууд, Хөвсгөл, Улаагчин хар, Тэлмэн, Ойгон, Өгий, Тэрхийн Цагаан нуур, Хөвсгөлийн Дархадын хотгорт орших Цагаан нуур, Хэнтийн нурууны Хагийн Хар, Хөх, Хар Зүрхний Хөх, Хангал зэрэг олон нуур ойт-хээрийн бүсэд бий.



Манай орны ой 140 гаруй зүйлийн мод сөөгөөс бүрдэх бөгөөд шинэс, нарс, хуш, гацуур, жодоо зэрэг шилмүүст мод, хус, улиас, улиангар, хайлаас, бургас зэрэг навчт мод зонхилон тархана. Гэхдээ ойг бүрдүүлэгч гол мод нь шинэс байдаг байна. Нийт нутгийн 8.2%-ийг ой эзлэх ба нэг хүнд дунджаар 4.8 га ой ноогддог. Заган ой бүхий газрын 34.2%-ийг Улсын тусгай хамгаалалтанд авчээ. Ойн баялаг нь уур амьсгалын эрс хэлбэлзлийг супруулах, чийгийн хуримтлал, хангамжийг сайжруулах, хөрсийг ус, салхины элэгдлээс хамгаалах, голын усны түвшин, гадаргын урсацыг тохируулах зэргээр хүрээлэн байгаа орчноо хамгаалах олон чухал үүргийг гүйцэтгэж байдаг.



1. Ойт-хээрийн бүсэд Хангай, Хэнтий, Хөвсгөлийн уулс, Алтайн уулын баруун хэсгийн захын ойтой хээртэй уулнууд, манай нутгийн хамгийн зүүн хэсгийн Хянганы салбар уулс багтана. Үүнийг монгол орны засаг захиргааны зурагтай тулган харьцуулж, ямар ямар аймгийн нутаг ойт-хээрт орох вэ?
2. Ойт-хээрийн бүсэд урсах гол мөрдийн нэрийг зургаас харж бичээрэй.
3. Ойт-хээрийн бүсэд орших Булган, Сүхбаатар хотуудын уур амьсгалын байдлыг 1-р хавсралтаас үзэж, график байгуулан харьцуулан дүгнэлт хийх.
4. Цэцэрлэг хотод VII сард дунджаар $+16^{\circ}\text{C}$ байдаг. Энэ үед 1 шоометр агаарын үнэмлэхүй чийг хэдэн граммд хүрвэл бороо орж болох вэ? 18-р зүйлээс чийглэгийн итгэлцүүрийг харуулсан хүснэгтийг ашиглан бодоорой.



Хавсралтын 1-ээс үзэхэд Зуунмод хот Улаанбаатараас өндөрт оршдог учир хүйтэн баймаар юм. Гэтэл Улаанбаатарт илүү хүйтэн байгаагийн учрыг аль болох олон талаас нь тайлбарлаарай.

Ойт-хээрийн бүсийн аж ахуйн ашиглалт.

Манай орны ойн ихэнх нь ойт-хээрийн бүсэд орших ба бүсийн талбайн 30 орчим хувь нь ой модтой. Уулсын ар хажууд ургах ойд нь шинэс зонхицно. Хангай, Алтайн уулсад шинэстэй нарс, хус, улиас холилдон ургасан **холимог ой** илүү тархжээ. Манай ой ерөнхийдөө сийрэг, энд бургас, хад, монос, нохойн хошуу, нэрс, тошлой, үхрийн нүд, улаалзгана, буриагуул зэрэг сөөг ургамал, гүзээлзгэнэ, алирс зэрэг жимс, жимсгэнэ ургана. Төрөл бурийн жимс түүж, даршлан хүнсэндээ хэрэглэхээс гадна эмчилгээний зориулалтаар ч хүмүүс ашигладаг.

Их талбай эзлэх хар шорооон, хар хүрэн, хүрэн хөрсөнд нь хээрийн

бүсийн өвслөг ургамал ихтэй. Энд бие-лэгтэн, алаг өвс (буурцагтан, үетэн, улалжаас бусад өвсөн ургамлыг **алаг өвс** гэж нэрлэнэ) ургана.

Энд үетнээс улалж, хялгана, бутнуур, согоовор, ботуул, дааган сүүл, биелэг, ерхэг голлоно. Харин алаг өвснөөс далантовч, агь, навтуул, бамбар, далантүрүү ургана. Гэхдээ газрын хотгор гүдгэрийн байдлаас болж газар, газар өөр өөр. Хотос хөндийд үетэн ургамал зонхицно шивээг хялгана, даагансүүл элбэг ургана. Өндөр уулын ургамлаас өлчир дэгд, эмийн ургамлаас бамбар, тарваган шийр, цээнэ, долоогоно ургадаг.

Оид буга, бор гөрөөс, жирх, хэрэм, жигүүртнээс ятуу, хөхөө, тоншуул элбэг. Хээрийн бүсийн ургамалтай га-

зарт тарвага, зурам, үхэр огодой, жижигүүртнээс тогоруу, элээ, бүргэд, сар, харцага, болжмор, турлиах элбэг байна. Араатнаас чоно, үнэг хоёр элбэг.

Ойт-хээрийн бүс нь манай эдийн засагт их ач холбогдолтой нутаг юм. Манай улсын тариалангийн талбайн ихэнх нь энд байхаас гадна услалт хэрэглэн тариалах боломж ч их бий. Бэлчээр, хадлангийн нөөц их. Гадаргын налуу энд 6° - 20° хүрнэ. Их налуу газар нь тариалан эрхлэхэд таатай бус.

Мөнх цаст уулсыг хамруулан авч үзвэл манай улсын, нутгийн 60

орчим хувь буюу 564 мянга гаруй ам км. талбай бүхий нутаг энэ бүсэд багтаж ба энд 14 аймгийн 98 сумын 1.8 сая гаруй хүн ам амьдарч, 18 сая мал бэлчээрлэж байна. Эндхийн малчид "өвөлжөө, зуслан" гэсэн хоёр нүүдэлтэй нутагтай байх нь их бөгөөд ган, зуд бараг болдоггүй учир мал аж ахуй, газар тариалан эрхлэхэд таатай.

Ой модноос гадна чулуун нүүрс, фосфорит, зэс, молибден, алт зэрэг ашигт малтмал элбэг. Манай орны 3 том хот болох Улаанбаатар, Дархан, Эрдэнэт энэ бүсэд ордог.



69 дугаар зураг. Ойт-хээрийн бүсийн зарим ургамал 1.Хонгорзул, 2. Одой сараана, 3.Гэзэгцэцэг, 4. Жамъяномядаг, 5.Туйпланцар , 6. Хөвөн оройт



Хонин арц



Сибир хундгана



Дөрвөлжин
бөлбөө



Цагаан цээнэ



Дагуур тэрэлж



Ямаан сэргэг



70 дүгээр зураг . Ойт-хээрийн бүсийн нэн ховор зарим ургамал



Хэрэв танай сургууль ойт-хээрийн бүсэд оршдог бол дараах ажиглалт хийж дүгнэлт гаргаарай.

1. VII сард хамгийн их халахдаа хэдийд хэдэн хэм хүрч байсан бэ? I сард хамгийн их хүйтрэхдээ хэдийд хэдэн хэм хүрч байсан бэ? Намар, өвөл хэдийд цасан бүрхүүл тогтдог вэ? Хавар цас хэдийд цоохортдог вэ? Цасны зузаан цагаан газар хэдий хэр, ой модон дотроо хэдий хэр байдаг вэ? Намар, хавар болж байгаа нь байгалийн ямар ямар шинж тэмдгээр илэрдэг вэ? Ган, зуд болох явдал гардаг уу? Хамгийн сүүлд ган, зуд хэдийд болсон бэ?
- Дэлхийд нэн ховор ямар амьтан, ургамал танай нутагт байдаг вэ? Жагсаалт гаргаарай.
- Хавсралтын 6-д байгаа ургамлын хатаадас хийж аваарай. Хатаадас бий бол тулгаж шалгаарай.
2. Уур амьсгалын 44, 45, 46, 47-р зургуудыг ашиглан жилийн дундаж температур нь -2°C , VII сарынх $+16^{\circ}\text{C}$ -аас бага байдаг нутгуудыг олж заан, нэрлэж, ярилцаарай.

28.

ХЭЭРИЙН БҮС

Хээрийн бүс нь Хангайн нурууны өврөөс зүүн тийшээ өргөсөн үргэлжлэх бөгөөд урд захын хил нь говийн бүсийн хойд хил буюу х.ө. 45° -х.ө. 46° -ын зэргэдийн орчмоор өнгөрнө. Хээрийн

бүсийн зүүн хэсгийн хойд хилийг баримжаалж хэлбэл Хангайн нурууны зүүгээр хойшоо эргэж бараг Орхон, Туул голын бэлчир хүрэх бөгөөд тэгээд урагшаа эргэж Богдхан уулын урдуур



71 дугаар зураг. Дорнодын тэгш талд

Хэрлэн гол хүрч Хэрлэнбаян Улаан ба Өндөрхаан уулын өврөөр, Улз голын саваар Хэнтийн нурууны зүүн хойшоо з.у. 113-р голдожийг дагаж улсын хилд хүрэх шугам гэж үзэж болно.

Хээрийн бүсэд жилийн дундаж температур 0°C , VII сарын дундаж $+20^{\circ}\text{C}$, I сарын дундаж температур -20°C хүрнэ. 200-250 мм тунадас унах нь ойт-хээрийн бүсээс бараг хоёр дахин бага юм. (16, 17, 18-р зүйлүүдийн газрын зургийг үз)

Цасан бүрхүүл 70 орчим хоног тогтвортой байх ба ган болох явдал.govийн ба цөлийн бүсийнхээс арай удаан. Хүйтрэлтгүй үе 110-120 орчим хоног үргэлжилнэ.

Энэ бүсийн зүүн хэсэг орчмын нутаг болох Дорнод аймгийн нутгийн урд

зах, Сүхбаатар аймгийн нутгийн зүүн урд захад хур тунадас 250 мм-ээс илүү байдаг нь Номхон далайн улирлын салхины нөлөө юм. Энэ бүсийн ихэнх хэсэгт ухаа гүвээт тал зонхилж, хотгор гүдгэрийн ялгаа их биш учир хөрсөн бүрхэвч нилээд жигд байна.

Бүсийн хойд талаар хар хүрэн хөрс алаг цоог, өмнөд хэсгээр цайвар хүрэн хөрс тохиолдоно. Ихэнх нутагт хүрэн хөрс зонхилдог. Газар тариаланг зөвхөн бүсийн хойд хагаст гол мөрний хөндий зэрэг арай чийглэг газраар эрхлэх боломжтой. Тиймээс Хэрлэн гол, Ононгийн зарим цутгал, Улз гол, Халхын голын дагуу тариалангийн газар төвлөрчээ.



72 дугаар зураг. Тал хээрийн бүсийн өвөлжөөнд ургасан шарилж

Хээрийн бүсийн аж ахуйн ашиглалт.

Хээрийн бүсэд цайвар хүрэн, хүрэн хөрс голлоно. Хонхор газраа давсархаг хөрс, хужир марз ихтэй бөгөөд энд тэнд довцог манх бүхий элс ч бас тааралдана. Хазааргана, шивээт хялгана, хиаг, түнгэ, ерхөг, агь, даагансүүл, биелэг өвс ихтэй ба

чулуурхаг буюу элсэрхэг газраа харгана ургана. Өмнө захаар нь говийн ургамал болох хөмүүл, таана тааралдана. Хужир марзтай хонхор газруудаар дэрс, бударгана, лууль ургана. Модлог ургамал ховор. Толгодын ам хөндийгөөр хайлас, бүйлэс, яргай, бургас, тавилгана ургасан байдаг.



73 дүгээр зураг. Хээрийн бүсийн зарим ургамал

1. Төлөгч өвс, 2. Шар яргуй, 3. Гоо юлт, 4. Галуут гичгэнэ, 5. Цахилдаг,
6. Тагийн гол гэсэр



Ла́яа ёёо ёёо



Лэдээчүй ёёо



Оддадаадаа
ёёо



Одоо лаадаадаа
одоо



Одийн аа
мөнжийн



Лийн ёёо



74 дугаар зураг. Хээрийн бүсийн нэн ховор зарим ургамал

Амьтны аймаг нь дан хээрийн амьтдаас бүрдэх бөгөөд цагаан зээр хамгийн элбэг амьтан. Төв Азийн цагаан зээрийн 70 хувь нь манай хээрт бий гэж үздэг. Түүнээс гадна үлийн цагаан оготно маш их. Хурдан үрждэг, бэлчээрийг их сүйтгэдэг хортон мэрэгч боловч хөрсийг сийрэгжүүлдэг. Мэнэнгийн талд тарвага, үлийн цагаан оготно байхгүй нь сонин. Чоно, үнэг, хярс хааяагүй амьдрах ба болжмор, ногтруу, ятуу, элээ, сар, начин шонхор зэрэг шувууд, ховор шувуудаас хонин тоодог амьдардаг.

Хээрийн бүс нь манай улсын нутгийн 20 гаруй хувийг эзэлдэг бөгөөд энд манай 9 аймгийн 50 гаруй сумын 300 гаруй мянган хүн ам амьдарч 7 сая орчим мал бэлчээрлэдэг, хадлан бэлчээрийн гол нутаг болно. Малчдад “өвөлжөө, зуслан” гэж байх боловч ус, бэлчээр ургамлаа дагаад жилд хол ойр (150 км хүртэл) 10 гаруй удаа нүүж мал аж ахуйгаа эрхэлнэ. Гүний ус элбэг тархсан байх тул худаг гарган ашиглах нь түгээмэл.



1. Хээрийн бүсийн ургамлаас таних ургамлаа нэрлэ.
2. Хэрэв танай сургууль хээрийн бүсэнд оршдог бол нутагтаа зонхилох 20 ургамлын хатаадас хийж аваарай. Ингэхдээ Хавсралт 6-д байгаа нэрстэй тулгаж үзнэ үү.
3. Хээрийн бүсийн зүүн өмнөд ба хойд захын хэсэгт өвс ургамал өтгөн шигүү их ургадгийн учрыг сайн ярилцаж тайлбарлаарай.
4. Хэрэв танай сургууль хээрийн бүсэнд оршдог бол дараах ажиглалт хийж дүгнэж ярилцаарай.
5. VII сард агаар хамгийн халуун болохдоо хэдийд хэдэн хэм хүрч байсан, I сард хамгийн их хүйтэн болохдоо хэдийд хэдэн хэм хүрч байсан. I сар ба VII сард дунджаар хэдэн хэм байдаг вэ?
6. Намар өвөл хэдийд цасан бүрхүүл тогтдог. Хавар цасан бүрхүүл хэдийд ханзардаг, цасны зузаан хэдий хэр байдаг вэ? Намар, хавар болж байгаа нь үзэгдэлзүйн ямар ямар шинж тэмдгээр илэрдэг вэ?
7. Ган, зуд болох явдал хэр зэрэг олонтаа тохиолддог вэ? Хамгийн сүүлд хэдийд хамгийн сурхий ган, зуд болсон бэ?
8. Цасан ба широон шуурга хэр зэрэг олонтаа болдог вэ?
9. Манай орны ба дэлхийн хэмжээнд нэн ховор ямар ургамал, амьтан танай нутагт байна? Нэрийн жагсаалт гаргаж үз.
10. Үүр амьсгалын 44, 45, 46, 47-р зургуудыг үзэж жилийн дундаж температур нь 0°C , VII сарын дундаж температур нь $+20^{\circ}\text{C}$ -аас бага байдаг нутгийг олж заагаарай.
11. Үүр амьсгалын 44, 45, 46, 47-р зургуудыг ажиглаж хээрийн бүсийн үүр амьсгалын талаар ярилцаарай. Энд нэр гарсан газруудыг газрын зурагт олж заагаарай.


29. ГОВИЙН БА ЦӨЛИЙН БҮС

Энэ бүсийн ихэнх талбай манай орны өмнөд хэсгийг хамрах боловч Увс нуурын хотгорын хойд зах хүртэл үргэлжлэх *Их нууруудын хотгор* болон *Говь-Алтайн* уулсын араар үргэлжлэх Нууруудын хөндийг хамрах ба нийт нутгийн 40 орчим хувийг эзлэн оршдог. Энэ бүсийг заримдаа говийн ба цөлийн гэж дотор нь ялгадаг.

“Цөл” гэсэн үг монгол хэлнээ “хүн амьтангүй зэлүүд газар” гэсэн угтатай боловч газарзүйн ухаанд хүн амьтангүйгээс гадна байгалийн нөхцөлийн хувьд хуурай буюу бас хэт халуун, хүйтэн байдаг газрыг илэрхийлдэг ухагдахуун болжээ.

Говийн ба цөлийн бүс нь манай орны хамгийн дулаан, бас хамгийн чийг тунадас багатай газар. Энэ бүсийн урд хэсгээр жилийн дундаж хэм $+2^{\circ}\text{C}$ - $+4^{\circ}\text{C}$, YII сарын дундаж $+20^{\circ}\text{C}$ - $+24^{\circ}\text{C}$, I сарынх -16°C орчим байдаг. Цөлийн бүсэд орших Эхийн голд **36 мм** тунадас унах ба **44.8°C** хүрч халсан нь манайд тэмдэглэгдсэн хамгийн их халуун, хамгийн бага тунадас юм.

Жилийн тунадас 100-150 мм буюу манай орны хамгийн бага тунадастай, ган болох давтагдал ойрхон. Өвөл цасан бүрхэвч нимгэн, царай байх хугацаа богино. Говийн бүсийн хойд хэсэг болох *Их нууруудын хотгор* хойгуур



75 дугаар зураг. Хэрмэнцав (Өмнөговь, Гурвантэс сум)

Эрдэмтэн Я.Цэвэл “Говь тачир сийрэг, ургамалтай, урсгал ус маш ховор, элс хайрган хөрстэй, тарвага нутагшдаггүй хээр тал” гэж тодорхойлжээ.

Ард түмний дунд “Монголд алдартай 33 говь бий” гэсэн яриа байдаг боловч судлаачдын үзэж байгаагаар “говь” нэртэй 370-аад газар байдаг аж. Мөн “хөндий”, “хоолой” гэсэн нэртэй газрууд ч говь цөлийн төрхийг илэрхийлэх явдал бий.

өргөрөгт өндөр уулаар хүрээлэгдэн оршдог учраас өвлүүн цагт их хүйтэн агаар хуримтлагдаж, говийн бүсийн төдийгүй улсын бусад нутгаас хүйтэн болдог. Жилдээ их хүйтрэх өдрийн тоо цөл, говийн бүсийн өмнөд хэсэгт 10-аас хэтрэхгүй байхад Увс нуурын хотгорт 50-аас олон байдаг. Говийн бүс түүний дотор Увс, Хяргас, Хар ус, Хар нуурын хотгор нь агаарын даралт ихтэй.


Өртөө газраас айлын гэр
 Өдрийн од шиг цахилнам билээ
 Халуун тогооноос бүрхээр авахад
 Хамар цоргин бүчих уур шиг
 Таана аагисан хөхөмдөг манан
 Талаар дэгдэн хөөрнөм билээ.
 Зүн намартаа говь ингэж

Зуух мэт голдоо халаад
 Өлгийтэй нялхас шиг
 Өвөлдөө илчээрээ амьсгалж
 Цан хүүргээ үргээн
 Цас үүлэндээ хайлдаг юм.
 (Төрийн шагналт, Ардын уран зохиолч
 Д.Пүрэвдорж "Сэгс цагаан богд"
 найраглалаас)



76 дугаар зураг. Говийн ба цөлийн бүсийн зарим ургамал

1. Муркрофтийн жигд, 2. Зулзган заг, 3. Бударгана, 4. Гишүүнэ, 5. Заг, 6. Тоорой,



Адäääæeëöyöyä



Аihæéí ôîñò



Öäâðääéí áóäðàà



Ööëäí ôîéðääî



Iºöö oadaai



Óëääí ööëäì



77 дугаар зураг. Говийн ба цэлийн бүсийн нэн ховор зарим ургамал

Говийн ба цөлийн бүс нь салхи ихтэй, ялангуяа хаврын цагт шороон шуурга, угалз болох нь олонтаа. Жилдээ шороон шуурга 40-өөс олон удаа болдог. Өмнөговь аймгийн Булган суманд жилийн салхины дундаж хурд 10 м/с байдаг. Булган сум нь говийн бүсэнд Гурванбогд, Гурвансайханы нуруудын хоорондох урт бөгөөд өргөн уудам хоолойд оршдог сум юм. (50-р зургийг үз)

Гадаргын ус ховор, харин Их нууруудын хотторт, Тэс, Нарийн, Завхан, Хүнгий, Боршоо, Торхлог, Хөндлөн, Хархираа зэрэг голын адаг орж ирэх бөгөөд Хангайн нурууны өврийн Баганууруудын хотторт Байдраг, Таац, Түй, Онгийн голын адаг, Алтайн өвөр говьд Булган, Үенч, Бодонч, Барлаг голуудын адаг орж ирнэ. Говьд баянбуурд олон тааралддаг нь гүний ус элбэг байдгийн гэрч юм.



78 дүгээр зураг. Говь Гурвансайхан уул

Манай орны нутгийн 20 гаруй хувьд тархсан говийн бор хөрсний ихэнх нь энэ бүсэнд байх ба ялзмаг бага, ургамал тачир. Харин цөлийн хэсгээрээ гөлтгөнөт борсаарал хөрс голлох ба хөрсгүй, хайрга чулуу бүхий газар ч бий. Манай цөлийн ихэнх нь чулуурхаг цөлд орно.

Говь-Алтайн нуруунд уулсын дээд хажуугаар нимгэн цайвар хүрэн ба хүрэн хөрс, Ихбогд, Багабогдын оройгоор нутгын хөрстэй. Давсархаг хөрс элбэг.

Хонхор газраа орчны газраас салхи, усаар туугдаж ирсэн амархан уусдаг бодис, элдэв давс хуримтлагддагаас марз үүснэ.

Ургамал нь тачир, таруу, энд тэнд жижиг бут маягаар ургадаг. Бүсийн зүүн хэсэгт бор хөрсөнд ботуул, хялгана, шарилж, тогторгоно, монгол өвс ургах бөгөөд хазааргана ширэг зэрэг хээрийн ургамал, өмнөд хэсэгт харгана, боролзой, багалуур, тэсги, бор шаваг зэрэг говийн ургамал зонхилен.

Говь-Алтайн уулсад уулын сонгино, монгол өвс голлон ургана. Нам газруудаар бор бударгана, багалуур, ортууз, хотир, шаваг, шар бударган, хар суль, биелэг өвс, цагаан түнгэ, хойрог, харгана, говийн хунчир зэрэг нь эндхийн унаган ургамал юм. Модлог ургамлаас заг ургана. Заг элсэрхэг, чулуурхаг газарт төгөл ой маягтай ургадаг. Говийн хуурай сайрын дагуу хайллас ургана.

Говийн ба цөлийн бүсэд манай арваад аймгийн 80-аад сумын 270-аад мян. хүн амьдарч 7 сая орчим мал бэлчиж байна. Энд ус бэлчээрийн аяыг дагаж олон нүүдэллэх бэлчээрийн мал аж ахуй, түүний дотор ямаа, тэмээний аж ахуй илүү хөгжсөн. Өвс ургамал нь тачир сийрэг учраас бэлчээрийн даац сайн биш. Малчид 150 км хүртэл хол нүүдэллэж малаа өсгөнө. Хүн малын ундаанд гүний усыг ашиглана.

Энд дулааны нөөц хангалттай, хоногийн дундаж температур нь +10°C-аас их, хоногийн тоо 150 түүнээс олон учраас дулаан их шаарддаг наранцэцэг, цагаан будаа, хулуутны овгийн ургамал, улаан лооль, хөвөн, усан үзэм, өргөст хэмх зэрэг ургамлыг усалгаатайгаар тарьж ургуулах боломжтой. (44, 46, 47-р зургуудыг үз)



“Хонгорын элс” хэмээх энэ гайхам сайхан газраас байгалийн олон янзын дүр төрхийг нэгэн зэрэг харж болно.

Говь-Алтайн нурууны үргэлжлэл болох Сэврээ уулс бараантан сүндэрлэж, түүнтэй өрсөн дүйх “элсэн манхануулс” дүнхийнэ. “Элсэн уулс”-тай зэрэгцэн өтгөн ногоон ширэг дундуур Хонгорын цэнгэг уст жижиг гол урсах ажээ. Энд очсон хүн нэг хөлөө ногоон зүлгэн дээр, нөгөө хөлөө элсэн дээр тавиад зогсож болох аж.

Байгаль хосгүй өвөрмөц хослолыг хэрхэн бүтээдгийг чухам эндээсл харж болно. Ийм ч учраас тэр зүг хөлхөх дотоод гадаадын зочин гийчний хөл тасардаггүй юм.

“Хонгорын элс” хэмээх энэ элсэн манхан нь манай орны нутгийн

өмнө хэсэгт Говь-Алтайн Сэврээ, Баянбор, Гурван сайханы нуруудын хөндийгөөр баруун хойноос зүүн урагш чиглэн 185 км урт үргэлжилсэн том элсний нэг хэсэг юм. Элсний гол хэсэг нь Өмнөговь аймгийн Сэврээ сумын нутагт орших ба хамгийн өргөн газраа 20 км хүрдэг. Элсний нийт талбай 925 ам.км бөгөөд энд харьцангуй өндөр 200 м-ээс ч илүү гарах өндөр манханууд бий. Өвс ургамалгүй учир алсаас харахад үтрэм дээр нуруулсан шинэ улаан буудай мэт санагдах нь нэн сонин. Зүүн урд захын төгсгөл хэсгийг нь *Төхөмийн элс* гэж нэрлэдэг. Увс нуурын хонхор дахь Бөөрөгийн элсийн хойд зах нь х.е 500 18-д хүрэх бөгөөд энэ нь дэлхийн их талбайтай манхт элсний хойд захын цэгийн нэг юм.



79 дугаар зураг. Хонгорын элс (Өмнөговь аймаг, Сэврээ сум)
(Цаана нь Сэврээ уул, наана нь Хонгорын голын зүлэг)



1. Хэрэв танай сургууль.govийн ба цөлийн бүсэнд буюу энэ бүсэд ойролцоо оршдог бол дараах ажиглалт хийж дүгнэлт гаргаарай.
 - VII сард хамгийн их халуун, I сард хамгийн их хүйтэн болоходоо хэдэн хэм хүрч байсан бэ? VII ба I сард дунджаар хэдэн хэм халуун ба хүйтэн байдаг вэ?
 - Намар өвөл хэдийд цасан бүрхүүл тогтдог, хавар хэдийд цас цоохортон ханзардаг, цасны зузаан хэдий хэр байдаг, цастай байх хугацаа хэд хоног үргэлжилдэг вэ?
 - Ган болох явдал хэр ойрхон давтагддаг, хэдийд хамгийн сүрхий ган болов? Ямар байдалтай байв?
 - Хүчтэй салхи, угалз, шороон шуурга хэр их болдог вэ? Хамгийн сүүлд хэдийд болов?
2. Танай сум.govийн бүсэд оршдог бол сумасаа хойш болон урагшаа байгалийн төрх байдал ямар болж өөрчлөгдхөхийг төсөөлөн бодож ярилц
3. Үүр амьсгалын бүлэгт байгаа зургуудыг ажиглаж.govийн ба цөлийн бүсийн уур амьсгалын талаар эх зохион бич.
4. Говийн ба цөлийн бүсийн ургамлын навч жижиг, зарим нь бүр нарийхан байдгийн учрыг эзэмшсэн мэдлэгээ ашиглан тайлбарла. (Хариуг Дадлага ажлын номоос үз)
5. Байгалийн нөхцөл өөрчлөгдөхөд нөлөөлөх хүчин зүйлсийг нэрлэж тайлбарла.
6. Дараах хүснэгтийг ажиглаж, байгалийн ямар бүсэнд ямар, ямар төрлийн мал аж ахуй эрхлэхэд тохиромжтой болохыг ялган бичээрэй.

Мал аж ахуйд нөлөөлөх байгалийн нөхцөл

| Мал аж ахуйн төрөл | Байгалийн нөхцөл |
|--------------------|------------------------------------------------------------|
| Тэмээ | $h=1500$ м-ээс доош $t=-3^{\circ}$ - aac 15° |
| Адуу | $h=$ нам уулс ба талархаг хээр |
| Монгол үхэр | $h=$ дундаж өндөр уул, $t=-15^{\circ}$ - aac $+15^{\circ}$ |
| Сарлаг | $h=2400$ м < өндөр уулын бүс |
| Хонь | нам уулс ба талархаг хээр |
| Ямаа | $t=<+15^{\circ}$ уулт хээрийн бүс |


30. ӨНДРИЙН БҮСЛҮҮР

Манай орны өндөр уулсад үүсэх босоо бүслүүр нь Альп, Гималай, Андын уулсынхаас ялгаатай. Манай өндөр уулсаар тайгиын, тагийн гэсэн үндсэн бүслүүрээс гадна мөнх цасны гэсэн З бүслүүр ялгарна. Гэхдээ уулсын орших өргөргөөс шалтгаалан босоо бүслүүрийн өндөр нь уулс бүрт өөр өөр.

Манай орны өндөр уулсад 1800-2300 м орчим өндөрт тайгиын бүслүүр үүснэ. Хэнтийн ба Хөвсгөлийн уулсад тайга их тархсан ба Хангайн уулсад арай бага. Монгол Алтай, Хархираа, Түргэний уулсад арай хуурай учир тайгиын бүслүүр байхгүй, зөвхөн ойт-хээр, уулын хээр л бий. Тайгиын бүслүүрт

нэлзээд сэргүүн, VII сард дунджаар +12⁰C, түүнээс бага боловч 400-500 мм тунадас унана. Цас их унадаг, зарим газраа 1 метрээс зузаан цас тогтоно.

Тайгад ойн ширэгт хөрстэй, ойгүй газар нь хар шороон хөрс, уулын ам хөндийгөөр нь нуга намгийн хөрс тархсан. Хэнтийн уулсад тайга 2000-2300 орчим метр өндөрт байх ба дээд хэсгээрээ хүш, түүнээс доош шинэс голлон ургадаг. Тайгад бадаан, арц, адирс, башир, тошлой, алтан гагнуур, хөвөнт, нэрс, сургар, нохойн хушуу, сарнай, тэрэлж, хонилин, дэгд ургана. Хөрс нь хөвдөөр бүрхэгдсэн.



80 дүгээр зураг. Найман нуур нь Хангайн гол нурууны ар дор оршдог. Нуурын урд эрэгт ойн бүснээс дээш тагийн бүс үүссэн нь тод харагдана.

Монгол ардын аман зохиолд
өртөнцийн гурван ногооныг
“Талд ургадаг зээргэнэ ногоон
Тайгад ургадаг хуш ногоон
Тагт ургадаг арц ногоон” гэж
тодорхойлсон байдаг.



Хангай, Хэнтий, Хөвсгөлийн уулс,
Алтайн уулсад **2300** орчим метр, Говь-
Алтайн уулсад **3000 м**-ээс дээш тагийн
бүслүүр оршино. Энд жилийн дундаж
температур нь -8°C орчим, VII сарынх
 8°C -аас бага, жилдээ 500 мм ба түүнээс
их тунадас унадаг.

Тагийн бүслүүрт уулын нугын
хөрстэй, дан асга чулуун оргил ч их.
Байнга хүйтэн, сэрүүн уур амьсгалтай
учир ой модгүй, ургамал нь тачир
сийрэг, тундрын төрхтэй. Энд улалж,

бушилз ноёлохын хамт биелэг өвс,
мэхээр, зожиргоно, дэгд, бургас, арц,
далан, хальс тавилгана, хаг элбэг
ургана.


Тагийн бүслүүр их яруу найрагч
Б.Явуухлангийн тодорхойлж бичсэнээр:

“Үүлэн нүүдэл өөхийн зүссэн
Үзүүрт модон ургаагүй хяр
Зуны бороо цасаар буудаг
Зуурам хөлдүү хангайн царам” юм.
Алтай Таванбогд Хархираа, Түргэн,
Цамбагарав, Хангайн Отгонтэнгэр,
Хөвсгөлийн Соёны уулын Мөнхсарь-
дагийн оргилуудад тагийн бүслүүрээс
дээш мөнх цасны бүслүүр илэрнэ.
Энд VII сард дунджаар -0°C -аас бага
байдаг.



81 дугаар зураг. Өндөр уулсын зарим ургамал

1. Хөвөнт, 2. Тошлой, 3. Алтангагнуур, 4. Башир цэцэг, 5. Хонилин, 6. Өлчир дэгд



Гурвалжин шүрэн
үндэс



Сибир жодоо




Дагуур сараана



Адамсын Тэрэлж
/Даль/



Алтан тэрэлж



Нэмрөгт банздоо
/Вансэмбэрүү/



82 дугаар зураг. Өндөр уулын бүсийн нэн ховор зарим ургамал

Монгол Алтайн уулсад 3300 орчим метр өндөрөөс, Хархираа, Түргэн, Ихтүргэний уулсад 3400 орчим метр өндөрөөс, Хангайн уулсад 3500 орчим метр өндөрөөс, Соёны ууланд 3300 орчим метр өндөрөөс мөнх часны хил үүсчээ. Эдгээр уулсад байх мөнх цас, мөсөн голын талбай 540 ам км хүрнэ. Алтай Таванбогд, Цамцагарав, Хархираа, Мөнххайрхан, Түргэний уул-

сад мөстлөгийн талбай хамгийн их. Алтай Таванбогдын зүүн хойд хажуу руу буусан 20 км урт Потанины мөсөн гол хамгийн урт нь юм.

“Мөчид дөрвөн хөлтний

Мөр нь гараагүй оргил

Мөгөөрсөн нимгэн хоолойтны

Дуу нь хүрээгүй оргил”

(Ардын уран зохиолч Ц. Дамдинсүрэн)



83 дүгээр зураг. Жаргалант хайрханы нуруу



Уулын бэлд нь дулаан байснаа оройд нь сэруүн болдог. 1351 м өндөрт оршдог Улаанбаатарт VII сард дунджаар $+17^{\circ}\text{C}$ дулаан байдаг бол 2268 м өндөр Богдхан уулын оройд хэдэн хэм дулаан байх вэ?



- Хэнтийн ууланд 2300 орчим метр хүртэл өндөрт тайга, түүнээс дээш тагийн бүс үссэн байтал 2800 орчим метр өндөртэй.govийн Гурван сайхан ууланд ой тайгын бүслүүр үүссэгүйн учир юу вэ?
- 3590 м өндөр Арцбогд ууланд мөнх цас, мөсөн гол байхгүй. Гэтэл Соёны нурууны оргил Мөнхсарьдагт 3300 метр өндөрөөс мөнх часны бүслүүр үссэндийн учрыг тайлбарлаарай. (Хариуг Дадлага ажлын номоос үз)



Байгалийн нөхцөл нөөц аж ахуй эрхлэлтэд хэрхэн нөлөөлдөг болохыг дараах байдлаар дүгнэн үзэж болно.

Байгалийн нөхцөл ба тариалан эрхлэлт

| Байгалийн бүс | Байгалийн нөхцөл | Тариалахад тохиromжтой ургамал |
|-----------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------|
| Ойт хээрийн бүс | T 10°C < = 40°-1400°C, өндөр уулсаар 400°C >, нэн хүйтэн, ургамлын чийг хангамж =55-100% ба чийгэвтэр, өндөр уулсаар100%-< тунадас =300-500 мм, цасан бүрхүүл XI.1-ээс IV.10/V.1 түүнээс хойш, чийгийн илүүдэлтэй учир ургах хугацаа багино, голын сүлжээний нягтшил 0.30-0.35 км/км ² , газар доорх урсац 50 мм < | Үргах хугацаа богинотой, дулаан бага шаардах, эрт болцтой хүнсний ногоо болон хүлэмжийн ногоо |
| Хээрийн бүс | T 10°C < = 140°-2000°C, ургамлын чийг хангамж =10-30% ба зүүн хэсгээр 30-55% буюу гандуу, тунадас =200-300 мм буюу чийг дутмаг | Эрт болцтой таримал хөх тария |
| Говийн бүс | T 100C=200°-3000°C, ургамлын чийг хангамж > 10% нэн хуурай тунадас =100-200 мм, цасан бүрхүүл XII.1 XII.10 -аас II.10, түүнээс эрт, голын Σ эрлижээний нягтшил < 0.10 км/км ² газар доорх урсац <5 мм | Хожуу болцтой таримал үрийн эрдэнэ шиш, наранцэцэг, шар буурцаг, тутарга, тарвас |
| Цөлийн бүс | T 10°C < = 300° < °C, ургамлын чийг хангамж =55-100% ба чийгэвтэр, өндөр уулсаар100%- < тунадас =50 > мм, нэн хуурай | Хожуу болцтой ургамал, эрдэнэ шиш тутарга, усалгаатай газар тариалан |




1. Ямар ямар аймгууд.govийн ба цөлийн бүсэд оршдогийг ярилцаарай.
2. Байгалийн 4 бүсийн дулаан хүйтэн, хур тунадасны байдлыг өөрийн нутгийнхтай харьцуулж ярилцаарай.
3. Танай сургууль байгалийн ямар бүсэд оршдог вэ? Өөрийн бүсээ бусад бүсээс хаагуур, хэдий хэр зайд оршиж байна гэдгийг газарзүйн зураг дээр ярилцаарай.
4. Та бүхэн элбэг тархсан 20 ургамлын хатаадас хийж ав. Хатаадастай бол түүнээ үзэж ярилцаарай.
5. Байгалийн бүс бүрийн ургамлаас нэрлэ. Шинж байдлыг нь ярилц.
6. Танай бүсэд эмийн ба хүнсний ямар ямар ургамал ургадгийг нэрлэж ярилцаарай.
7. Үүр амьсталын зураг үзэж жилийн дундаж хэм нь $+2^{\circ}\text{C}$, VII сарын дундаж нь $+20^{\circ}\text{C}$ байгаа нутгийн заагийг олж ав. Ямар ямар аймаг хамрагдаж байгааг нэрлэж ярилц.
8. Мөн зургаа ашиглан жилийн дундаж хэм нь $+6^{\circ}\text{C}$, VII сарын дундаж нь $+24^{\circ}\text{C}$ байгаа нутгийн хойд хилийг олж ав.
9. Цаг уурын мэдээгээр “Арцбогдын урд хоолойгоор хүчтэй салхитай” хэмээн зарлагддаг нутаг нь Өмнөговь аймгийн Булган сумын хавьд юм. Булган сумын төвийг зургаас олж газрын хотгор, гүдгэрийн байдлыг ярилцаарай!
10. Манай нэгэн найрагч загийг

“Голдоо хүртэл хатсан юм шиг
Говийн заг хатуу ч гэлээ
Нарны элчинд ноцтол халсан
Нарийхан мөчир нь ногоон билээ” гэж дүрсэлсэн байдаг. Энэ нь ямар зохиолчийн ямар нэртэй бүтээл вэ?
11. Бөөрөгийн элсний хойд зах х.ө. $50^{\circ} 18'$ -ын цэгийг зурагт олж заа.
12. Хээрийн ба ойт-хээрийн бүсийн байдлыг харьцуулж дүгнээрэй.

| Аялалын төслийн төрөл | Вийн аялалын төрөл |
|-----------------------------|-----------------------|
| | |



13. Дараах зураг болон хүснэгтийг ажиглаж байгалийн бүс ялгараход дулаан (температур), чийг (тунадас мм)-ийн харьцаа хэрхэн нөлөөлснийг тайлбарла.



| Суурин газрууд | Орших өндөр Дтд.м | Дундаж хэм /t°C/ | | | Жилд унах тунадас /мм/ |
|----------------------------|-------------------------|------------------|---------|-----------|------------------------------|
| | | Жилийн | I сарын | VII сарын | |
| Даланзадгад Х.ө. 43°34' | 1465 | +4° | -16° | +20° | 129.5 |
| Улаангом Х.ө. 49°59' | 939 | -3.7° | -32° | +16° | 138 |
| Эхийн гол Х.ө. 43°15' | 1000 | 8.3° | -11.8° | 26.2° | 50 орчим |
| Сайншанд | 938 | 3.5° | -18.4° | 24° | 115.9° |



inter NET

<http://en.mongoliatoday.mn>
<http://www.mongolclimate.mn>
<http://www.google.com>
<http://www.olloo.mn>

БАЙГАЛИЙН АШИГЛАЛТ ХАМГААЛАЛТ

9

Гол агуулга

- Байгаль хамгаалах уламжлалт арга
- Улсын тусгай хамгаалалттай газрууд
- Экологийн тулгамдсан асуудлууд

Юу мэддэг болох вэ?

- Байгаль хамгаалах уламжлалт аргууд болон байгалийн нөөцийн ялгаа
- Улсын тусгай хамгаалалттай газрууд, тэдгээрийн ялгаа, онцлог, байрлал
- Экологийн тулгамдсан асуудлууд, түүнийг шийдвэрлэх арга замуудын талаар мэддэг болно

Юу чаддаг болох вэ?

- Байгаль хамгаалах аргуудыг эзэмших
- Улсын тусгай хамгаалалттай газруудыг газрын зурагт тэмдэглэж заах
- Улсын тусгай хамгаалалттай газруудын онцлог, ялгааг тайлбарлах, ач холбогдлыг дүгнэх
- Экологийн тулгамдсан асуудлуудын учир шалтгаан, үр дагаврыг тайлбарлаж чаддаг болно

Мэдлэгээ хэрхэн хэрэглэх вэ?

- Байгаль хамгаалах ач холбогдлыг ойлгож, амьдрал дээр хэрэгжүүлэх
- Өөрийн орон нутгийн экологийн тулгамдсан асуудлуудыг дүгнэн гаргаж шийдвэрлэх арга замыг тодорхойлж хэрэгжүүлэх ажил зохиох
- Орон нутгийнхаа болон эх орныхоо байгаль, экологийг хамгаалах хүмүүжил төлөвшүүлэх
- Байгаль хамгаалах санал, санаачлага гарган дэлгэрүүлэх хүсэл эрмэлзэлтэй болно

31. БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ

Байгалиа хамгаалах гэдэг нь байгалийг ашиглахгүй байна гэсэн үг биш. Хүн төрөлхтөн байгалийг ашиглахгүй гээр амьдрах аргагүй юм. Хотжилт их хөгжсөн, том үйлдвэр, хүн ам олонтой зарим улс оронд байгаль нь унаган төрхөө алдаж, хүний аж ахуйн үйл ажиллагаанд нэрвэгдээгүй газар бараг үгүй болжээ. Жишээ нь: Европын орнууд гэхэд л хааягүй тариалангийн талбай, ногооны газар, засаж янзалсан зам, үйлдвэр уурхай, хот суурин, орон байр, барилга байгууламж, гүүр далан, суваг шуудуу болон хувирсан байдаг. Энэ нь байгалийг ашиглах талдаа сайн боловч, ийм улс оронд онгон цэвэр байгаль үгүйлэгдэхэд хүрдэг ажээ. Байгалийн нөхцөл, нөөц баялагийг ашиг-

цаг, ус, гол, газар хөлдөх, шувуу буцах, өвлийн улиралд бэлтгэх, намар цагт байгаль хамгааллын ажилд анхаарал тавьж ирсэн сайхан уламжлал бий.

Байгалийн нөхцөл, нөөц нь хүний эрүүл мэндэд, тав тухтай амьдрахад ихээхэн нөлөөтэй билээ. Байгалийн нөхцөлд газрын өндөр нам, агаарын даралт, чийгшил, дулаан хүйтэн зэрэг орно. Алтай, Хангай зэрэг өндөр ууланд хүйтэн, сэргүүн жихүүн, агаарын даралт тал газрынхыг бодвол бага, тэндхийн хүмүүс ч үүндээ дассан байдаг.

Байгалийн нөөцөд газрын хэвлэйн баялаг, хөрс, ургамал, усны эрдэс бодисын найрлага ордог. Усны найрлага хүний эрүүл мэндэд их нөлөөтэй.




лах, үйл ажиллагаа ихсэж байгаа өнөө үед байгаль хамгаалах, ашиглах ажлыг их ухаалаг, зөв зохистой авч явуулах нь хүний эрүүл мэнд, амьдралд зайлшгүй чухал болоод байна.

Манайд газар гэсэх, мод ургамал тарих, шувууд ирэх, мал, амьтан төллөх, улирал эхлэх, үргэлжлэх, хавар

Нутгаасаа өөр газарт амьдрахад агаар, ус таарахгүй байна гэж ярьдаг нь үүнтэй холбоотой. Байгалийн нөхцөл, нөөц баялаг хүний эрүүл мэндэд хэрхэн нөлөөлдгийг судалдаг эрүүл мэндийн газарзүй гэж салбар ухаан бий болжээ. Хээрийн хүрэн хөрсөнд уураг ихтэй учраас хонины ноосны гарц

сайн байдаг бол ойн бүсэд ургадаг тарианы найрлаганд нүүрс ус харьцангуй ихтэй бөгөөд нутгийн дулаан, хүйтэн, чийг, агаарын даралт зэрэг байгалийн хүчин зүйл нь эрхэлж буй аж ахуйд их нөлөөтэй байдаг. Энэ бүгдийг харгалзан чанарын газарзүй гэдэг салбарыг хөгжүүлж болохоор юм. Мөн бөх, дуучин, уран бүтээлч гээд хөдөлмөрч, ухаалаг, бүтээлч хүмүүс төрдөг нутгууд ч бий. Энэ

бүгдийг бодолцон авьяас чадварын газарзүй гэдэг салбар ухаан ч хөгжих боломжтой юм. Ер нь хүний амьдралд таатай байгалийн нөхцөл гэж бий. Хүн биений хүчний, болон сэтгэл санааныхаа ядаргааг гаргахын тулд зориуд амралтын зорилгоор газар нутаг үзэх, рашаан сувилалд амрах явдал байдаг. Байгалийн нөхцлийн хүний амралт зугаалгад тааламжтай нөхцөл гэж байдаг.



32.

МОНГОЛЧУУДЫН БАЙГАЛЬ ХАМГААЛАХ УЛАМЖЛАЛ

Монголчууд уул ус, нутаг бэлчээрээ элбэг баян, цэвэр ариун, сүрлэг сайхан байлгахыг эрхэмлэн дээдэлж ирсэн түүх нь Хүннү нарын үеэс улбаатай юм.

Ерөөс хүн төрөлхтөнд байдаг байгалийг шүтэн бишрэх үзэл нь Монголчуудын хувьд уул усыг “эзэнтэй”, “догшин, лус савдгатай” гэж бодон түүнийг зөрчсөн хүмүүс байгалиас цээр-

лэл хүлээдэг хэмээн үзэж ирсэн явдал юм. Иймээс ч уул усаа "хайрхан", "хан уул", "баян уул", "рашаан" гэхчлэн эрхэмлэн нэрлэдэг. Овоонд чулуу нэмэрлэх, газар уул хадыг ухаж төнхөхийг цээрлэх, газрыг хөндөхдөө сар, өдөр, цагийн сайныг сонгон авч гахайгаар хадруулах, ороонго, гөрөөсний эврээр хөндөж эхлэх зэргээр дом шившлэг үйлддэг нарийн ёс журам бий. Эдгээр нь зан үйл, ёс заншлын уламжлал юм.

Чингис хаан Бурханхалдун уулыг "Үүрд тахиж байхыг андгайлж" байснаас эхлэн уул усаа тахин хүндэтгэх ёс үүсжээ. Төрөөс ёслол үйлдэн тахилга хийдэг уулыг "Их тахилгат уул" хэмээн өргөмжлөн нэрлэдэг. Их тахилгат ийм уулс нь эзэн Чингисийн үеэс тахиж ирсэн Хэнтийхан, /Бурханхалдун/, Богдхан, Завханы Очирваань богд Отгонтэнгэр, Сүхбаатарын Дарьганын Алтан-Овоо, Ховдын Алтанхөхий юм.

Харин XYIII зууны үеийн "Халх журам" хуулинд ховор амьтан ургамлыг хамгаалах, агнахыг хориглох, тодорхой газарт ан агнахыг хориглох, агнах хугацаа заасан заалт орж байсан нь одоогийн байгаль хамгаалахтай холбоотой 30 гаруй хуулийн эхлэл гэж үзэж болно.

Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтанд авах нь байгалийг хамгаалах гол хэлбэр юм. Монгол улсад 1778 оноос Богдхан уулсыг дархлан хамгаалж ирсэн бөгөөд энэ нь дэлхийн анхны дархан газрын нэг юм.

Улсын хамгаалалттай газрыг "Дархан цаазат газар" гэж ганцхан зэрэглэлээр авч үзэж байснаа 1994 онд "Улсын тусгай хамгаалалттай газрын тухай" хуулиар ийм газар нутгийг 4 ангилан үзэхээр болжээ. Энэ нь:

1. Дархан цаазат газар,
2. Байгалийн цогцолборт газар,
3. Байгалийн нөөц газар,
4. Дурсгалт газар юм.


XVIII зууны Халх журам хуулинд "Ан агнаж үл болох өдрийг шинжиж 8-р сарын 15, 13, 25, 30-ны өдөр" хэмээн зааснаас гадна хүрээ зассан "хүрээнээс хуурай нойтон мод огтлохгүй", "Сангийн даваа зэрэг газрыг хамгаалалтад авах" гэх зэрэг заалт орж байжээ. Загас хамгаалах хууль 1922 онд, агууруын хууль 1933 онд гарсан байдаг.

Одоо манай улсын 13.5%-ийг эзлэх 209000 ам км талбай бүхий 55 газрыг Улсын тусгай хамгаалалтад аваад байна. Нутгийн тахилгатай уул ус ч иргэдийн байнгын хамгаалалтад байдаг, хуулиар хамгаалагдсан нутаг юм.

Дархан цаазат газар: "Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тухай" хуулинд заасан нь: "Байгалийн бүс бүслүүрийн онцлог, хэв шинжийг төлөөлж чадах унаган төрхөө хадгалсан байдал, шинжлэх ухааны онцгой ач холбогдлыг харгалzan байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах зорилгоор улсын тусгай хамгаалалтад авсан зарим газар нутгийг *Дархан цаазат газар* гэнэ".

Байгалийн цогцолборт газар: "Байгалийн унаган төрхөө харьцангуй хадгалсан түүх, соёл, шинжлэх ухааны болон танин мэдэхүй, экологийн хүмүүжилд ач холбогдол бүхий улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг *Байгалийн цогцолборт газар* гэнэ".

Байгалийн нөөц газар: Байгалийн тодорхой хэв шинж, аль нэгэн нөөц баялагийг хамгаалах, хадгалах, нөхөн сэргээх нөхцлийг бүрдүүлэх, зорилгоор



84 Дугаар зураг. Улсын тусгай хамгаалалтай газар нутаг

улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг байгалийн нөөц газар гэнэ” гэж заагаад дотор нь “Байгалийн иж бурдлийн, Биологийн, Түүхэн олдворын, Геологийн нөөц газар” гэж ялган тодорхойлжээ.

Дурсгалт газар: “Байгалийн өвөрмөц тогтоц, түүх соёлын ул мөрийг уламжлагдан хадгалагдсан байдлаар нь өвлөн үлдээх зорилгоор улсын хамгаалалтад авсан газар нутгийг *Дурсгалт газар гэнэ*”. Дурсгалт газрыг байгалийн ба түүх соёлын гэж ангилна.



85 дугаар зураг. Цамбагарав уул

32. ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗРУУД



Дархан цаазат газар

| Нэрс, нутгийн хэмжээ /ам км/ 1. | Хамгаа- лалтанд авсан он 417 | Орших байгалийн бүс муж 1778 | Байршил Хэнтий нурууны ба- руун урд захад орших 2268 м өндөр уул 2. Хасагт- хайрхан уул 275 | Хамгаалах болсон Үндэслэл Дэлхийн ууган дар- хан газрын нэг. Шинэсэн ойн ургамал амьтантай. Тайгын төрх байдлыг хадгал- сан уул Говь, уулын хээр, ойн төгөл, тагийн бүслүүр оршино. Ирвэс, буга, аргаль, янгир амьдардаг |
|-------------------------------------------------|------------------------------------------|---------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 3. Хөхсэргийн нуруу 659 | 1965 | Говийн бүс, Алтайн уулс | Завхан гол, Шаргын хотгор, Хүйсийн го- вийн хооронд ор- шино. | Говь, уулын хээр, ойн төгөл, тагийн бүслүүр оршино. Ирвэс, буга, аргаль, янгир амьдардаг |
| 4. Говийн их дархан цаазат газар 53117 | 1977 | Өндөр уулсын бүс, Алтайн уул | Монгол Алтайн гол нурууны албарнуу. Ховд, Баян-Өлгий аймгийн нутгийн заагт оршино | Өндөр уулын тагийн бүслүүрийн хэв шин- жийг хадгалсан. Ирвэс, аргаль, янгир, шилүүс амьдардаг. |
| 5. Монгол дагуур 1030 | 1975 | Говийн бүс | “А” хэсэг нь Баян- хонгор, Говь-Алтай аймгийн урьд захын нутаг, “Б” хэсэг нь Ховд, Говь-Алтай аймгийн нутгийн заагийн урд захаар | Говь цэлийн экосис- темийг хамгаалах зорилгоор хамгаалал- танд авсан, мазаалай, хавтгай, жороо тоодог, ирвэс, хулан, хар сүүлт, аргаль, янгир зэрэг нэн ховор, ховор ан амьтдын өлгий нутаг |
| 6. Дорнод монголын тал 5704 | 1992 | Хээрийн бүс | Дорнод аймгийн нут- гийн зүүн хойд зах | Хар тогоруу, цагаан того-руу, цэн тогоруу зэрэг нэн ховор шувуудын өлгий нутаг. |
| | 1995 | Хээрийн бүс | Дорнод, Сүхбаатар аймгийн хилийн заа- гийн улсын хилийн наагуур орших нутаг | Хуурай хээрийн байга- лийн унаган төрх байдлыг хадгалсанхээр тал нутаг. (Мэнэнгийн тальн урд зах) |



| Нэрс, нутгийн хэмжээ /ам км/ 7. Нөмрөг 3112 | Хамгаа- лалтанд авсан он 1995 | Орших байгалийн бүс муж Хянганы салбар уулс | Байршил Дорнод аймгийн зүүн зах, Дэгээ, Нөмрөг голын сав | Хамгаалах болсон үндэслэл Хус, шинэсэн ойн төгөл ургах ба хээрийн ургамал, нарсан ой, ан амьтад элбэг. Нэн ховор халиу, гангара хун, хар мөрний хандгай амьдардаг. |
|-------------------------------------------------------------|-----------------------------------------------|----------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 8. Отгонтэнгэр 955 | 1992 | Өндөр уулын бүслүүр, Хангайн уулархаг | Хангай нурууны мөнх цааст оргил | Өндөр уулын хээр, ой хөвч, тагийн бүслүүр, мөнх цасыг нэг дор үзэж болох үзэсгэлэнт нутаг. Их тахилгат уул. |
| 9. Ханхэнтий 12271 | 1995 | Тайгын бүслүүр | Хэнтий нурууны зүүн хойд хэсэг | Тайгын бүслүүрийн терх байдлыг хадгал- сан, гурван голын эх, шинэсэн ой, ойн амь- тад тархсан, Чингис хааны дурсгалт нутаг. |
| 10. Увс нуурын орчим 7126 | 1993 | Говь, хээр, өндөр уулын бүслүүр | Увс нуур орчим, Хархираа, Түргэн, Цагааншувуут уул, Алтан элс | Уулын хээр, өндөр уулын ой, тагийн бүс, мөнх цасны байгалийн терхийг нэг дор үзэх боломжтой нутаг. |
| 11. Говийн бага дархан цаазат газар 18392 | 1993 | Говийн бүс | Дорноговь, Өмнөговь аймгийн нутгийн заа- гийн урд зах | Говийн байгалийн уна- ган төрхийг хадгалсан, загийн шугуйтай, ху- лан, хар сүүлт, аргаль, янгирын нутаг |
| 12. Хорьдол саарьдаг 1886 | 1997 | Өндөр уулын бүслүүр | Хөвсгөл нуураас ба- руун тийш орших | Нэн ховор вансэм- бэрүү, сибирь хунд- гана, ямаан сэргэг ургадаг. Хандгай, цаа буга, халиу амьдардаг, шохойн чулуун уул. |



- Хангайн нурууны хамгийн өндөр оргил болох Отгонтэнгэр уул, үзэсгэлэнт Бадархундага нуурын зургийг ажиглаад дараах асуултанд хариул. Уулын оройд мөнх цас байдгийн учир юу вэ? Бадархундага нуур ямар үүсэлтэй байж болох вэ? Нуурын ус цэнгэг үү, давстай юу



- Дархан цаазтай газруудыг нутаг дэвсгэрийн хэмжээгээр нь дараалуулж бичин графикаар илэрхийл.
- Байгалийн бүс бүрээр Дархан цаазтай газруудыг ялгаж хамгаалах болсон үндэслэлийг тодорхойлж бич. Хамгаалах арга хэмжээг хамтарч хийгээрэй.
- Дархан цаазтай газруудын талаар цуглуулга хийж бэлтгээрэй.



Байгалийн цогцолборт газар

| Нэрс, нутгийн хэмжээ /ам км/ 1. | Хамгаа- лалтанд авсан он Хөвсгөл орчим 8381 | Орших байгалийн бүс муж 1992 | Байршил Хөвсгөл нуурын ба-руун, зүүн талаар ул-сын хил хүртэлх нутаг | Хамгаалах болсон үндэслэл Эгц шовх оргилуудтай их оий хөвчтүүлэх, цэнгэг уст Хөвсгөл нуур орчмын нутаг |
|-------------------------------------------------|-------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 2. | Говь- Гурван- сайхан 26947 | Говь-Алтайн ул, Говийн бүс 1993 | Өмнөговь аймгийн нутагт орших Говь- Гурвансайханы ул | Говийн уулын байгалийн төрх байдлыг хадгалсан нутаг |
| 3. | Горхи- Тэрэлж 2932 | Хэнтийн уулархаг Ойт хээр 1993 | Ханхентийн ДЦГ- ын баруун заход оршино | Шинэсэн оий хөвчтүүлэх, уул хад цохиотой Тэрэлж, Туул зэрэг гол горхитой үзэсгэлэнт нутаг |
| 4. | Хорго- Тэргийн цагаан нуур 773 | Ойт хээрийн бүс 1965 | Архангай амийгийн Тариат сумын нутаг | Унтарсан галт уул, нуур бүхий байгалийн үзэсгэлэнт нутаг |
| 5. | Хангайн нууруу 8885 | Хангайн уулархаг өндөр уул- сын бүслүүр 1996 | Манай орны төв хэсэгт оршино | Шинэс голлосон оий хөвчтүүлэх олон уул, салбар нуруудтай |
| 6. | Хустайн нууруу 506 | Ойт-хээр 1993 | Хэнтий нууруны ба-руун урьд захын уул | Тахь нутагшуулж буй нутаг |
| 7. | Хар-Үс нуур 8503 | Их нууруудын хотгор 1997 | Ховд аймгийн Хар-Үс, Хар, Дөргөн, Зэргийн цагаан нууруд | Цагаан бэлбөө зэрэг нэн ховор ургамал, бөхөн, жороо тоодог, гангар хүн, тургуул бо-лон зэгсний гахай, хар сүүлт, хотон зэрэг ховор амьтад бүхий үзэсгэлэнт нуур |
| 8. | Алтай Таванбогд 6362 | Өндөр уулын бүслүүр 1996 | Баян-Өлгий аймгийн нутагт орших Монгол Алтай нууруны баруун захын хэсэг | Мөнх цаст, тагийн бүслүүрт өндөр уулын байгалийн унаган төрх байдалтай, мөстлөгийн моренд боогдох үүссэн гүн цэнхэр нууруудтай. |



| | | | | |
|---------------------------------|------|---------------------------|--------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------|
| 9. Ноён хангай уул 591 | 1998 | Өндөр уулын бүслүүр | Хангай нурууны төвхэсэгт Архангай аймгийн Хангай сумын нутаг | Ховор амьтан, ургамалт, нутгийн тахиалгат үзэсгэлэнт уул |
| 10. Тарвагатайн нуруу 5254 | 2000 | Өндөр уулын бүслүүр | Завхан, Архангай аймгийн нутгийн заагаар оршино | Сэлэнгийн урсгалын эх, ус хагалбарын нуруу |
| 11. Сийлхэмийн нуруу 1400 | 2000 | Өндөр уулын бүслүүр | Завхан, Архангай аймгийн нутгийн заагаар оршино | Алтайн аргалийн гол байршил нутаг |
| 12. Ханхөхий - Хяргас нуур 5534 | 2000 | Говийн ба ойт-хээрийн бүс | Увсаймгийн нутагт оршино | Цөлийн хээрийн бүсийн хойд хязгаар. Гандуу хуурай орчин устай хоршин байгалийн өвөрмөц байдалтай |
| 13. Цамба гарав уул 1110 | 2000 | Өндөр уулын бүслүүр | Баян-Өлгий, Ховд аймгийн нутгийн заагт оршино. | Мөнх цаст уул, эмчилгээний рашаануудтай, ирвэсийн гол нутаг |
| 14. Онон-Балжийн сав 4158 | 2000 | Ойт-хээр | Хэнтий аймгийн нутагт оршино | Сибирийн ой тайга, өмнөдийн Төв Азийн хуурай цөл хээр хөёрын шилжих заагийн байгалийн үзэсгэлэнт нутаг |
| 15. Дарьгангын 629 | 2004 | Тал хээрийн бүс | Сүхбаатараймгийн Дарьганга, Наран сумын нутаг | Их тахилгат Алтан овоо, Молцог элс, Сүмт, Ганга, Холбоо, Эрдэнэ зэрэг олон нууруудыг багтаасан нутаг |
| 16. Мянган Угалзат уул 600 | 2002 | Өндөр уулын бүс | Ховд Цэцэг аймгийн сумын нутагт | Монгол Алтайн гол нуруунд оршдог, Алтайн аргалийн гол нутаг |
| 17. Улаан тайга 108 | 2003 | Өндөр уулын бүс | Хөвсгөл аймгийн баруун хэсэгт орших нуруу | Тайгын экосистемийг хамгаалах зорилгоор хамгаалалтанд авсан |
| 18. Хөгнө-Тарна 843 | 1997 | Ойт-хээр | Булган аймгийн Гурванбулаг, Рашаант сумын зааг | Тайгын болон хээрийн ургамал, амьтан нэг дор оршин амьдардаг |
| 19. Тужийн нарс 800 | 2002 | Ойт-хээрийн бүс | Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хотын урдуур орших нарсан ой | Тэгш тал газар элсэн хөрсөнд ургасан дан нарсан ойтой |



1. Монгол орны уулсын ар хажуу ойтой байдаг. Харин Тужийн нарс тэгш гадарга дээр ургасны учрыг багшийн тусламжтайгаар мэдээд нарсан ойн ач холбогдлын талаар ярилц.



2. Хустайн нурууны тахийг аялал жуулчлалын үзмэр болгож ашигладаг. Тахь нутагладаг өөр газар бий юу? Чи юу мэдэх вэ?



3. Байгалийн цогцолбор газруудаас өндөр уулын бүслүүрт байдаг газруудыг нээрлэж гол онцлогуудыг тодорхойлоорой.
4. Хамгийн сүүлд бүртгэгдсэн цогцолборт газар хаана байдаг, ямар нэртэй вэ?



Байгалийн нөөц газар


| Нэрс, нутгийн хэмжээ /ам км/ | Хамгаа- лалтанд авсан он | Орших байгалийн бүс муж | Байршил | Хамгаалах болсон үндэслэл |
|---------------------------------------|-----------------------------------|-------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1. Батхаан уул 219 | 1957 | Ойт-хээр, хээр | Төв, Өвөрхангай аймгийн нутгийн заагт орших уул | Их ой, манхан элс, уул нурuu нэг дор хослон оршдог үзэс-гэлэнт нутаг |
| 2. Нагалхаан уул 31 | 1957 | Ойт-хээр | Төв аймгийн нутагт Иххэнтийн нuruуны баруун өмнө заход орших уул | Уулын хээр, ойт хээр хосолсон өвөрмөц тогтоцтой байгалийн үзэсгэлэнт нутаг |
| 3. Булган гол 77 | 1965 | Говийн бүс, Алтай уулархаг нутаг | Баян-Өлгий айм- гийн нутаг | Алтайн нuruуны өврөөс эх авч урсдаг гол. Нэн ховор амьтан минжийг хамгаалах зорилгоор улсын хамгаалалтанд авсан нутаг |
| 4. Лхачин вандад уул 588 | 1965 | Хээрийн бүс | Сүхбаатар аймгийн нутагт улсын хил орчимд орших уул | Буга амьдардаг. Цагаан зээ-рийн төллөх гол байршил нутаг |
| 5. Угтам уул 462 | 1993 | Хээрийн бүс | Дорнод аймгийн нутагт Улз голын урд хөвөө | Ойт хээр, хээрийн бүсийн заагт орших ой модтой уул. Монгол бүрэлгэнэ, цагаан цээнэ ургадаг. |
| 6. Шарга- Манхан 3901 | 1993 | Алтай уулархаг нутаг, Их нууруудын хотгор | Их Нууруудын хот- горын урд зах, | Хар-Ус нуурын урдуур, Бөхөн хамгаалах, өсгөх зорилгоор улсын хамгаалалтанд авсан нутаг |
| 7. Алагхайрхан 364 | 1996 | Өндөр уулын бүслүүр | Монгол Алтайн гол нуурунд Алаг нуурын хонхороос баруун хойш орших уул | Өндөр уулын таг, цармын байгалийн унаган төрхийг хадгалсан. Ирвэс, аргаль, янгир амьдардаг |
| 8. Бурхан буудай уул 521 | 1996 | Өндөр уулын бүс | Монгол Алтайн гол нуурууны зүүн хэсэгт Бэгэрийн хонхорын урдуур үргэлжлэх уул | Ирвэс, аргаль, янгир амь- дардаг, эртнээс шүтэж ирсэн уул |



| | | | | |
|-------------------------------------|------|----------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 9. Ихнаарт уул 437 | 1996 | Хээрийн ба говийн бүс | Дорноговь айм- гийн нутагт | Аргаль амьдардаг боржин чuluун уул, түүхийн дурсгал ихтэй |
| 10. Загийн усны хоолой 2736 | 1996 | Хээрийн ба говийн бүсийн зааг нутаг | Дундговь, Дорно- говь, Өмнөговь аймгийн нутгийн зааг | Цагаан зээр, хар сүүлтийн амьдардаг загийн шугуйтай, говийн байгалийн төрхийг хадгалсан |
| 11. Эргэлийн зоо 609 | 1996 | Говийн бүс | Дорноговь айм- гийн нутагт | Эртний амьтдын үлдэгдэл бүхий геологийн түүхэн олдворын нөөц газар |
| 12. Тосон Хулстай 4700 469 | 1998 | Хээрийн бүс | Дорнодын Цагаан- Овоо, Хэнтийн Баян-Овоо сумын зааг нутаг | Цагаан зээр төллөдөг гол нутаг |
| 13. Хар Ямаат уул 506 | 1998 | Хээрийн бүс | Хэнтий, Сүхбаатар аймгийн нутгийн зааг | Буга амьдардаг уул. Ганц цэцэгт алтанзул, монгол бүрэлзгэнэ, том дохиурт сонгино зэрэг нэн ховор ургамал ургадаг |
| 14. Яхь нуур 2514 | 1998 | Хээрийн бүс | Дорнод аймгийн нутагт орших | Нуур орчмын нутаг, Цагаан зээрийн тархацын хойд зах |
| 15. Дэвэл арал 103 | 2000 | Алтайн уулархаг | Баян-Өлгий, Увс аймгийн зааг, Ачит нуурын Усан хоолой, Ховд го- лын дундах арал | Нэн ховор гургуул, минж зэрэг амьтдын байршил нутаг |
| 16. Намнан уул 296 | 2003 | Ойт хээрийн бүс | Хөвсгөл, Булган аймгийн нутгийн заагт | Их ой модтой, ургамал, ан амьтан элбэгтэй нутаг |
| 17. Ханжарга лант уул 600 | 2003 | Ойт хээрийн бүс | Булган аймгийн нутаг | Их ой модот уулын байгалийн төрх байдал, биологийн төрөл зүйлийг хамгаалах зорилгоор улсын хамгаалалтанд авсан |
| 18. Их газрын чулуу | 2003 | Тал хээрийн бүс | Дундговь аймгийн Гурван сайд хан сумын нутаг | Их боржингийн бүсэд багтаж хадан цохиот уул |



- Та нар Лхачинвандад уулыг ямар аймгийн нутагт байдгийг бичээд газрын зураг дээр олоорой. Энэ нутаг байгалийн ямар бүсэд багтдаг вэ?



- Бөхөн үзэхийн тулд жуулчид хамгийн ойрхондоо хаана очвол зохих вэ?
 - Угтам уул
 - Шарга-Манхан
 - Батхаан уул
 - Хар ямаат уул
- Дэвэл арал дээр нэн ховор ямар ямар амьтад байдаг вэ? Энэ нь хаана байдаг арал вэ?
- Дундговь аймгийн нутагт байдаг Их газрын чулуу хэдэн онд тусгай хамгаалалттай газар нутагт багтсан бэ?
- Байгалийн нөөц газрын хүснэгтээс цагаан зээр амьдардаг нутгуудыг олж тэмдэглээрэй.




Äöödñääëö ãàçàð

| Нэрс, нутгийн хэмжээ /ам км/ хамгаалалтанд авсан он | Хамгаа- лалтанд авсан он | Орших байгалийн бүс муж | Байршил | Хамгаалах болсон үндэслэл |
|--------------------------------------------------------------|-----------------------------|-------------------------------|---------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1. Булган уул 18 | 1965 | Ойт- хээрийн бүс | Архангай аймгийн Цэцэрлэг хотыг нө-мөрлөж уул | Байгалийн үзэсгэлэнт, түүхийн дурсгалт тахилгат уул |
| 2. Уран уул 58 | 1965 | Ойт- хээрийн бүс | Булганы нутагт, Бүрэн-гийн нурууны төгсгөл | Ойт-хээрийн бүсэд орших унтарсан галт уулс бүхий байгалийн үзэсгэлэнт нутаг |
| 3. Ээжхайрхан уул 225 | 1995 | Говийн бүс | Говь-Алтай аймгийн Захуйн баянбүрдийн баруун хэсэг | Байгаль, түүхийн дурсгалт боржин чулуун уул |
| 4. Хүйсийн найман нуур 115 | 1992 | Өндөр уулын бүслүүр | Хангайн Байгалийн цогцолборт газрын зүүн урд оршино | Хангайн гол нурууны ар дор галт уулын хүрмэн чулуунд боогдож үүссэн хонхорт тогтсон өөр хаорондоо холбоотой 9 нуур |
| 5. Сүйхэнт 48 | 1996 | Говийн бүс | Дорноговь аймгийн Мандах сумын нутаг | Чулуужсан модон ой ил гарсан байгалийн ховор тогтоцтой нутаг |
| 6. Шилийн богд Хөргийн хөндий 232 | 2004 | Тал хээрийн бүс | Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутаг Дарьгангын 220 унтарсан галт уулсын нутаг. | Ойт-хээрийн ургамал- тай. Хөргийн хөндийд 7 хүн чулуу байдал |



1. Өвөрхангай аймгийн Уянга сумын нутагт байдаг Түрэг бичээс бүхий Онгийн хөшөө нь ЮНЕСКО-ийн хамгаалалтанд орсон эртний чухал дурсгалын нэг. Та нар өөр ийм дурсгалтай газар нутаг мэдэх үү?







2. Аулган аймагт байдаг Уран уул нь Бүрэнгийн нурууны төгсгөлд байдаг унтarsan галт уул юм. Энэ уулын ойролцоо байгаа унтarsan галт уулсыг олоорой. Манай оронд байдаг унтarsan галт уулууд хэдий үед ажиллагаатай байсан болохыг тодруулж тайлбарлаарай.



3. Хүйсийн найман нуур нь Хангайн гол нурууны ар дор байрладаг. Тэнд байдаг нууруудыг нэрлээрэй.
4. Архангай аймгийн Булган уул нь улсын тахилгат уул мөн үү? Тахилгат уулс нь дотроо хэдэн төрөл байдаг вэ?





86. Говийн их дархан газар нь

Говийн их дархан газар нь хүний аж ахуйн үйл ажиллагаанд өртөөгүй онгоноороо үлдсэн дэлхийн цөөн.gov, цөл нутгийн нэг юм. 1975 онд хамгаалалтанд авсан энэ дархан газрын "А" хэсэг нь Баянхонгор, Говь-Алтай аймгийн урд захын нутаг, "Б" хэсэг нь Ховд, Говь-Алтай аймгийн нутгийн заагийн урд захаар оршино. Энд тогтоцын хувьд Тэнгэр уултай холбоотой Байтаг, Хавтаг, Атас, Чингис, Сэрг Цагаанбогд, Эдрэнг зэрэг өндөр уулууд орших бөгөөд урагшлах, зүүн тийшлэх тутам намсан талархаг хэлбэртэй болж Цэнхэр номин зэрэг уудам говиуд болно. Том уулуудын ам хөндийд Шархулсны, Цагаанбургасны, Талын мэлтэсийн зэрэг баян бүрдүүд бий.

Энд дэлхийд ховор, манайд нэн ховор болсон Монгол тост,

улаантулам, хавтгайн будраа, улаан түнгэ, жигд, мөнххаргана, тоорой зэрэг ургамал, мөн нэн ховор мазаалай, хавтгай, жороо тоодог, уулсаар нь ирвэс болон ховор амьтдаас хулан, хар сүүлтий, аргаль, янгир зэрэг амьтад амьдардаг.

Алтай Таванбогд уул. Алтай Таванбогд уулыг түүний оргил мөнхцэст манай улсын хамгийн өндөр 4374 м өндөр Хүйтэн уулнаас зүүн урагшаа улсын хил дагуу орших гол нуруу Өвчүү, Ёлт уулууд болон Хоргон, Хотон, Даян нууруудыг хамрах нутаг.

Энд мөнх цаст, тагийн бүслүүрт өндөр уулын байгалийн унаган төрх байдалтай мөстлөгийн моренад боогдож үүссэн гүн цэнхэр нууруудтай. Мөстлөгийн хунх бүхий сүрлэг сайхан уулс оршино. Энэ уулын мөнх цас мөсөн голын адгаас Цагаан гол,

болон Ховд голын эх болох Хотон, Хоргон нууруудыг дамжин урсдаг олон гол горхи эх авч урсана.

Мөстлөгийн хүнх гэдэг нь уулын уруу гулсах хэдэн зуун метр зузаан мөсөнд сийлэгдэн ухагдан үүссэн

эгц хам ханан хажуу эрэг. Нэн ховор амьтдаас ирвэс, халиу, гангар хун, ховор амьтдаас буга, алтайн хойлог, дорнын өрөвтас, хээрийн галуу зэрэг амьтад амьдарна.



1. Нутгийн тахилгатай уул усаа нэрлэ. Нэрийг бичиж ав! Тахих ёслол хэдийд болдог, ямар ямар арга хэмжээ зохиогддогийг ярилц! Уулынхаа тахилгын санг уншиж үзээрэй.
2. Танай аймаг суманд ямар зэрэглэлийн тусгай хамгаалалттай газар хэд бий бэ? Хамгаалалтад авсан шалтгааныг одоогийн байдалтай харьцуулан ярилцаарай. Мөн улсын хамгаалалтад авмаар ямар газар байгааг дурдаж учрыг ярилц.
3. Дархан цаазат газар, Байгалийн цогцолборт газрын болон Байгалийн нөөц газар, Дурсгалт газрын ялгаатай тал ба төстэй тал юу вэ? Хүснэгтийг бөглөөрэй.

| | Ààðóàí öðààçàò ãàçàð | Ààéâàëèéí öîðõïëáíðò ãàçàð | Ààéâàëèéí íºö ãàçàð | Ãóðñâàëðâàçàð |
|--------------|----------------------|----------------------------|---------------------|---------------|
| èæèëë ðèíæ | | | | |
| ÿéâààðàé òàë | | | | |

Байгаль орчныг хамгаалах нь дан ганц улсын төдий биш, дэлхийн хэмжээний, нийт хүн төрөлхтний амин чухал үйлс болоод байна. Дэлхийн Байгаль Хамгаалах Сангаас нэн тэргүүнд хамгаалах шаардлагатай 200 бүс нутгийг зарласны дотор манай орноос хоёр газар багтсан нь Алтай-Соёны бүс нутаг ба Монгол дагуурын бүс нутаг юм.

Алтай-Соёны бүс нь дэлхийд нэн

цэнгэг усны том сан болох Хөвсгөл нур, олон нуурт Дархадын хотгор, онгон зэрлэг байгальтай Улаантайга уул, Тэнгис, Шишгэдийн голын сав газар багтана. Евразийн байгалийн цөм гэж нэрлэгддэг энэ нутгийн байгалийн гоо үзэсгэлэн, онгон зэрлэг байгаль нь түүнийг хамгаалах үндэслэл болдог. Мөн хүн төрөлхтөний соёл иргэншил үүссэн нэгэн голомт болохыг батлах хуучин, дунд, шинэ чулуун зэвсгийн үеийн буурь бууц, дарханы газар, ба-



87 үзүүлэлтэй 200 км²-ийн нутагт Монгол орны нутаг дэвсгэрээс хамрагдсан байдал

ховордсон амьтан ургамалтай, үзэсгэлэнтэй ой хөвч, мөнх цаст сүрлэг уулс, цэнгэг уст нуур гол мөрд, түүхийн нандин дурсгалуудыг агуулсан байгаль түүхийн онцлог нутаг юм. Энэ бүс нутагт манай орны баруун, хойд хэсэгт орших Монгол Алтайн нуруу, Соёны нуруу, Их нууруудын хотгор, дэлхийн

гаж зэвсэг, утга соёлын дурсгал болох олон үеийн хадны сүг зураг бичээс, буган хөшөө, хүн чулуу, булш бунхан, хот суурингийн ором, мөр энэ бүс нутагт их бий.

Монгол дагуурын бүс нутагт манай орны Дорнод хэсгийн хэдэн аймгийн ой модгүй, тэгш тал, намхан гүвээ,

толгод бүхий хээрийн бүсийн нутаг багтана. Ижил төсөөтэй хээрийн бүс болох Хойд, Өмнөд Америк, Дундад Ази, Австралийнхаас ялгаатай нь манай Дорнод монголын тал онгон төрхөө алдаагүй, дэлхийн хэмжээнд нэн ховордсон амьтан ургамал ихтэйгээс гадна цагаан зээрийн гол нутаг болдог.

Энд манай улсын тусгай хамгаалалттай хэд хэдэн газар бий. Эдгээрээс гадна байгаль, түүх, соёлын шинжлэх ухааны онцгой ач холбогдолтой газруудыг Олон улсын хүн ба шим мандлын нөөц газар, дэлхийн байгаль соёлын өвийн жагсаалтанд хамруулж, хамгаалалтыг сайжруулах ажлыг хэрэгжүүлж байна.

Олон улсын хэмжээнд бүртгэгдсэн онцлог газрууд

| | |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| НҮБ-ын Шинжлэх ухаан, боловсрол, соёлын байгууллага (ЮНЕСКО)-ын дэлхийн өвийн ба шим мандлын нөөц газар | Говийн их дархан газар, Богдхан уул, Увс нуурын ай сав |
| Рамсарын конвенц (Олон улсын ач холбогдол бүхий нам гархаг газар, Ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай) | Монгол дагуурын дархан газар, Тэрхийн Цагаан нуур, Өгий болон.govийн нуурууд Орог, Таацын цагаан, Бөөнцагаан, Адгийн цагаан, Хар-Ус, Айраг нуур |
| Зүүн хойд Азийн тогоруу хамгаалах олон улсын сүлжээ | Монгол Дагуурын дархан газар |
| Галуу нугасны овгийн шувуудыг хамгаалах олон улсын сүлжээ | Тэрхийн цагаан нуур, Өгий нуур |



88. ägäyýð çóðàã. Öýðöèéí öäääàí íóóð


33. МОНГОЛ ОРОНД АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ХӨГЖҮҮЛЭХ БОЛОМЖ

Монгол орон байгалийн өвөрмөц онцлог нөхцөлтэй билээ. Жишээлбэл: халуун хуурай уур амьсгалд үүсэх манхат элс нь хойшоо, хүйтэн хөлдүү газрын цэвдэгт хөрс нь урагшаа түрж ороод зэрсөн ийм нутаг Монголоос өөр байхгүй.

Монгол оронд өвөл дэлхийн хойд хагасын агаарын их даралтын төв

олширч байгаа нь дараах З онцлогийг
үзэж танилцах гэсэн хүсэлтэй нь
холбоотой.

Манай орон дэвсгэр нутаг ихтэй орон, хүн ам цөөтэй тэгээд хөдөө нутагт ард түмэн нь бэлчээрийн мал аж ахуй эрхлэн нүүдлийн амьдралтай байдаг зэргээс болоод байгалийн нөхцөл байдал, газарзүйн орчин нь



89 àóáààð çóðàã. Áîðòé-Óýðýèæééí ááéáëëééí öïðåöïëáíð áàçàð áàðü
“íàéàíð ñàðåìà” æñðöë-íñí áàçàð

бүрэлдэн тогтдог учраас тэнгэр цэлмэг байдаг. Монгол оронд жилдээ 256 хоног түүнээс ч олон хоног тэнгэр цэлмэг байдаг. Энэ бүгд нь гадаадын хувьст их сонин санагдлаг.

Монголын тэнгэрт шөнө од тоолж болно гэж гадаадынхан ярьдаг нь нэн үнэн зүйл. Од байтугай сар нарыг цөөхөн олж хардаг үүл манан ихтэй орнуудын хүмүүс үүнийг гайхахаас яахав. Манай оронд жуулчлан ирэгсэд

нэг их бохирдоогүй, бас хүний аж ахуйн үйл ажиллагаанд тэгтлээ нэг их талхлагдаагүй нэрвэгдээгүй онгон байгальтай юм.

Өнөөдөр манай оронд хүний аж ахуйн үйл ажиллагаанд талхлагдаагүй онгоноороо байгаа тайга, ой хөвч, тал хээр, говь цөл нутаг байна.

Байгаль, газарзүйн орчин онгоноороо байна гэдэг нь тэнд байгаа амьтан ургамал нь байгалийн байдлаараа



90 äöääääð çóðää. 1962 lïä áîñäîñíí xèíäèñ öäàäíû õ°ø°°
(Öýíðèé àéíää, Äääääë ñòì, Äöðääííööðí àíðäëð)

байх, ховор амьтан ургамал элбэг байх нөхцөл нь бурдсэн гэсэн үг билээ.

Монголын нутагт зээр, чоно, үнэг, хярс, тарвага, тогоруу, шонхор гэхчлэн амьтад жигүүртнийг хааяагүй үзэж болно. Эдгээр амьтныг үзсэн нэгэн жуулчин: “Монгол орон тэр аяараа амьтны хүрээлэн юм байна” гэж дуу алдсан нь үнэний хувьтай.

Монголын байгаль газарзүйн ийм онцлог, үзэсгэлэн төгс, цэвэр цэнгэг агаар ус, зэрлэг ан амьтан, онгон байгалийг үзэх гэж гадаадын хүмүүс сонирхож ирэх нь ихсэж байна.

Монгол орон байгалийн хувьд ийм онцлогтойгоос гадна түүх соёлын арвин их дурсгалтай. Монгол орноос одоогоос 700 мянган жилийн тэртээ хүн амьдарч байсан буурь бууц олдсон бөгөөд монгол орон нь эзэн Чингисийн өлгий нутаг мөний хувьд түүнтэй холбоотой дурсгалт газрууд олонтой.

Энэ бүгд нь манайд аялал жуулчлал хөгжүүлэх тааламжтай нөхцөл болж байна.

34. ЭКОЛОГИЙН ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

Орчин үед чухал тавигдаж байгаа экологийн хямралын асуудалд агаар мандлын бохирдол, уур амьсгалын өөрчлөлт, озона давхаргын цооролт, усны нөөцийн шавхагдал, усны бохирдол, цөлжилт, ойгүйдэл, байгалийн баялгийн хомсдол, хөрсний бохирдол зэрэг ордог.

Эдгээр асуудлуудаас манай орны хувьд тулгамдаж байгаа зарим экологийн асуудлыг жишээн дээр авч үзье.

Цөлжилт. Хөрс ургамал өөрчлөгдөж тухайн нутаг дэвсгэр цөл болон хувирах үйл явцыг цөлжилт гэнэ. Цөлжсөн газар дээр хөрсний шинж муудаж, ургамал амьтанустаж, хөрсний ус давстай болж, нөхөн сэргээгдэх чадвар алдагдана. Цөлжилт явагдахад нөлөөлөх хүчин зүйлийг байгалийн ба хүний хүчин зүйлийн гаралтай гэж ангилдаг.

Манай орны нутаг дэвсгэрийн 41.3% нь говь цөлийн бүс байхын зэрэгцээ ихэнх нь экологийн хувьд эмзэг, 20 см орчим зузаантай ялзмаг

багатай хөрс нь салхи, усны эвдрэлд өртөх магадлал өндөр байдаг нь цөлжилтөнд нөлөөлж байдаг.

Мал их өссөн нь бэлчээрийн даац хэтэрч, ноолуурын эрэлт зах зээл дээр ихэссэнтэй холбоотой. Ямааны тоо толгой өссөн нь бэлчээрийн чанар муудаж, цөлжилт нүүрлэхэд хүргэжээ.

Цөлжилттэй холбоотойгоор элсний нүүдэл эрчимтэй явагдаж байгаагийн нэг жишээ нь Говь-Алтай аймгийн Хөх морьт, Дорноговь аймгийн Замын-Үүд сумын төвүүд юм. 1960-аад онд эдгээр



91. Эдгээр асуудлуудаас манай орны хувьд тулгамдаж байгаа зарим экологийн асуудлыг жишээн дээр авч үзье.

| Цөлжилтийн хүчин зүйл ба шалтгаан | |
|-------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------|
| Байгалийн хүчин зүйл | Хүний хүчин зүйл (антропоген) |
| Цаг уурын таагүй нөхцөл (удаан хугацааны ган) | Ой модыг огтлох |
| Хөрс давсжих | Бэлчээрийн талхлалт |
| Хөнгөн хөрстэй байх (элсэрхэг, хөнгөн шавранцар хөрс) | Усыг зүй зохисгүй ашиглах, хөрсний усны түвшин доошлох |
| Газрын гүний усны түвшин доошлох | Шороон замыг дураараа гаргах |
| Салхины ба усны элэгдэл | Хагд өвсийг шатаах |
| | Газрыг хэт их хагалах |
| | Малын хэт төвлөрөл |
| | Говийн заг болон модлог, бутлаг ургамлыг ихээр түүж, түлшинд хэрэглэсэн. |



92 äöäààð çóðàã. Ííäééí áîëüí øèðäýñýí ðîõíé

сумуудыг байгуулах үедээ барилга барих элсийг гаднаас зөөж авчирдаг байсан бол өнөөдөр эсрэгээр сумын төвд хуримтлагдсан их элсийг гадагш нь зөөж зайлцуулах ажилд их хөдөлмөр хөрөнгө зардаг болжээ. Замын-Үүдэд элсний нүүдэл жил ирэх тутам нэмэгдэж, элсний талбай 192 га, зузаан нь 10-200 см болж, 2000 оны хавраас эхлэн салхин дээд талын 60 орчим км газарт элсэн бүрхүүл үүсжээ.

Цөлжилтөөс сэргийлэхийн тулд юу хийх вэ? Цөлжилтөөс хамгаалах хамгийн түгээмэл аргуудад бэлчээрийг зохистой ашиглах, ойн зуравс байгуулж, салхины хүчийг сааруулах, хөрсийг хамгаалж ургамалжуулах, хашаажуулж, байшин барилга, цардмал зам байгуулах зэрэг олон ажил орно. Бас том хотуудад өвлүүн цагт замын хальтиргааг арилгах гэж давс асгаж байгаа. Дараа нь давстай ус, шороогоо хажуугийн цэцэрлэг рүү хийдэг. Тэр нь хотын цэцэрлэг дотор хужирмалаа давс үүсгэн цайрч байдаг. Энэ нь цэцэрлэгээ давсжуулах зохисгүй ажил болж байна.

Ойгүйдэл. Ойн баялаг нь уур амьсгалын эрс хэлбэлзлийг зөөлрүүлж, чийгийн хуримтлал хангамжийг сайжруулах, хөрсийг ус салхины



93 äžäýýð çóðàã. Íäðëïäññí ié

элэгдлээс хамгаалах, голын усны түвшин гадаргын урсацыг тохируулах зэргээр хүрээлж байгаа орчноо хамгаалах олон чухал үүргийг гүйцэтгэдэг. Монгол орны ой нь усны горимыг зохицуулах, хөрс, ус хамгаалах ач холбогдолтой боловч сүүлийн жилүүдэд ойн түймэр гарах давтамж ихсэж их хэмжээний ойн талбай түймэрт сүйдсэн, ой модыг хайр гамгүй огтолсноос болж хаврын саруудад агаарын хурайшилт нэмэгдэх, хөрсний элэгдэл, цөлжилтийн талбай нэмэгдэх, усны нөөц хомсдох хандлага ажиглагдаж байна. Тухайлбал Хангайн нуруунаас эх авч.govийн Улаан нуур хүртэл урсдаг байсан Онгийн голын эх орчмын ой модыг хайр гамгүй огтолж, голын хөндийн дагуух нутгаас алт олборлосон зэрэг шалтгаанаас урсац нь тасарч Улаан нуур үндсэндээ ширгэжээ.

Усны хомсдол. Тодорхой нутаг дэвсгэрийн газар доорх усны нөөц багасах буюу гадаргын усны хувьд урсацын хэмжээ улам бүр багасахыг усны хомсдол гэнэ. Энэ нь экологийн таагүй үр дагавар авчирч тэнцвэрийг алдагдуулдаг.

Ойг огтлох, гүний болон гадаргын усыг их хэмжээгээр зохисгүй ашиглах, усыг аж ахуйн үйл ажиллагаанд зохисгүй ашиглах, усыг бохирдуулах зэрэг шалтгаанаас усны хомсдол үүснэ.

Манай ард түмэн эрт дээр үеэс булаг шандны эхийг цэвэр байлгах голын ойр орчим юм угаах, бохироо асгах зэргийг цээрлэж байсан хүмүүжилтэй билээ. Үүнийг хүүхэд залуучууд бид уламжлан авч ажиллах ёстой.

2004 онд тоологдсон гадаргын усны нэгдсэн дүн

| | | |
|------------------------|------------|-----------------------------------|
| Áàäääðääúí óníú íýð | Á¿ö òîí | Øèðäýñýí áîë ìºðöí, íóóðúí òîí |
| Áîë áîðöé | 5153 | 372 |
| Áóëäã, øàíä | 9582 | 1158 |
| Íóóð | 3854 | 573 |

Хатаж ширгэсэн гол горхины тоо Хөвсгөл, Өвөрхангай, Төв, Архангай, Сэлэнгэ, Булган аймагт хамгийн их буюу 33-54 хүрч, Ховд аймагт 8 гол, Баян-Өлгий аймагт 17 гол горхи ширгэжээ. Гүний усны нөөц багассанаас хөрсний гулгалт болон нуралт үсэх аюултай. Усны хомсдолыг багасгахын тулд ой модыг отглохгүй байх, усыг зүй зохицой ашиглах шаардлагатай.

Хөрсний эвдэрэл. Хөрсний элэгдэл нь бэлчээрийн талхагдал, ургамлын нэмрөг багасах, ойн талбай багасах зэрэг шалтгаанаас уур амьсгалын хуурайшилт болж, хөрсний элэгдэл явагдаж, уржил шим алдагдана.

Хөрсний эвдрэл ба бохирдол, бэлчээрийн талхагдал, ургамлан нэмрэгийн багасалт, ойн талбайн багасалт, уур амьсгалын хуурайшилт, агротехникийн буруу үйл ажиллагаа, салхины үйл ажиллагаа зэргээс хөрсний үржил шим алдагдахыг хөрсний эвдрэл гэнэ.

Салхиар хөрс элэгдэх үйл явцыг дефляци гэнэ. Ялангуяа шуурга хөрсний дээд үргжил шимтэй хэсгийг хийсгэж хөрсийг эвдрэлд оруулдаг. Иймээс салхины төвүүдийг олж ургамал-жуулах, ойн зурvas байгуулах зэргээр эвдрэлээс хамгаалдаг. Манай орны салхины хүч ихтэй өмнө ба зүүн талын нутгаар салхины элээх хүч их байна. Химийн хорт нэгдлүүд, хог хаягдаас болж хөрсний организмууд мөхөж,

хөрсний өөрийгөө цэвэршүүлэх чадвар алдагдахыг **хөрсний бохирдол** гэнэ. Жишээ нь: Улаанбаатар хотод жилд 223 мянган тонн хатуу хог хаягдал хөрсийг бохирдуулж байна. Хөрсний бохирдол төвлөрсөн суурин газруудаар их байна.

Хог хаягдал. Хотжилт төвлөрөлт ихэссэнээс хог хаягдлыг зайлцуулах асуудал хүндрэлтэй боллоо.

Хог хаягдал нь хөрсийг бохирдуулахаас гадна агаарыг бохирдуулж, хүний эрүүл мэндэд муугаар нөлөөлдөг. Жишээ нь: УБ хотод жилд 500000 шоо метр хог хаягдаж, Дарь эхийн овоо, Улаанчлуут, Мориндаваа зэрэг 3 цэгт нийт хогийн 90% нь хуримтлагддаг. УБ хотын хогийн цэгийн байрлал салхин талдаа буруу байрлалтай байгаа нь хүн амын эрүүл мэндэд муугаар нөлөөлдөг. Хогийн цэг зөв байрлуулах, хогийг цуглуулах, хоггүй болгох, дахин боловсруулах ажил хийх шаардлагатай.

Хотжилт, хүн ам хэт ихээр төвлөрсөн газруудад хотжилттой уялдан хотжилтын өвчин үүсдэг байна. Үүнд:

1. *Шуугианаас үүсэх өвчин.* Хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй дуу шуугианд тээврийн хэрэгслэл (автомашин, агаарын болон төмөр замын тээврийн хэрэгслэл), аж үйлдвэрийн явцад гарах дуу чимээ багтана. Шуугианы гол үүсвэр нь авто тээврийн хэрэгслэлүүд (нийт дуу шуугианы 80 хувь) юм. Шуугианы өвчин дуу шуугиан ихтэй газар үүсдэг ба сонсголын эрхтэн

болов чихэнд гол төлөв өөрчлөлт оруулдаг.

2. *Хотын бүсийн тоосжилтоос үүсэх өвчин.* Хотын бүсийн тоосжилт их байдгаас шалгаалан хотын хүн ам ялангуяа үйлдвэр, дулааны цахилгаан станцын ажилтнууд тоосноос үүсэх ушигны өвчинөөр их өвчилдөг.

3. *Зүрх-судасны тогтолцооны өвчлөл нь хотын хүн амын дунд маш өргөн тархсан өвчлөл юм.* Өндөр хөгжилтэй орнуудад энэ өвчин хүн амын үхлийн 50 гаруй хувь, өвчлөлийн 30%-ийг эзэлдэг. Энэ өвчинөөр 30-49 наасны хүмүүс өвчлөх нь элбэг байна.

4. *Амьсгалын замын хэлбэртэй шинэ төрлийн хорт хавдрын өвчний өсөлт хотын хүн амын дунд өндөр давтамжтай байдаг.* Энэ өвчин нь ихэнхдээ хотын хүн ам ялангуяа тамхичдад тусч байна. Амьсгалын замын хэлбэртэй хорт хавдрын өсөлтийг хотын агаарын бохирдол, гэр тасалгааны агаарт байдаг тоос, тамхины утаа, бактер, мөөгөнцөр, хоол бэлтгэх, хийхэд гардаг янз бүрийн үнэр зэрэг нь химиин хорт бодисын агууламж, төрлийг олшуулдагтай холбож үздэг.

ӦААՆДАӨӨОÄ

1. Аймгийн төв, хотуудын газарзүйн байрлал, уур амьсгалын зарим үзүүлэлт

| Нэрс | Орших өндөр д.т.д. м | Газарзүйн солбицол | | Жилийн дундаж | | |
|---------------|-------------------------------|--------------------|----------|----------------------------------|--------------------------|-------------------------|
| | | Х.Ө. | З.У | Агаарын температуру градус | Агаарын тунадас мм | Салхины хурд, м/с |
| Цэцэрлэг | 1691 | 47°28' | 101°27' | -0,1 | 337,8 | 2,5 |
| Өлгий | 1710 | 48°58' | 89° 59' | -0,2 | 113,5 | 2,7 |
| Баянхонгор | 1859 | 46°11' | 100°43' | -0,5 | 206,7 | 2,9 |
| Булган | 1208 | 48°48' | 103°32' | -1,5 | 327,7 | 2,1 |
| Алтай | 2181 | 46°22' | 96°016' | -1,5 | 171,2 | 3,4 |
| Сайншанд | 938 | 44°54' | 110°08' | 3,5 | 115,9 | 4,5 |
| Чойбалсан | 747 | 48°04' | 114°30' | 0,5 | 250,6 | 3,6 |
| Мандалговь | 1393 | 45°46' | 106°17' | 1,0 | 159,7 | 4,4 |
| Улиастай | 1760 | 47°44' | 96° 50' | -2,8 | 219,1 | 1,7 |
| Арвайхээр | 1913 | 46°16' | 102°47' | 0,8 | 247,2 | 3,8 |
| Даланзадгад | 1465 | 43°34' | 104°026' | 4,0 | 129,5 | 4,0 |
| Баруун - Ургт | 981 | 46°41' | 113°17' | 0,6 | 203,7 | 2,2 |
| Сүхбаатар | 626 | 50°14' | 106°12' | -0,2 | 283,8 | 2,2 |
| Зуунмод | 1529 | 47°42' | 106°56' | 1,7 | 282,5 | 2,5 |
| Улаангом | 939 | 49°59' | 92°04' | -3,7 | 138,8 | 1,4 |
| Ховд | 1406 | 48°00' | 91°38' | -0,3 | 125,9 | 1,6 |
| Мөрөн | 1283 | 49°38' | 100°10' | -1,8 | 232,5 | 2,0 |
| Өндөрхаан | 1027 | 47°19' | 110°40' | -0,8 | 255,7 | 3,6 |
| Дархан | 850 | 49°26' | 105°56' | -0,6 | 306 | 1,7 |
| Улаанбаатар | 1351 | 47°55' | 106°55' | -2,4 | 237,5 | 2,2 |
| Чойр | 1200 | 46°21' | 108°23' | +0,3 | 200 | 0,2 |
| Эрдэнэт | 1300 | 49°03' | 104°05' | 0,0 | 396,8 | 2 |
| | | | | | | |

“Г.Намхайжанцан. Барилгад хэрэглэх уур амьсгалын ба геофизикийн үзүүлэлт, УБ., 1994 он” номоос авав.

2. Óëñûí ãàçðûí íýääìýë ñàíãèéí á¿òýö

| Газрын ангилал | Талбай ам км | Эзлэх жин % |
|---------------------------------|--------------|-------------|
| 1. Улсын нутгийн хэмжээ | 1564116 | 100 |
| 2. Хөдөө аж ахуйн газар эдэлбэр | 1288908 | 82.41 |
| 3. Хот, тосгон бусад суурингийн | 5236 | 0.33 |
| 4. Зам шугам сүлжээний | 1999 | 0.13 |
| 5. Ойн сан бүхий газар | 178520 | 11.41 |
| 6. Усан сан бүхий газар | 16773 | 1.07 |
| 7. Улсын нөөц газар | 72680 | 4.65 |

3. Томоохон гол мөрд

| Голын нэр | Үргт, км | Үс цуглуулах талбай, ам км |
|-----------------------------------|----------|----------------------------|
| Хойд мөсөн далайн ай сав | | |
| Орхон | 1124 | 133000 |
| Туул | 819 | 53200 |
| Сэлэнгэ | 593 | 282000 |
| Эг | 475 | 40500 |
| Идэр | 452 | 24600 |
| Дэлгэр мөрөн | 445 | 26700 |
| Ерөө | 328 | 11800 |
| Шишгэд | 298 | 18300 |
| Чулут | 415 | 10750 |
| Хануй | 421 | 14620 |
| Номхон далайн ай сав | | |
| Хэрлэн | 1090 | 116500 |
| Улз | 420 | 27500 |
| Онон | 296 | 40200 |
| Халхын гол | 233 | 17200 |
| Төв Азийн гадагш урсгалгүй ай сав | | |
| Завхан | 808 | 71200 |
| Ховд | 516 | 58000 |
| Онги | 435 | 53000 |
| Тэс | 568 | 33400 |
| Байдраг | 310 | 28300 |
| Булган | 250 | 8750 |
| Таац | 200 | 9190 |
| Хүнгий | 196 | 21693 |
| Бодонч | 180 | |
| Үенч | 105 | |

4. Томоохон нуурууд

| Нуурууд | Талбай ам км | Хамгийн гүн м |
|----------------------------|--------------|---------------|
| Увс | 3350 | 22 |
| Хөвсгөл | 2760 | 262.4 |
| Хар-Ус | 1852 | 4.4 |
| Хяргас | 1407 | 80 |
| Буйр | 615 | 50 |
| Хар | 575 | 7 |
| Дөргөн | 305 | 27 |
| Ачит | 297 | 5 |
| Бөөнцагаан | 252 | 15 |
| Үүрэг | 238 | 42 |
| Тэлмэн | 194 | 27 |
| Сангийн далай /Хөвсгөлийн/ | 165 | 30 |
| Айраг | 143 | 10 |
| Орог | 140 | 5 |

5. Томоохон рашаанууд

| Рашаан | Аймаг, сум |
|--------------------|--------------------------|
| 1. Халзан уул | Дорноговь, Даланжаргалан |
| 2. Отгонтэнгэр | Завхан. Улиастай |
| 3. Ерөө | Сэлэнгэ. Ерөө |
| 4. Аварга | Хэнтий. Дэлгэрхаан |
| 5. Тосон нуур | Хэнтий. Дэлгэрхаан |
| 6. Улаанбаатар | Улаанбаатар |
| 7. Аржанчивлан | Налайх |
| 8. Хужирт | Өвөрхангай. Хужирт |
| 9. Шаргалжуут | Баянхонгор. Эрдэнэцогт |
| 10. Утаат минчүүр | Дорнод. Чойбалсан |
| 11. Могойт | Өвөрхангай. Бат-Өлзийт |
| 12. Их цайдам нуур | Төв. Баян |
| 13. Гурван нуур | Хэнтий. Дадал |
| 14. Үүдийн нуур | Баянхонгор. Баян-Овоо |
| 15. Их төхөм нуур | Төв. Бүрэн |
| 16. Жанчивлан | Төв. Эрдэнэ |
| 17. Цэнхэр | Архангай. Цэнхэр |

6. Òðãýýìýë òàðõñàí óðãàìàë

Говийн ба цөлийн бүс

Монгол өвс, хазааргана, ширэг, багалуур, тэсги, бор шаваг, таана, бор бударгана, бөөрөлзгөнө, хотир, шар шаваг, харгана, хар суль, цагаан суль, заг, цульхир, хайлас, улаан бударгана, хармаг, шар бударгана, боролзой, бажууна, бэрээмэг, тоорой, бургас, жигд, шагшуурга.

Хээрийн бүс

Хялгана, ерхөг, дэрс, бударгана, лууль, агь, харгана, тавилгана, яргай, бүйлс, тогторгоно, хазааргана.

Ойт хээрийн бүс

Ойн ургамал - Шинэс, нарс, хус, улиас, үхрийн нүд, улаагана, гүйлс, бургас, нохойн хошуу, гүзээлзгэнэ, алирас, ботуул, даагансүүл, биелэг, ерхөг, навтуул, ганга, далантуруү, хялгана.

Тайгын ургамал - Бадаан, нэрс, сургар, хад, гачуур, хуш, арц, хөвд

Тагийн ургамал - Биелэг, мэхээр, дэгд, бургас, шивэл, арц, даланхальс, хаг, бушилз, зожиргоно.

7. Ховор ан амътад

| Монгол улсын Засгийн газрын 2001 оны 1 хавсралт | | 264-р тогтоолын |
|----------------------------------------------------|---------------------|-------------------|
| Нэг. Хөхтөн | Хоёр. Шувуу | 15. Хар өрөвтас |
| 1. Аргаль | 1. Алтайн хойлог | 16. Хонин тоодог |
| 2. Янгир | 2. Манхин галуу | 17. Азийн цуучил |
| 3. Хулан | 3. Хээрийн галуу | 18. Хилэн жигүүрт |
| 4. Хар сүүлт | 4. Хошуу галуу | 19. Эгэл хүрзгэнэ |
| 5. Халиун буга | 5. Хуруут хүн | 20. Цагаан шонхор |
| 6. Ойн булга | 6. Гунгар хүн | 21. Амарын шонхор |
| 7. Зэгсний гахай | 7. Байгалийн нугас | 22. Одой галуу |
| 8. Говийн шилүүс | 8. Ухаа шумбуур | |
| 9. Хадны суусар | 9. Халzan ангир | Гурав. Загас |
| 10. Цоохондой | 10. Ямаан сүүлт | 1. Цагаан амар |
| 11. Эрээн хүрэн | 11. Усны бух шувуу | 2. Давх |
| 12. Гозоорой зурам | 12. Цасч дэглий | |
| | 13. Халбаган хушуут | |
| | 14. Дорнын өрөвтас | |

8. Өмнөдий 33 аяаү1

| 1. Тусгай хамгаалалттай газрын хил дотор оршдог говиуд | | | |
|---------------------------------------------------------------|------------------------------------|----------------------------------|------------------------------|
| Говийн их дархан газарт: | | Байгалийн нөөц газарт: | |
| 1. Номингийн | Говь-Алтай-Алтай | 21. Шаргын | Говь-Алтай-Шарга |
| 2. Шаралдайн | Говь-Алтай-Алтай | 22. Манханы тал | Ховд- Манхан |
| 3. Загтсайрын | Говь-Алтай-Алтай | 23. Загийн усны хоолойн | Дундговь-Өлзийт |
| 4. Зүүнгэрийн | Говь-Алтай-Алтай | 24. Модон овооны | Дундговь-Өлзийт |
| 5. Отгоны | Говь-Алтай-Алтай | 2. Бусад томоохон говиуд. | |
| 6. Харсайрын | Говь-Алтай-Цогт | 25. Зулганайн | Өмнөговь-Гурвантэс |
| 7. Талын | Говь-Алтай-Алтай, Цогт | 26. Гурилын | Өмнөговь-Гурвантэс |
| 8. Шалын | Говь-Алтай-Цогт, Эрдэнэ | 27. Заг, Сүүжийн | Өмнөговь-Номгон |
| 9. Нарансэвстийн | Говь-Алтай-Цогт, Эрдэнэ | 28. Борзонгийн | Өмнөговь-Номгон, Баян-Овоо |
| 10. Нарийн хөх | Баянхонгор-Баян Өндөр | 29. Захуй-Зармангийн | Говь-Алтай-Эрдэнэ, Цогт |
| 11. Ингэнэхөөвөрийн | Баянхонгор-Шинэжинст, ӨМ-Гурвантэс | 30. Улаан шалын | Баянхонгор |
| 12. Цэнхэрхоолойн | Баянхонгор-Баян Өндөр | 31. Хүйсийн | Говь-Алтай |
| 13. Ланзатын | Баянхонгор-Баян Өндөр | 32. Долоодын | Говь-Алтай-Хөхморьт |
| 14. Борцонжийн | Ховд-Булган, Алтай, Үенч | 33. Өөшийн | Дорноговь-Өргөн |
| 15. Давсанхуурайн | Ховд-Булган, Үенч | | Сүхбаатар-Халзан, Баяндэлгэр |
| 16. Хонин усны | Ховд-Алтай, Үенч | говиуд болно. | |
| 17. Ёлхоны | Ховд--Алтай, Үенч | | |
| Говийн бага дархан газарт: | | | |
| 18. Зээмэгийн | ӨМ-Баян-Овоо, Номгон | | |
| 19. Галбын | ӨМ-Ханбогд | | |
| 20. Хармагтайн | ДО-Хатанбулаг | | |

9. Томоохон манхан элс

| Элсний нэр | Талбай ам км | Орших аймаг, сум |
|----------------------------------------|--------------|-----------------------------------------------|
| 1. Бөөрөг (Алтан элсний хамт) | 4000 | Увс-Зүүнговь, Баруунтуруун |
| 2. Монгол элс | 2700 | Завхан-Дөрвөлжин, Говь-Алтай. Хөхморьт |
| 3. Бор хар | 2500 | Завхан - Ургамал, Завханмандал, Сантмаргац |
| 4. Бага бууралын элс /Арзагийн/ | 1616 | Увс - Завхан |
| 5. Далайн элс Аргалантын Улаан | 1216 | Дорноговь - Эрдэнэ |
| 6. Багануурын элс | 1200 | Завхан.Дөрвөлжин, Говь-Алтай - Хөхморьт |
| 7. Гөлөөн манхны | 1000 | Дорноговь - Хөвсгөл |
| 8. Хонгор элс (Төхөмийн элсний хамт) | 925 | Өмнөговь - Сэврээ, Баяндалай |
| 9. Богдын голын элс | 847 | Завхан - Алдархаан, Цагаанхайрхан |
| 10. Халзангийн | 714 | Өмнөговь - Булган |
| 11. Борзонгийн | 700 | Өмнөговь - Номгон |
| 12. Жарангийн Зэгст, Дунд, Зүүн элс | 650 | Өмнөговь - Ноён, Сэврээ, Гурвантэс |
| 13. Айраг нуурын | 644 | Увс-Завхан |
| 14. Баян нуруу, Гашууны элсэн усны элс | 600 | Дорноговь - Хатанбулаг |
| 15. Хар загийн | 493 | Өмнөговь - Булган |
| 16. Хар нуурын | 416 | Завхан - Эрдэнэхайрхан |
| 17. Бүгтийн элс | 400 | Өмнөговь - Баяндалай |
| 18. Харганы | 392 | Увс - Завхан, Ургамал |
| 19. Хулгар, Бүргэдийн | 350 | Дорноговь - Хөвсгөл, Улаанбадрах |
| 20. Цэнхэр хоолойн | 306 | Баянхонгор - Баянхонгор |
| 21. Молцог элс | 248 | Сүхбаатар - Дарьганга |
| 22. Галуутын | 216 | Завхан - Цэцэн-Уул |

10. Мөнх цаст оргилууд

| Уулын нэр | Өндөр д.т.дм | |
|-------------------------|--------------|---------------------------------------------------------|
| 1. Хүйтэн | 4374 | Баян-Өлгий - Цэнгэл |
| 2. Мөнххайрхан | 4204 | Ховд - Мөнххайрхан |
| 3. Цаст | 4193 | Баян-Өлгий - Алтанцөгц, Баяннуур |
| 4. Цамбагарав | 4165 | Ховд - Эрдэнэбүрэн, Баян-Өлгий - Баяннуур, Алтанцөгц |
| 5. Сутай | 4090 | Ховд - Цэцэг, Дарви, Говь-Алтай - Тонхил, Дарви |
| 6. Таванбогд | 4082 | Баян-Өлгий - Цэнгэл, Улаанхус |
| 7. Бугат | 4047 | Ховд - Мөнххайрхан, Баян-Өлгий - Булган |
| 8. Хархираа | 4032 | Увс - Тариалан, Ховд |
| 9. Ихтүргэн | 4029 | Баян-Өлгий - Ногооннуур |
| 10. Отгонтэнгэр | 4021 | Завхан - Отгон, Улиастай |
| 11. Баатархайрхан | 3984 | Ховд - Зэрэг, Мөст |
| 12. Сайр уул | 3984 | Баян-Өлгий - Толбо |
| 13. Түргэн | 3964 | Увс - Бөхмөрөн, Тариалан |
| 14. Цэнгэлхайрхан | 3943 | Баян-Өлгий - Улаанхус |
| 15. Өндөрхайрхан | 3914 | Баян-Өлгий - Улаанхус |
| 16. Самартай | 3900 | Баян-Өлгий - Цэнгэл |
| 17. Асгат | 3795 | Баян-Өлгий - Ногооннуур |
| 18. Мөнхцаст | 3918 | Баян-Өлгий - Ногооннуур |
| 19. Цагаан уул | 3752 | Баян-Өлгий - Алтай |
| 20. Цаст уул | 3669 | Баян-Өлгий - Цэнгэл |
| 21. Рашааны уул | 3668 | Баян-Өлгий - Цэнгэл |
| 22. Дөш | 3876 | Баян-Өлгий - Дэлүүн |
| 23. Цагаанхайрхан | 3628 | Баян-Өлгий - Цэнгэл |
| 24. Дөнгөрөхийн Барзгар | 3669 | Баян-Өлгий - Цэнгэл |
| 25. Хөхсайн уул | 3574 | Баян-Өлгий - Буянт, Алтай |
| 26. Мөнхсарьдаг | 3491 | Хөвсгөл - Ханх |